

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-58

1.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	4-30
2.Малын генетик нөөцийн төлөв байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох	31-58
3.2025 оны хаврын мал төллөлтийн дүн, мэдээний талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох	58

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
05 дугаар сарын 28-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 21 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Мөнхбат, А.Ундраа, Ж.Чинбүрэн;
Чөлөөтэй: Ж.Бат-Эрдэнэ, С.Лүндэг, З.Мэндсайхан;
Эмнэлгийн чөлөөтэй: П.Батчимэг.

Нэг.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Г.Энхмөнх, мөн газрын ахлах шинжээч Ө.Мөнхбаяр, Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч С.Эрдэнэцэцэг, хуульч П.Бүнчинжав, М.Энхмэнд, судлаач И.Бямбахүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, Н.Наранбаатар, Б.Уянга, Б.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, Ц.Идэрбат, Л.Мөнхбаясгалан, Ж.Батжаргал, Г.Ганбаатар нарын тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Г.Энхмөнх, мөн газрын ахлах шинжээч Ө.Мөнхбаяр, хуульч П.Бүнчинжав, М.Энхмэнд, судлаач И.Бямбахүү нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, С.Замира, Р.Сэддорж, У.Отгонбаяр, Б.Бейсен нар үг хэлэв.

Б.Бейсен: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Татгалзсан: 13
Бүгд: 17
23.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Г.Ганбаатар нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 35.3 хувийн саналаар дэмжээгүйд тооцов.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Замира Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 09 минутад хэлэлцэж дуусав

Хоёр.Малын генетик нөөцийн төлөв байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Мал аж ахуйн хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Мөнхнасан, Малын нөөцийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Цогтбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Малын генетик нөөцийн төлөв байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Ц.Идэрбат, У.Отгонбаяр, Ж.Батжаргал, М.Бадамсүрэн, М.Мандхай, С.Замира, Р.Сэддорж, Б.Бейсен нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Мал аж ахуйн хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Мөнхнасан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, М.Мандхай, С.Замира, Р.Сэддорж, Ж.Батжаргал, М.Бадамсүрэн, Ж.Энхбаяр нар үг хэлэв.

Байнгын хорооны дарга Б.Бейсен мэдээлэл сонссонтой холбогдуулан “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Бейсен: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17

64.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүд Малын генетик нөөцийн төлөв байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 19 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.2025 оны хаврын мал төллөлтийн дүн, мэдээний талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Мал аж ахуйн хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Мөнхнасан, Малын нөөцийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Цогтбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

2025 оны хаврын мал төллөлтийн дүн, мэдээний талаарх мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр өмнөх буюу 2 дугаар асуудалтай хамтатган танилцуулсан болно.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүд 2025 оны хаврын мал төллөлтийн дүн, мэдээний талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 19 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 41 минут үргэлжилж, 24 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 70.8 хувийн ирцтэйгээр 19 цаг 02 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
15 цаг 21 минут.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Эрхэм гишүүдэд энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц 58,3 хувьтай бүрдсэн тул БОХХАА-н байнгын хорооны 25 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Хуралдааны ирцийг танилцуулъя. Буланы Бейсен 3 дугаар тойрог ирсэн байна, Очирбатын Амгаланбаатар 2 дугаар тойрог ирсэн байна, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ 4 дүгээр тойрог ирсэн байна, Пүрэвийн Батчимэг өвчтэй, Сайнхүүгийн Ганбаатар гишүүн 1 дүгээр тойрог ирсэн байна, Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн 6 дугаар тойрог ирсэн байна, Сонгобайн Замира жагсаалтаар ирсэн байна, Цагаанхүүгийн Идэрбат 6 дугаар тойрог ирсэн байна, Мэндбаярын Мандхай гишүүн жагсаалтаар ирсэн байна, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн 7 дугаар тойрог ирсэн байна, Бадрахын Найдалаа жагсаалтаар ирсэн байна, Нанзадын Наранбаатар 7 дугаар тойрог ирсэн байна, Ухнаагийн Отгонбаяр 6 дугаар тойрог ирсэн байна, Ренчинбямбын Сэддорж 7 дугаар тойрог ирсэн байна, Болдын Уянга жагсаалтаар ирсэн байна.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 3 асуудал хэлэлцэнэ. 1 дүгээрт Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, ЗГ-ын 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь асуудал Малын генетик нөөцийн төлөв байдал, цаашид авах, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ХХААХҮ-ийн сайдын мэдээллийг сонсох, 3 дахь нь 2025 оны хаврын мал төлөлтийн дүн мэдээний талаар ХХААХҮ-ийн сайдын мэдээллийг сонсох ийм 3 асуудал хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу? Санал байхгүй байна.

Нэг.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэх асуудалд оръё. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ЗГ-ын 2025 оны 5 сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн энэ хуулийн хэлэлцэх эсэхийг хэлэлцье. Хууль санаачлагчийн танилцуулгыг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Одонтуяа танилцуулна. Одонтуяа сайд.

С.Одонтуяа: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор батлагдсан ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулж, бизнес дэх байгаль орчны үнэлгээний ангиллыг цөөрүүлж, төрийн оролцоог бууруулна гэсэн зорилтыг үндэслэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль нь 1998

онд батлагдаж, 2012 онд шинэчилсэн найруулга хийгдэж, 6 удаа нэмэлт, өөрчлөлт хийгдсэн бөгөөд өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд хуулийн зарим зүйл, заалт хоорондоо зөрчилдөх, зохицуулалтын хувьд давхцах, тодорхой бус хоёрдмол утга илэрхийлэх, төсөл хэрэгжүүлэгчид эдийн засгийн болоод цаг хугацааны хүндрэл учруулах зэрэг асуудал гарч байгаа тул эдгээр асуудлыг эрх зүйн зохицуулалтын хувьд сайжруулан зохицуулах зайлшгүй шаардлагатай байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланд төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн Нийтийн Хурлын санал, тэмдэглэл гэж заасныг хэрэгжүүлэхэд олон талын хүндрэл гарч, хоног хугацаа алдаж, шаардлагатай төслүүд явахгүй гацдаг, байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний төслийн ангиллыг хуулийн хавсралтаар хатуу тогтоосноор тухайн төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, цар хүрээ, төрөл, төсөл хэрэгжих газар нутгийн байршил, хүчин чадлыг харгалзан үзэх боломжгүй, мөн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд нийгмийн нөлөөллийн үнэлгээ, уур амьсгалын өөрчлөлт, олон улсын банк, санхүүгийн байгууллагын стандартыг хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн тусгах хэрэгцээ шаардлагатай зэрэг нөхцөлийг тогтоосон.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр гарсан нөхцөл байдлыг хянан үзээд зарим шаардлага тодорхойгүй, бичиг баримтын бүрдлийн ангилал ойлгомжгүй, давхацсан шинжтэй, үүрэг хариуцлагын зохицуулалт тусгагдаагүйн улмаас хууль хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэлийг арилгах үүднээс Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн эх бичвэрт 20 хэсэг, 5 заалтыг нэмж тусган, 11 хэсэг, 4 заалтыг өөрчлөн найруулж нийт хуулийн 44 заалт буюу 32,8 хувьд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсрууллаа. Мөн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлын хүрээнд холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, олон улсын байгууллагууд, төсөл хэрэгжүүлэгч ААН-үүд, салбарын судлаачдын төлөөллийг оролцуулан 3 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан саналыг нэгтгэн тусгаж ажиллалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар 1.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилт сайжирч, төсөл хэрэгжүүлэгч, хөрөнгө оруулагч нарт учирч байсан цаг хугацаа алдах, бичиг баримтын бүрдэл хангах, хүлээх, төрийн байгууллага хооронд явах, олон нийтийн оролцооны асуудлаас болж төслийн хэрэгжилт гацах, санхүүгийн алдагдал хүлээх зэрэг асуудлыг цогцоор нь шийдэх эрх зүйн орчин бүрдэнэ. Тухайлбал ерөнхий үнэлгээний түвшинд Засаг даргын санал өгөх хугацаа олон төрлийн бичиг баримтад шаардаж цаг авдаг асуудал нарийвчилсан үнэлгээний түвшинд улиралд нэг удаа хуралддаг иргэдийн Нийтийн Хурлын хугацаа, хуралд оролцогчдоос дэмжихгүй байгаа талаар гаргасан тогтоолоос шалтгаалан төсөл хэрэгжиж чадахгүй байх зэрэг асуудлыг шийдвэрлэж, одоогийн нөхцөл байдлаар хамгийн доод тал нь 150 хоногт шийдвэрлэгдэж байсан хугацааг 3 дахин буурууллаа. 2.Асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байгаль орчны үнэлгээтэй холбоотой төрийн үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй хүргэх, цахим хэлбэрээр ажиллах, мэргэшсэн мэргэжилтэн ажиллуулах, ангиллыг сайжруулах замаар төвлөрлийг сааруулах, оролцогч талуудын ажлын уялдаа холбоо сайжрах нөхцөл бүрдэнэ. 3.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний шинэчилсэн ангиллаар нийт төслийн 38 хувь нь ангилал буурч, байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт хийлгэх болон шалгах хуудсаар бүртгүүлэх боломжтой болно. Мөн аймаг нийслэлийн түвшинд хийгдэж байгаа

нөхцөл болзолтой хийсэн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийн 30 хувь нь шалгах хуудсаар бүртгүүлж үнэлгээ шаардахгүй. 4.Байгаль орчны үнэлгээний цахим шилжилт болон мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай нийцүүлнэ. 5.Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэдийн мэдэх эрхийг хангахтай холбоотой зохицуулалтыг тусгасан.

Иймд хуулийн төслийн үзэл баримтлалын дагуу Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Бейсен: Одонтуяа сайдад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан ирсэн ажлын хэсгийн танилцуулъя. Салдангийн Одонтуяа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Г.Энхмөнх ажлын хэсгийн ахлагч, Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Ц.Эрдэнэцэцэг Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Байгаль орчны нэгдсэн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч, Ө.Мөнхцэцэг, Мөнхбаяр Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын Орчны бохирдлын бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч, Энхмэнд хуульч, ажлын хэсгийн гишүүн, П.Бүнчинжав хуульч, ажлын хэсгийн гишүүн, И.Бямбаахүү судлаач, доктор. Хууль санаачлагчийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу, нэрсээ өгнө үү? Мандхай гишүүнээр тасалъя, Батжаргал гишүүнээр тасалъя. Мандхай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Нөлөөллийн ангиллын шинэчлэл гэж байгаа. Энэ санал дээр 3.1.4 дэх хэсэг дээр төсөл гэсэн тодорхойлолтыг илүү нарийвчилж, ангиллын энэ шалгуур босго үзүүлэлтүүдийг тодорхой болгох шаардлага байгаа. Яагаад гэхлээр одоогийн байдлаар төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн өөрөө анги ерөнхий, нарийвчилсан гээд ялгал тодорхойгүй, олон нийтийн ийм хүлээлт үүсгэдэг учраас энэ дээр ийм саналтай байна. Шинээр нэг бүлэг болгон нэмэх эсвэл энэ олон нийтийн оролцоон дээрээ илүү дэлгэрэнгүй болгож оруулах боломжтой юу гэж асуумаар байна? Төслийн мэдээллийг илүү олон нийтэд урьдчилан ил тод хүргэх үүргийг бас тусгах. Тэгээд орон нутгийн иргэд, төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын энэ саналыг тусгах журам мөн санал авч танилцуулах хугацааны доод босгыг ядаж жишээ нь 15-аас 30 хоног ч гэдэг юм уу, яагаад гэхлээр байгаль орчны үнэлгээний энэ шударга, хариуцлагатай байдалд олон нийтийн хяналт их чухал үүрэгтэй байдаг. Ялангуяа томоохон төслүүдийн хувьд бол.

Энэ байгаль орчны үнэлгээний тайлангийн энэ баталгаажуулалтыг илүү мэргэжлийн зөвлөл хариуцах, ялангуяа тайлангийн худлаа мэдээлэл өгсөн тохиолдолд оноох энэ хариуцлага, магадгүй жишээлбэл эрүүгийн юм уу, захиргааны хариуцлагын механизмыг тусгах боломжтой юу? Хяналт шалгалтыг илүү тэр орон нутагт нь тэр төвлөрлөөс сааруулж, орон нутагт нь байлгах тэр бүтэцтэй байлгах талаарх энэ асуудлыг энэ хуульдаа тусгаж өгсөн үү гэж асуумаар байна. Мөн одоо бол яг яаж байгаа гэхлээр байгаль орчин энэ нөлөөллийн үнэлгээ нийгмийн ерөөсөө үнэлгээ хийгддэггүй. Гэтэл яадаг вэ гэхлээр аж ахуйн нэгж, байгууллага очоод үйл ажиллагаа явуулъя гэхлээр байгаль орчин үнэлгээнийхээ тайланг гаргаж авчхаад, нийгэмд үзүүлэх нөлөөллөө хийдэггүйгээс болоод эргээд тэнд нь орон нутгийн иргэд ч гэдэг юм уу, нөлөөлж байгаа тэр оршин суугчдын асуудал хөндөгддөг. Тэгээд энэнээс гарч байгаа, үүсэж байгаа хохирол ерөөсөө шийдэгдэхгүй явсаар ирсэн. Яагаад гэхлээр энэ чинь өөрөө хуульдаа нийгмийн асуудал дээр санал авах гэдэг,

оролцоог хангах гэдэг асуудал өөрөө тодорхойгүй явж ирсэн учраас. Тэгэхээр энэ дээр ямар зохицуулалтыг оруулж өгч байгаа вэ? Нийгмийн үнэлгээ хийгдэх асуудлыг оруулж өгч байгаа юм болов уу гэдэг асуултыг тавимаар байна.

Б.Бейсен: Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Мандхай гишүүний асуултад хариулъя. Дараа нь манай шинжээчид яамныхан нэмж хариулаарай. 1 дүгээрт энэ нийгмийн нөлөөллийн үнэлгээ гээд маш чухал асуудлыг хөндлөө. Ер нь бид энэ өмнөх үнэлгээ дээр голцуу байгаль орчны үнэлгээ гэж их яриад байдаг байсан. Амьтанд нь яаж нөлөөлөх юм, уур амьсгалд нь яаж нөлөөлөх юм гэхээс тухайн төсөл хэрэгжсэнээр тухайн амьдарч байгаа иргэд ямар нөлөөлөлд өртөх юм бэ гэдгийг бол төдийлөн их авч үздэггүй байсан. Ялангуяа сая Эгийн гол дээр бид очиход тэр иргэд энэ нөлөөллийн үнэлгээг хамтдаа хийе. Энд нүүлгэн шилжүүлэлтээс эхлээд л хүүхдүүдийн сургууль, цэцэрлэг бүх ийм нийгмийн үнэлгээг онцгой анхаарч үзэх шаардлагатай гэсэн. Тийм учраас ер нь энэ хуульд энэ нийгмийн нөлөөллийн үнэлгээг нарийвчилж тусгасан байгаа. Ер нь олон улсын яг стандартын дагуу бид энийг хийх гэж оролдсон. Тэр хугацаан дээр хэлэлцэх эсэх дэмжигдсэний дараа хугацаа хэтэрхий богино байна энэ дээр байгаль орчны асуудал чухал учраас хугацааг жоохон нэмье гэдэг асуудал хэлэлцэх явцад боломжтой.

Ер нь бид энэ байгаль орчны үнэлгээ хийгдэх гэж байгаа төслүүдийг 3 ангилж байгаа. Зэрэглэлийг нь нарийвчилж байгаа. Жишээлэхэд өмнө нь нэг жижигхэн нэг хүн лаборатори ажиллуулахад эсвэл бүүр том уул уурхайн төсөл хийхэд яг адилхан ийм шаардлага тавьдаг байдаг. Энэ нь маш хүндрэл учруулдаг. Тийм учраас бид ангилж байгаа. Тэгэхээр нэг литр химийн бодис ч оруулж ирсэн, мянган тонн ч байсан энэ бүх юу нь адилхан учраас бид энэ зэрэглэлүүдийг нэлээд сайн тогтоож өгч, энэ зэрэглэлийг яаж шийдэх вэ гэдгийг гаргасан. Жишээлэхэд энэ жижиг 3 дугаар зэрэглэлийн төсөлд хамрагдаж байгаа хүмүүс заавал тусгай зөвшөөрөл хүлээхгүйгээр шууд цахимаар мэдүүлээд ингээд орхиж байгаа. 2 дугаар хэсэг нь аймаг, орон нутаг, нийслэл энэ дээр тодорхой хяналт тавьж, өөрсдөө хэрэгжүүлэх ийм зөвшөөрлийг өгнө. 3 дахь нь яах аргагүй Байгаль орчны яам ингээд хариуцаж байгаа юм. Дээрээс нь энэ Үндсэн хуулийн заагдсан иргэдийн мэдэх эрхийг бид зохицуулж өгч, энэ төсөл хэрэгжих гэж байгаа багийн иргэдэд энэ мэдээллийг сайн өгөхөөр ингэж оруулсан байгаа. Тэгээд мэдээж ингэж цахимжсанаар энэ хүнд суртал 152 хоног болдог байсан энэ хугацааг бол бид багасгаж өгсөн байгаа. Манай хүмүүс нэмээд хариулчих уу 4.

Б.Бейсен: 4 номер нэмж хариулъя.

Г.Энхмөнх: Мандхай гишүүний асуултад хариулъя. Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Энхмөнх. Түрүүнд ангилалтай холбоотой асуудлыг сайд дурдлаа. Мэдээж энэ дээр яг энэ олон улсад тавигдаж байгаа шаардлагын хувьд ABC гээд 1, 2, 3 дугаар зэрэглэл гээд ангилчихсан байж байгаа. Яг энд бид нийцүүлээд үндсэндээ одоогийн байгаа ангилал зэрэглэлийн хувьд төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл гэдэг зөвхөн 2 ангилал байгаад байгаа. Энийг бид хэд үндсэндээ нөлөөллийн зэрэглэлээс нь хамаараад нөлөөллийн зэрэглэл 1, 2, 3 гээд ангилчхаж байгаа юм. Тэгэхлээр нөгөө нөлөөллийн 1 дүгээр зэрэглэлийн хувьд төрийн захиргааны төв байгууллага, 2 дугаар зэрэглэлийн хувьд аймаг, нийслэл, 3 дугаар зэрэглэлийн хувьд зөвхөн бүртгэлжүүлэлтээ хийгээд явна л гэсэн үг.

Хэрвээ бид хэд ингээд энэ нөлөөлөл зэрэглэлийг хийвэл төрийн захиргааны төв байгууллага дээр ирж байгаа ачааллын хувьд 30-аас 40 хувь 2 дугаар зэрэг лүү шилжинэ гэж байгаа юм. Энэ хувиараа тухайн аймаг, нийслэл дээр байгаа нөлөөллийн нийт төслүүдийн хувьд тэр хувиараа зөвхөн бүртгэлээ хийлгээд явах ийм боломж бололцоо бүрдэнэ гэсэн үг. Нөгөө талаасаа.../минут дуусав/

Б.Бейсен: Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Түрүүний нөгөө нийгмийн үнэлгээ хийх заалт нь яг нарийвчилж яаж орсон бэ гэдгийг тодруулаад өгчхөөрэй. Энэ үнэлгээний байгууллагын тэгвэл хараат бус байдлыг ер нь яаж баталгаажуулж байгаа юм бэ? Энэ жишээлбэл энэ ялангуяа энэ жижиг төслүүд дээр үнэлгээний байгууллага яах вэ хувийн аж ахуйн нэгж зөвшөөрөлтэй байгууллагуудаар хийлгэж байгаа. Томоохон компаниудыг жишээлбэл орон нутаг өөрөө байгаль орчны төрийн байгууллага нь өөрөө үнэлгээ хийгээд яваад байгаа. Тэгэхээр энэ дээр ямар асуудал үүсэж байна гэхлээр нөлөөллийн үнэлгээ захиалагчийн даалгавартай явагддаг ийм байдал илт ийм ашиг сонирхлын зөрчилтэй байхаар байгаа тийм ээ? Тэгэхлээр энийг илүү нөгөө хараат бус байлгах, хяналттай байлгах дээр яг ямар заалтууд орж ирсэн бэ гэдэг дээр асуулт юу хариулт авъя.

Б.Бейсен: 4 номерын микрофон хариулъя.

Г.Энхмөнх: Мандхай гишүүний асуултад тодруулга өгье. Энэ тухай хуулийн төслийн 3.1.6 дээр нэр томъёоны тодорхойлолт гээд байж байгаа. Энэ дээр тухайлбал байгаль орчны нөлөөллийн үнэлгээг юу гэж ойлгох вэ гэж байгаа юм. Энд хамрах хүрээн дотор нь бид хэд нийгмийн нөлөөллийн үнэлгээтэй холбоотой асуудлыг хамруулж өгсөн. Нөгөө талаасаа бид хэд энэ асуудлыг журам болоод аргачлалдаа маш тодорхой заагаад оруулчихна. Тухайлбал тухайн төсөл хэрэгжүүлснээр нийгэм талаасаа ямар нөлөө үзүүлэх юм, нүүлгэн шилжүүлэлтээр ямар асуудал үүсэх юм, буцаагаад тэр нөлөөллийн бүсэд байгаа, бүсэд амьдарч байгаа иргэдийн хувь дээр амьжиргаа дээр нь ямар асуудал үүсэх юм гэх мэтчилнээр илүү тодорхой, ойлгомжтой болоод явна. Энэ нөлөөллийн үнэлгээ тодорхой хийгдэхгүйгээс үүсэлтэйгээр буцаагаад тухайн томоохон төсөл гацах, хэрэгжилт удаашрах ийм нөхцөл байдал бий болсон. Тэгээд тухайлбал бид хэд энэ нийгмийн нөлөөллийн үнэлгээтэй холбоо бүхий асуудлаар Дэлхийн банкны 10 стандарт, Азийн хөгжлийн банкны болоод энэ ОУБ-ын тавигдаж байгаа шаардлагуудтай харьцуулсан дүн шинжилгээ.../минут дуусав/

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулъя.

Г.Энхмөнх: Хараат бус асуудал дээр тухайлбал энэ нөлөөллийн бүсэд байгаа иргэдэд хэлэлцүүлгийг зохион байгуулна. Ингэхдээ тухайн мэргэжлийн байгууллага болоод төсөл хэрэгжүүлэгч хамтран тухайн төсөлтэй холбоотой мэдээллээ ил тод, нээлттэй байдлаар танилцуулагдаад явна. Нөгөө талаасаа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас хийж байгаа цахимжуулалттай холбоотой асуудлаар тухайн тайлан өгөхөөс эхлүүлээд төгсгөл хүртэлх энэ процессын асуудлууд бүгд цахимд нээлттэй, ил тод байж байгаа юм. Нөгөө талаасаа энэ хуулийн өөрчлөлтөөр ямар асуудал байна гэхлээр бид хэд энэ тухайн тайланг баталгаажуулж байгаа мэргэжлийн зөвлөлийн 80 хувь нь зөвхөн шинжлэх ухааны болоод холбогдох салбарын эрдэмтэд байна гэсэн ийм шийдлийг оруулаад явж байгаа юм.

Б.Бейсен: Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Байнгын хорооны гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Тэгээд энэ үзэл баримтлалыг нь л харлаа. Үндсэн хуультайгаа зөрчилдчихсэн юм байна. Тэгээд юу нь Үндсэн хуультай зөрчилдчихсэн юм гэхээр зэрэг энэ үзэл баримтлал дээр тодорхой бичсэн байгаа юм. Олон нийтийн оролцооноос хамаараад шалтгаалаад энэ төсөл гацдаг, хугацаа алддаг гэхчихсэн байгаа байхгүй юу. Тэгээд олон нийтийн оролцоо гэдэг чинь нөгөө багийн иргэдийн Нийтийн Хурал, нөгөө багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлээд тэгээд тэмдэглэл авах, санал авах процессоос болоод гацдаг гэж байгаа байхгүй юу. Тэгээд Үндсэн хуульд чинь заачихсан шүү дээ. Тухайн төслийн байгаль орчны үнэлгээг, тухайн байгаль орчинд хэрхэн нөлөөлж байна вэ гэдгийг чинь тэр тухайн багийн, тухайн сумын л иргэд хамгийн сайн мэдэж байгаа шүү дээ. Хүнд нь яаж нөлөөлж байна, ургамал, амьтанд нь яаж нөлөөлж байна, тэр малд нь яаж нөлөөлж байна гэдгийг чинь тухайн оршин суугч орон нутгийнхан л сайн мэдэж байгаа шүү дээ. Тэгээд орон нутгийнх нь саналыг авахгүй ямар үнэлгээ байдаг юм бэ?

Үндсэн хуульд тодорхой заачихсан шүү дээ. Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй гээд заачихсан байгаа шүү дээ. Тэгээд зарим нэг төслүүд байгаль орчныг бохирдуулсан, хордуулсан, хүний эрүүл мэндэд нөлөөлсөн асар олон төслүүд байгаа шүү дээ. Жишээ нь бодитой байж байгаа шүү дээ Тавантолгойн уурхайн үйл ажиллагаанаас болоод Цогтцэций сумын иргэд цул тоосон дотор өдөр, шөнөгүй ингээд л байж байгаа. Мал нь уух усгүй, идэх ногоогүй, бэлчих бэлчээргүй л байгаа. Энийг чинь хамгийн сайн нөлөөлөлд нь өртөж байгаа хүмүүс тэнд байгаа байгаль орчин, мал, амьтан, хүн амьтан л байгаа шүү дээ. Тэгээд эд нараас асуудаг хэлэлцүүлдэг юмыг нь хасаад хаячихлаар чинь өнөө Үндсэн хуулийнхаа хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах ёстой гэдэг заалттайгаа зөрчилдчихсэн ийм л төсөл орж ирж байгаа юм. Үзэл баримтлалаа их гоё эхэлсэн байгаа. Үндсэн хуулийнхаа саяын хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй гэж сайхан эхлээд, яг араас нь тэгээд залгуулаад тэр иргэдээс нь санал багийн иргэдийн Нийтийн Хурлаас нь авахгүй гэххэж байгаа байхгүй юу. Тэгээд оруулж ирж байгаа энэ төсөл чинь үзэл баримтлалаасаа эхлээд хоорондоо зөрчилтэй, Үндсэн хуультайгаа зөрчилтэй ийм л юм ороод ирчихсэн юм байна гэж би ойлгосон. Тэгээд би тодруулга авч байгаад, юу хариулт сонсож байгаад дараа нь тодруулъя.

Б.Бейсен: Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Энэ дээр энэ нутаг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд энэ баг, хорооны иргэдийн нийтийн хурал гээд байхгүй болчихсон. Тэгэхээр энэ өөрөө энэ хуулийн зөрчлийг үүсгэж байгаа 1 дүгээрт. 2 дугаарт энэ зөвхөн иргэдийн нийтийн хурал гэхээр нэг жоохон тийм өрөөсгөл ер нь болчихдог, тэр нь хуралддаггүй, ирц нь хүрдэггүй. Тэгэхээр энд юу гэж оруулсан бэ гэхлээр энэ төслийн нөлөөллийн бүс гэж оруулж өгч байгаа. Төслийн нөлөөллийн бүсийг шууд болон шууд бусаар өртөх эрсдэлтэй орон нутгийн иргэдийн асуудлыг хэрхэн шийдэх вэ гэж байгаа. Тэгэхээр энд иргэдэд энэ төслөө танилцуулах, хэлэлцүүлэг хийх гэсэн энэ бүх зүйлүүд нэлээд нарийн орсон байгаа. Жишээлэхэд энд хэрэгжилтийн байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт байгаа болзошгүй эрсдэл нь ямар байх юм, дэд бүтэц, тээвэр, тэдгээрийн хамрах талбай байршил нь ямар байх юм, соёлын өв нь ямар байх юм, энэ хүрээнд үүсэж болзошгүй хуримтлагдах нөлөөлөлд нь ямар байх юм гээд энийг бүүр илүү нарийвчлаад өгсөн байгаа 1 дүгээрт.

Мөн энэ олон нийтийг эхнээс нь төслийн талаарх мэдээллийг үнэн зөв, ил тодоор хангах гэсэн ийм зүйлүүд орсон байгаа. Тэгээд ер нь орон нутгийн иргэд анхнаасаа л өөрсдөө идэвхтэй оролцоод, санал, бодол, зөвлөмжөө өгөөд ингээд хэрэгжүүлээд явах ийм боломжийг нь нээсэн. Тэгэхгүй бол одоо ингээд мэдээлэлгүй байж байгаад төсөл яг хэрэгжээд эхлэхээр энийг ч хэрэгжүүлэхгүй гээд ингээд багийн нийтийн хурал нь ингээд гэдийгээд суучихдаг ийм зүйлүүд байгаа юм. Манай хэн нэмээд хариулчих 4.

Б.Бейсен: 4 номер тодруулъя, хариулъя.

Г.Энхмөнх: Наранбаатар гишүүний асуултад тодруулга өгье. Хуулийн нэг үндэслэл шаардлага нь юу вэ гэхлээр Үндсэн хууль батлагдсантай холбоотой мэдэх эрхтэй холбоотой зохицуулалт байж байгаа. Энэ хүрээнд тухайлбал аж ахуйн нэгж ямар үүрэг хүлээх юм, Засаг дарга, иргэдийн Хурлын дарга ямар үүрэг хүлээх юм гээд энэнтэй холбоотой заалтууд 14.1.2, 1.4, 1.5 гээд маш тодорхой заачихсан байж байгаа. Нөгөө талаасаа юу гэдэг юм тэр багийн иргэдийн хурал заавал хангагдаж байж Үндсэн хуулийн энэ эрх шаардлага хангагдана гэдэг бол жоохон өрөөсгөл байх гэж харж байгаа. Нөгөө талаасаа энэ мэдэх эрхтэй холбоотой асуудлаар төсөл хэрэгжүүлэгч болоод мэргэжлийн байгууллага нөлөөллийн бүсэд байгаа иргэдэд хэлэлцүүлгээ зохион байгуулна. Мэдэх эрхийг нь хангаад явна гэсэн үг. Ингээд явахдаа тухайн нөлөөллийн бүсэд байгаа иргэдийн 70 хувийг зайлшгүй хамруулсан байх ёстой гэдэг ийм шаардлага. Нөгөө талаасаа энэ байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ гээд ороод ирэхээр олон улсын шаардлага стандартаараа тэр гомдол барагдуулах.../минут дуусав/

Б.Бейсен: Наранбаатар гишүүн тодруулъя.

Н.Наранбаатар: Үгүй ээ багийн иргэдийн гол санал нэгддэг, ярилцдаг, шийдвэрээ гаргадаг байгууллага чинь өөрөө багийн иргэдийн Нийтийн Хурал шүү дээ. Энэ Нэгжийн хуулиар багийн иргэдийн нийтийн хурал чинь өөрөө байгаа шүү дээ. Багийн Засаг даргатай, иргэдийн Нийтийн Хурлын даргатай болсон, 2 жил тутамд сонгож явдаг. Тэгээд багийнхаа тулгамдсан асуудал, бүх асуудлууд ярьдаг, хэлэлцдэг, шийдвэр гаргадаг ганц байгууллага. Тэгээд энэнээс нь санал авахгүй өөр яаж явах юм бэ? Нөлөөллийн айлуудаар гээд тэр хавийнхаа эргэн тойрны хэдэн айлаар хэсээд, тэгээд тэр нь ийм санал өгсөн, энэ нь ийм санал өгсөн гэж шийдвэр гаргах юм уу, яах юм бэ? Ерөөсөө энэ нь тодорхойгүй, ойлгомжгүй. Багийн багийн ИНХ-аас өөр шийдвэр гаргадаг байгууллага энэ чинь багт байхгүй шүү дээ. Энэ чинь Үндсэн хуулиараа засаг захиргааны нэгжийн хамгийн анхан шатынх нь баг шүү дээ. Тэгээд багийн ИНХ шийдвэр гаргадаг гол байгууллага нь байхгүй юу. Эндээс санал авахгүйгээр.../минут дуусав/

Б.Бейсен: Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Энийг хэлэлцүүлгийн явцад яг энэ байгаагаар нь байх уу эсвэл арай өөрөөр оруулах уу гэдэг нь нээлттэй байгаа. Ер нь зүгээр бид энийг судалгаа аваад хэлэлцүүлэг хийхэд энэ төслүүдийн хамгийн гол гацаж байгаа асуудал энэ ИНХ нь ерөөсөө хуралдахгүй байна, ирц нь хүрэхгүй гэдгээр ерөөсөө хуралдахгүй, тэгээд төсөл маш их гацаж байна гэдэг ийм гомдол маш их ирж байгаа. Тэгэхээр энийг хэлэлцүүлгийн явцад манай ажлын хэсгийнхэн яг яаж зөв томьёолох вэ гэдэг нь нээлттэй байгаа. Энэ дээр бид нарын яах вэ нэг давуу тал нэмж оруулсан зүйл гэхээр нийгмийн үнэлгээг нэлээн сайн оруулж өгсөн. Нийгмийн үнэлгээ дээр ер нь нэг энийг 3 хуваана. 3 хуваахдаа шууд энэ нэгдүгээрх нь нөлөөлөл их буюу зэрэглэл

1 дүгээр төслийн хувьд ямар байх юм, нөлөөлөл дунд буюу 2 дугаар зэрэглэлийн төслийн хувьд яах юм, 3 дугаар зэргийн төслийн хувьд.../минут дуусав/

Б.Бейсен: Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Үзэл баримтлалыг дэмжиж байгаа. Тэгээд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамныхан нэлээн удаан ажилласныг мэдэж байгаа. Тэгээд яг орж ирсэн төсөл зүйл, заалтуудаа харахаар нэлээн хэлэлцэх эсэх нь дэмжигдлээ ч гишүүдэд нэлээн их ажил үлдээд байгаа юм шиг санагдаад байна, энэ хүрээндээ асуултуудыг асууя. Төслийн 3.1.4-д энэ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар 4 төрлийн үнэлгээг ярьдаг. Стратегийн үнэлгээ, төлөв байдлын үнэлгээ, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ, тэгээд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ гээд. Түрүүн Одонтуяа сайдын хэлсэн зэрэглэл 1 зэрэглэл, 2 зэрэглэл, 3-д хуваана гээд байгаа асуудал нь яг энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл дээрээ 3.1.4 дээр буюу төлөв байдлын үнэлгээ дээрээ л харагдаж байгаа. 3.1.4 гээд заалт дээр. Яг байгаль орчны үнэлгээ, нөлөөллийн үнэлгээндээ орж сайн харагдахгүй юм. Зэрэглэл 1 нь яг ямар төслөө хэлэх юм, зэрэглэл 2 нь ямар төслөө хэлэх юм бол гээд хайгаад үзэхээр байдаггүй. Тэгсэн мөртөө 7.7-д Засгийн газар холбогдох журмыг нь батлагдах юм, батлах юм шиг уншиж байгаа. Тэгэхээр хууль дээрээ зэрэглэл 1, зэрэглэл 2, зэрэглэл 3-аа тодорхойлж өгөхгүй бол нөгөө журам нь хуулиа дагаад даваад явчихийм асуудал, эрсдэл үүсээд байгаа мэт анзаарагдаж байна. Энийг тэгээд бүгдээрээ яах вэ?

3.1.6 дээр байгаль орчны нөлөөллийн үнэлгээ гээд энэ маань нөгөө нийгмийн, байгаль орчин, нийгмийн асуудлыг хоёуланг нь оруулж ирнэ гээд түрүүний үзэл баримтлалд бичсэнээр тэгж ойлгогдоод байгаа мөртөө 3.1.6-гийн нөлөөллийн үнэлгээг харахаар магадгүй энийгээ байгаль орчин, нөлөөллийн, нийгмийн нөлөөллийн үнэлгээ гээд нэрлээд 3.1.6-аа хөндөөд ороод ирсэн бол зөв байх байсан юм болов уу? Тэгэхээр ингээд л бас л нэг ажил үлдчихэж байгаа байхгүй юу.

Тэгээд 2 дугаар нэг асуудал нь болохоороо ер нь энэ аль ч түвшний үнэлгээг ярьсан гэсэн нэг төсөл гэдэг зүйлийг ярьдаг. Тэгээд төсөл маань өөрийнх нь тодорхойлолт нь зөвхөн уул уурхай биш байхгүй юу. Үйлдвэр байна, аж үйлдвэр байна, үйлчилгээнүүд байна, барилга байгууламж байна, тэдгээрийг шинэчлэх өргөтгөх асуудал ордог. Тэгэхээрээ ингээд нөлөөллийн үнэлгээ чинь нийгмийн нөлөөлөл нь ч орж ирж яригдах ёстой. Тэгээд иргэдийн оролцоог энэ дээр нэмж байна, хүсвэл л энэтэй холбоотой үнэлгээнүүдийг хийлгэж болно гээд үзэл баримтлалаа их гоё бичсэн байгаа юм. Яг хуулийн төсөл дээрээ иргэдийн оролцоог хаана хангаж байгаа юм бэ гээд харахаар 14.1.4, 18.5, 18.7 бүгдээрээ зөвхөн уул уурхайг ярьчихсан газрын хэвлийн баялаг гээд. Бусад нөгөө Эгийн голын усан цахилгаан станцын үнэр байдаггүй. Нөгөө говь руу явах гэж байгаа том усны төслүүдийн нийгмийн нөлөөлөл гэж гарна. Тэр бас нэг их хөндөгдөөгүй. Тэгэхээр гишүүдэд их ажил л үлдэж байгаа юм шиг санагдаад байна. Энэ 2 дээрээ хариулт авчхаад тодруулга авъя.

Б.Бейсен: Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Энэ хуулийн төсөл дээр манайх ажиллахдаа яам дангаараа биш олон улсын энэ байгууллагаас туслалцаа авч, хуулийн зөвлөгөө, хуульчид шинжээчид ажилласан. Тэгэхээр яг энэ талаар манайхан хариулт өгчхөөрэй. Ер нь энэ нийгмийн нөлөөллийн үнэлгээг бид энэ хуульд тусгаж өгснөөрөө эрх зүйн талаасаа олон улсад хүлээн зөвшөөрөгдөх боломж нэмэгдэнэ гэж үзсэн. Мөн энэ

үнэлгээний зарчмаа энэ олон улсад тавигддаг тэр шаардлагад аль болохоор нийцүүлэх талаар нэлээдгүй заалтуудыг оруулж өгсөн байгаа. Тэгээд яг энэ дээр ажилласан, энэ олон улсын бусад хууль, эрх зүйтэй нийцүүлсэн, хэд хэдэн орны хуулийг яасан гэдэг дээр яам нь хариулт өгчих үү, эсвэл манай ОУБ-ын хүмүүс хариулт өгчих үү.

Б.Бейсен: Яамныхан хэдэн номер хариулах вэ? 4 номерын микрофон хариулъя.

Г.Энхмөнх: Уянга гишүүний асуултад хариулт өгье. Үнэлгээний төрлийн хувьд төлөв байдлын үнэлгээ ерөнхий нарийвчилсан стратегийн хуримтлах гээд байж байгаа юм. Энэ зэрэглэлийн хувьд энэ нөлөөллийн эрчмээс нь хамаарсан зэрэглэл байж байгаа юм. Тэгэхлээр энэ хоёрыгоо тусад нь ойлгох, ойлгож харвал илүү тодорхой ойлгомжтой болох байх. Тухайлбал 1 дүгээр зэрэглэлийн хувьд төрийн захиргааны төв байгууллага, 2 дугаар зэрэглэлийн хувьд аймаг, нийслэл, 3 дугаар зэрэглэлийн хувьд зөвхөн бүртгэлжүүлэлт үүсгээд явах ийм л юм байж байгаа.

Нөгөө талаасаа байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний хувьд 3.1.6 дээр байгаль орчны нөлөөллийн үнэлгээг юу гэж ойлгох вэ гэж энэ дээр хамрах хүрээг нь зааж өгсөн байж байгаа. Энэ дээр нийгмийн нөлөөллийн үнэлгээтэй холбоотой асуудал нь орчихсон. Нөгөө талаасаа Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.8 дээр хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд заасан агуулга.../минут дуусав/

Б.Бейсен: Уянга гишүүн тодруулъя.

Б.Уянга: Үлдсэн асуултаа асууж амжих нь уу яах нь вэ? Ямартай ч зэрэглэл 1-ийн нь та хэдийн энэ өгсөн төслийг маш сайн уншихаад орж ирж байгаа байхгүй юу дарга. Тэгэхээр энэ 7.9 дээр зэрэглэл 1, зэрэглэл 2, зэрэглэл 3 гэхээд тодорхойлолт байхгүй байна. Таны яриад байгаа зэрэглэл 1-ийг тэр хариуцна, зэрэглэл 2-ыг тэр хариуцна, 3-ыг тэр хариуцна гэж алга. Та хэд өөрсдөө хуулиа уншсан байх гэж найдъя. Зэрэглэлийг хаана тайлбарлаж байгаа юм гэхээр 7.10 дээр зэрэглэл 1-ийн төслийг 5 жил, хэзээ тодотгох юм бэ гэдгийг нь л биччихсэн байгаа байхгүй юу. Тэгээд энийг анхогт энэ салбарыг мэдэхгүй хүн орж ирээд уншлаа гэхэд зэрэглэл 1 гэж юугаа ч яриад байгаа юм, 2 нь юугаа ч яриад байгаа юм гэсээр байгаад тэр 7.7-гийн Засгийн журмыг унших хэрэгтэй болчихож байгаа. Тэгэхээр журам нь хуулиа давчих гээд байна, энийг яриад байгаа юм.

2 дахь нь тэгээд яаж ийгээд л асуухаас. Ер нь энэ аливаа нэг төслийн нөлөөлөлд өртөж байгаа бүс иргэн гэсэн тодорхойлолт ямар ч хууль дээр байдаггүй. Танай хууль дээр тодорхойлолт байхгүй байна. Энийг яах вэ?

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 4 номер хариулъя.

Г.Энхмөнх: Нөлөөллийн бүсийг журам аргачлалаар тогтоож өгч байгаа. Тухайлбал энэ дээр юу гэдэг юм зэрэглэлийн хувьд хэрхэн авч үзэх вэ гэхлээр тухайн нөлөөллийн эрчим, цар хүрээ, хүчин чадал энэ бүгдийг харгалзаад ингээд энэ зэрэглэлийг журмын хавсралтаар буюу ангиллаар тогтоож өгнө гэж байгаа. Энэ дээр юу байх вэ гэхлээр тухайлбал хүчин чадлаасаа хамаараад тухайн төслийн хувьд нөлөөллийн эрчим нь ямар байх юм, хэдий хэмжээний талбайг хамрах юм, тэрийгээ аргачлалаараа илүү нарийвчлаад тодорхойлоод өгнө л гэсэн үг. Түүнээс

юу гэдэг юм энэ хэмжээний төслийн хувьд 10км, 20км гэдэг юм уу ... zone татна гэдэг юм уу энэ нь жоохон, буцаагаад жоохон хүндрэл үүсэх учраас энийг илүү аргачлалаараа тодорхой болгоод оруулаад өгнө гэсэн үг. Тэгэхлээр нөгөө мэргэжлийн байгууллага, судлаачдын оролцоотойгоор энэ тодорхойлогдоод явна гэсэн үг.

Б.Бейсен: Зэрэглэл 1, 2, 3-ын тодорхойлолт гэж байна. Хэдэн номер хариулах юм бэ? 6 номер тодруулаад хариулъя.

И.Бямбахүү: Уянга гишүүний асуултад хариулъя. Зэрэглэл 1, 2 гэдгийг яаж хооронд нь ялгаж байна вэ гээд 7.9 дээр тодорхойлж өгч байгаа юм. Өөрөөр хэлбэл тухайн төслийн үзүүлэх нөлөө, төрөл, байршил, нөлөөллийн хамрах цар хүрээнээс хамааруулж зэрэглэл 1, 2, 3-д ангилна гэж авч үзэж байгаа юм. Өөрөөр хэлбэл ер нь олон улсын байгууллагууд төслийнхөө зэрэглэл, эрсдэлийн зэрэглэлээ Дэлхийн банк жишээлбэл 4 ангилж байгаа. 4 ангилахдаа маш их, их, дунд, бага гээд. Энэ болгоны цаана ямар criteria явж байна вэ гэхлээр сая бидний энэ тодорхойлолт хийж өгсөн 7.9 дээр томьёолж өгч байгаа. Төслийн үзүүлэх цар нөлөөлөл, хэрэгжих газар, хүчин чадлыг харгалзан үзэж энэ зэрэглэл 1, 2-г тодорхойлж өгдөг.

Б.Бейсен: Уянга гишүүн тодруулъя.

Б.Уянга: Тийм, тэрийг ойлгоод л уншаад байна, байгаа юм. Та хэдтэйгээ маргалдахыг ерөөсөө хүсээгүй. Зүгээр 7.9-ийг ингээд уншихаар нөлөөлөл, цар хүрээ, төсөл хэрэгжих газар нутгийн байршил, хүчин чадлыг харгалзана гэж байгаа юм. Зэрэглэл 1, 2, 3 гэхээр логигоор ойлгох ёстой юу? 1 нь их байвал нэг гэх юм уу, их байвал 3 гэх юм уу? Тэгэхээр чинь энэ аливаа нэг төслийг ангилах гэж байгаа бол тодорхойлолт нь ядаж байх ёстой юм шиг. Тэгэхээр хэрвээ хэлэлцэх нь дэмжигдээд явбал энэ дээр зарчмын зөрүүтэй санал жишээ нь оруулж ирэх шаардлагатай гэж би үзэх гээд байна даа. Тэгэхээр энэ дээр л хариултаа авчхаад цааш ажиллах гээд байгаа юм. Тэгээд хариулт өгөөд хэрэггүй, ямартай ч байхгүй байна тодорхойлолт нь.

Б.Бейсен: Гишүүдийн асуусан асуултад тодорхой хариулаарай ажлын хэсгийнхэн. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа, энэ өдрийн мэнд хүргэе. Намайг сайд байх үед явж байсан төсөл нэлээн өнгө нь хувираад ороод ирчхэж. Саяын Уянга гишүүнийхтэй яг санал нэг зэрэглэл 1, 2, 3 гэдгийг тодруулах ёстой. Энэ чинь ашигт малтмал чинь өөр, өөр шүү дээ. Эсвэл ганцхан зүйл, ганцхан ашигт малтмал дээр гаргаж байгаа нөлөөллийн үнэлгээ юм уу? Тэгээд энийгээ тодруулах ёстой гэж харж байгаа юм.

2 дугаарт яах вэ ингээд харахаар зэрэглэл 1 төсөлд 5 жил, зэрэглэл 2 төсөлд 10 жил тутам байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд нэмэлт тодотгол хийнэ. Зэрэглэл 3 төсөлд энэ хуулийн 7.11-д заасан нөхцөл үүсээгүй тохиолдолд байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд нэмэлт тодотгол хийхийг шаардахгүй гээд ороод ирж байгаа юм. Энэ бол жилийг уртасгаж байгаа хэлбэр дээр зөв мэт боловч ер нь ерөнхий төлөвлөгөө, нарийн, нарийвчилсан төлөвлөгөө дээр нэг их асуудал зогсоод байдаггүй шүү дээ. Та хэд өөрсдөө надаар хэлүүлэлгүй мэдэж байгаа. Менежментийн төлөвлөгөө. Та хэд менежментийн төлөвлөгөө дээр гоё бичсэн байна. Юу гэж бичсэн бэ гэхээр зэрэглэл 1, 2, 3-аас шалтгаалаад дүйцүүлээд тухайн төсөлд нь хамааруулаад менежментийн төлөвлөгөөг батлахаар оруулаад өгчихсөн

байна. Гэхдээ 9.8 дээр байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээн авч, дараа оны төлөвлөгөө болон түүний хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батална гээд биччихсэн байгаа байхгүй юу. Тэгээд ингэж нүүр угааж болохгүй шүү дээ. Та нар 10 жилээр зэрэглэл 1-ээрээ 5 жилээр баталчихлаа гэж бодъё менежментийн төлөвлөгөөг нь, баярлалаа. Гэхдээ энд чинь та нар дараа жилийнхээ 12 дугаар сард багтаагаад заавал тайлагна гээд, тайлагнаж заавал тухайн жилдээ хэрэгжүүлэх, тухайн ондоо, дараа ондоо хэрэгжүүлэх шаардагдах хөрөнгө зардлын хэмжээг батална гээд биччихсэн байгаа байхгүй юу. Тэгээд энийг батлахгүй бол тэр менежментийн төлөвлөгөө 10 жил байсан ч энэ төсөл чинь явахгүй. Энийг Энхмөнх дарга надаар хэлүүлэлгүй мэдэж байгаа.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос Петро Чайна Дачин Тамсаг компанитай холбоотой асуудлаар бид менежментийн төлөвлөгөөг батлаагүй байсан. Гэтэл Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээрээс энэ менежментийн төлөвлөгөөг нь батал гэдэг бичиг ирж байсныг та бүхэн санаж байгаа байх. Баталсан тийм ээ, баталсан шүү дээ. Монгол Улсын ЗГ-ын хөтөлбөр явах ёстой, юу, юу гээд ингэж байгаад баталсан. Энэ үнэн. Тэгэхээр бид энийгээ яах юм бэ? Та нар дараа оныхоо 12 сард багтаагаад ингээд нэг талдаа 10 жил, 5 жил гээд гоё юм яриад, нөгөө талдаа менежментийн төлөвлөгөөг дараа ондоо багтаагаад шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг нь баталж өгөхгүй бол энэ ажил чинь зогсох юм уу гэдэг 2 дугаар асуулт.

Би 1 минут нэмээд авчихъя даргаа. 3 дугаарт уг нь аягүй сайн хэлсэн шүү дээ. Энэ 9.10 дээр ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны.../минут дуусав/

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүнд 1 минут нэмж олгоё.

Б.Бат-Эрдэнэ: Баталгаа болгож байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ гээд. Үгүй ээ тэгээд яах гэж олон улсад банкны баталгаа гэж байдаг юм бэ? Энэ банкны баталгааг нь аваад хийчихдэг систем рүү оруулъя гээд намайг сайд байхад та нар өөрсдөө зөвшөөрөөд энийг уул уурхайн call ч билүү, юу ч билээ нэг том хурал дээр очоод зарлаад алга ташилт авч байсан биз дээ Энхмөнх даргаа. Тэгээд энийгээ яаж байгаа юм бэ, одоо буцааж байгаа юм уу сайд нь өөрчлөгдсөн гээд? Ингэж болохгүй шүү дээ. Та нар банкны баталгаа хэрэглээд яваад энэ тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийнхөө баталгаагаа гаргана биз. Тэнд бэлэн мөнгө байршуулж, уул уурхайд эргэлдэх мөнгөө хэрэглээд явж байх ёстой компани тэнд бэлэн мөнгөө байршуулчихаад ингээд явдаг хэлбэрийг халах хэрэгтэй байхгүй юу. Тэгэхээр энэ болохгүй гэдгийг би хэлэх гэж байгаа юм. Тэгээд асуултад хариулт авч байгаад нэмэлт.../минут дуусав/

Б.Бейсен: Одонтуяа сайд, 4 номер хариулъя.

Г.Энхмөнх: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. 5 жил, 10 жилтэй холбоотой асуудал Үнэлгээний тухай хууль дээр хавсралт буюу 5 жил, 10 жилээр

байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төлөвлөж өгч байгаа. Таны ярьсан 9.8-тай холбоотой асуудал бол тухайн жилийн менежментийн төлөвлөгөөтэй холбоотой асуудал байгаа. Тухайн жилдээ хийх ажлынхаа төлөвлөгөөг тухайн 5 жил, 10 жилээр төлөвлөчихсөн байгаагаасаа тухайн жилдээ батлуулаад явах энэ зохицуулалт байгаа. Нөгөө талаасаа 9.8 өөрөө хөндөгдөөгүй заалт байгаа.

50 хувийн барьцаа байршуулахтай холбоотой асуудал 9.10 мөн хөндөгдөөгүй. Ер нь яах вэ энэ нөгөө барьцаатай холбоотой журмыг бид хэд 2025 оны 2 сард шинэчлэн баталсан. Энэ журмын шинэчлэлээр ямар асуудал болсон гэхлээр ер нь яах вэ энэ нөгөө байршуулж байгаа мөнгөтэй холбоотой асуудал, буцаан зарцуулалттай холбоотой асуудал хуучин журам дээр зөвхөн оролт байгаад, гаралт нь байхгүй байсан бол шинэчилсэн журмаараа энэ гаралтын асуудлыг тодорхой болгоод ингээд журмыг шинэчилчихсэн байж байгаа.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Энхмөнх дарга та бид 2 муур хулгана болж тоглоомооргүй байгаа юм. Наадхыг чинь би тэнэг биш ойлгож байгаа. Та нар тухайн жилийн дараа оныхоо хөрөнгө зардлын хэмжээг баталж өгч байж менежментийн төлөвлөгөө чинь хэрэгжих гээд байгаа байхгүй юу. Батлагдах гээд байгаа байхгүй юу. Тэгж байж тэр компанийн чинь тухайн жилийн үйл ажиллагаа эхлэх гээд байна шүү дээ, үргэлжлэх гээд байна нэг ёсондоо, тийм биз дээ? Үгүй ээ тэгээд ямар өөрчлөлт байгаа юм бэ? Та нар ерөнхий үнэлгээ, нарийвчилсан үнэлгээ 2-ыг 40 жил болгосон ч гэсэн менежментийн энэ төлөвлөгөөтэй холбоотой жил болгоны тайлан авч ингэдэг явдаг процесс чинь явдгаараа явж байгаа цаг хугацаанд 40 жил болоод ч нэмэргүй. Та нар 5 жилээр менежментийн төлөвлөгөөг нээж өгч байгаа бол тэр 5 жилээр нь асуудлыг нь шийдэх хэрэгтэй. Тэгж байж наад ААН-д чинь үйл ажиллагаа явуулах бүрэн эрх нь нээгдэнэ. Яг нээх гэж байгаа бол. Нэг талдаа нээгээд байгаа юм шиг боловч нөгөө талдаа та нар яг хаасан заалт чинь хэвээрээ яваад байна шүү дээ. Тэгээд нөгөө барьцааны 50 хувь, энийгээ банк.../минут дуусав/

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 3 номер хариулъя. 3 номер, албан тушаалаа хариуцсан, хариуцах албан тушаалын дагуу хариулъя.

Ө.Мөнхбаяр: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя 7.10 дээр заасан энэ зэрэглэл 1, 2, 3 төсөл дээр болохоор үнэлгээний нэмэлт тодотгол хийх асуудал байгаа юм. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө маань өөрөө 2 янзаар явж байгаа. Нэг нь Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хавсралтаар явахдаа төлөвлөж байгаа юу нь одоогийн хуулиар болохоор 5 жилээр төлөвлөөд явж байгаа менежментийн төлөвлөгөөг. Шинэ хуулиар бид энэ зэрэглэл 1, 2, 3-аасаа шалтгаалаад 1-ээс 10 хүртэл жилээр төлөвлөө гээд, дээр нь 9.8 дээр байгаа нь болохоороо нөгөө тухайн жилийн менежментийн төлөвлөгөөгөө жил бүхэн энэ 10 жилийн төлөвлөж байгаа эдийн засгийн тооцоон дотор.../минут дуусав/

Б.Бейсен: Тодорхой хариулъя. 1 номер хариулъя гэж байна. 1 номер.

П.Бүнчинжав: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Энэ хуулийн ажлын хэсгийг Дэлхийн банкны зүгээс ажилласан хуулийн зөвлөх Бүнчинжав байна. Ерөнхийдөө Бат-Эрдэнэ гишүүний яриад байгаа менежментийн тухайн жилийн менежментийн төлөвлөгөөг энэ нэмэлт, өөрчлөлтийн төслөөр хөндөөгүй. 5-аас 10 гэдэг нь одоогийн хууль дээр Үнэлгээний хуулийн, нарийвчилсан үнэлгээний хууль юуны тайлангийн ар талд 5 жилийн менежментийг батлуулна гээд хатуу заагаад

өгчихсөн одоогийн хууль дээр. Яг төслийнх нь ангилал жижиг байна уу, том байна уу, хөдөө гадаа байна уу ерөөсөө хамаарахгүйгээр уул уурхайн төсөл дээр ч 5 жил, жижиг төсөл дээр ч 5 жил байсныг 10 жил хүртэл болгож сунгаж өгсөн юм. Ийм нэмэлт, өөрчлөлт л яваад байгаа юм.

Б.Бейсен: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууя.

С.Ганбаатар: Энэхүү хуулийг Байгаль орчны яамнаас оруулж ирж байгаад би их харамсаж байна. Тэгээд ойрд нэг жоохон тэгээд л дуугарах нь дээ, хүчтэйхэн шиг л дуугарахаас. Та энэ 5А.1-д хуудас 2-т заасныг хар даа. Эдгээрийг үндэслээд хуулийн төслийн 7.12-т зарим төсөлд байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэхийг шаардахгүй гэж үг орж ирсэн байна шүү. Үгүй ээ та нар Үндсэн хуулийн 6.1-д газрын хэвлийн баялаг гагцхүү ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад гэж байгаа шүү дээ. Хамгаалах ёстой төр нь Байгаль орчны яам нь тэр ард түмнээс нь тэр гагцхүү гэдэг үгийг бүүр хамаагүй л дээ дээрэмдээд та нараас асуухгүйгээр шийднэ гэж хууль орж ирсэн.

Дараачийнх нь юмыг та нарт уншиж өгье дөө. 7.13, 7.14 төслийн товч танилцуулга дээр ч байна. Байгаль орчны нарийвчилсан ерөнхий үнэлгээг үндэслэн сум, дүүргийн зөвхөн Засаг дарга орон нутагтаа төслийн хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэж байхаар зохицуулахаар байна гэж байгаа юм. Та нар тоглож байгаа байлгүй дээ. Энэ чинь Байгаль орчны яамнаас орж ирж байгаа юм шүү дээ. Олон улсын хүний эрхийн конвенц дээр саяхан тайлан дээр нь бичсэн байна лээ. Буурай, баялагтай, баялаг ихтэй буурай орнуудад өөрийгөө өмгөөлөх чадваргүй хүн, байгаль 2-ыг дээрэмдэж цөм, цөм ашиг хийдэг юм гэсэн утга агуулгатай зүйл бичсэн байна лээ. Монгол орны яг зэрлэг капитализмаар явж байна. Өнөөдөр хөдөө орон нутагт иргэний дайны байдалтай байгаа шүү дээ. Та нар бол зүгээр иргэний дайныг улам гааруулж байна. Уул уурхайн компаниудыг хар том, том нохойтой, буутай хамгаалалтын албадаар хүрээлүүлчихсэн байгаа иргэний дайны байдалтай.

Энэ дээр бүүр тэр нөгөө Үндсэн хуулийн 6.1-д заасан ард түмнээс асуух олон нийтийн хэлэлцүүлэг явуулах, та нар горьдвоо гэдэг хууль оруулж ирж байна шүү дээ. Тэгэхлээр ийм ингэж тоглохгүй. Үндсэн хуулийн 6.1 бол эдийн засгийн аливаа ашиг ямар нэгэн эдийн засгийн үзүүлэлтээс дээгүүр, иргэдийн болон байгалийн аюулгүй байдал гэдэг асуудлыг дээр нь тавьсан байгаа. Та нар Үндсэн хуулиа зөрчсөн асуудал оруулж ирж байна. Байгаль, хүн 2-ыг л өөрийгөө өмгөөлөх чадваргүй хүмүүс, байгаль 2-ыг л өмгөөлөх үүрэг нь төрийн үүрэг, Их Хурлын үүрэг юм шүү дээ уг нь. Тэгээд энэ дээр ингэж заасан байна. Төр нь байгаль орчны стратегийн үнэлгээ хийх шинжээч томилох зэрэг үүргийг өөртөө авч байгаа нь та нар зүгээр авлига, хүнд суртлын бүүр гааруулах нь байна шүү дээ. Тэр шинжээчдэд л мөнгө өгчихөд тэр том, том компаниуд болчих гээд байна шүү дээ. Та нар танилцуулга дээр их гоё тайлбар өгсөн байгаа юм. 1-ээс 2 удаа иргэдийн төлөөлөгчдийн хурал нь хар даа, төсөл.../минут дуусав/

Б.Бейсен: Гишүүдийн асуусан асуултад энэ ажлын хэсэг тодорхой хариулаарай. Гишүүдээс гомдол тавиад байна шүү. Одонтуяа гишүүн хариулъя.

С.Одонтуяа: Тэгэхлээр ийм байгаа энд ингээд шууд ерөөсгөл хандаж болохгүй. Өнөөдөр бизнес эрхэлж байгаа хүмүүс энэ байгаль орчны үнэлгээг хийлгэхийн тулд 152 хоног шаардлагатай байгаа. Манай яаман дээр жилд 700-аас 800 үнэлгээг жилд хийж байна. Манай Үнэлгээний хэлтэс өдөр болгон л хуралдаад л байдаг, тэгээд энийг бид ангилсан юм. Ганбаатар гишүүнээ, ангилж байгаа юм 1,

2, ер нь 3 зэрэглэлээр ангилъя гэж. Яагаад гэхлээр би саяхан нэг ийм уламжлалын эмнэлэг дээр очлоо л доо. Тэгсэн чинь нэг жижигхэн эмнэлэг нэг лабораторитой, энэ зөвшөөрлөө авах гэж өчнөөн удаан явж байна гээд. Тэгээд яагаад гэсэн чинь ерөөсөө бүх ангилал нь нэг юм байна, нэг литр химийн бодис оруулж ирсэн ч адилхан, мянган тонн ч байсан. Тэгэхээр бид энийг ангилж байгаа юм. 3 дугаар зэргийн ангилал бол тэр шаардлагагүй компаниуд байна. Тэгээд л нэг хэдэн ААН-үүдээ махлаад л үнэлгээ хийлгэнэ гээд ингээд яваад байдаг. Тэдгээр нь яаж байгаа гэхлээр, одоо шинэ хуулиар бид яаж оруулж ирж байна гэхээр цахимаар мэдүүлнэ, заавал түүн дээр зөвшөөрөл авахгүй ийм нэг хэсэг байна. Энэ бол жижигхэн бичил бизнес энэ тэр зөндөө хүмүүс байна. 2 дахь нь арай өөр аймаг, орон нутаг нь өөрсдөө шийдээд, аймаг, орон нутаг нь хяналтаа тавьдаг. 1 дүгээр зэрэглэл бол яах аргагүй Байгаль орчны яам өөрөө энийг нь зөвшөөрлийг нь өгдөг, бүх юмыг нь хянадаг, саяын таны хэлсэн хатуу шаардлагаа тавьдаг ийм 3 л ангилж байгаа юм.

Тэгэхгүй ингээд бүгдийг нь нэг тогоонд оруулчихаар нөгөө яг зайлшгүй чухал зүйл дээрээ цаг нь ч бага, хүн нь ч бага ингээд асуудал бол үүсэж байгаа юм. Энийг бид нэлээн яах вэ дэвшил юм гэж оруулж ирж байгаа. Тэгэхгүй бол өнөөдөр бизнесийнхэн бизнес чинь явахгүй байна шүү дээ. Бизнесийнхэн өнөөдөр яагаад халгаад байгаа юм гэхээр нэг ганц зөвшөөрөл авах гэж л 152 хоног болоод байна гэдэг ийм гомдол маш их ирж байгаа. Дээрээс нь бид энэ нийгмийн нөлөөллийн үнэлгээнд оруулчихсан байгаа шүү дээ. Их нөлөөлөлд орж байгаа, дунд зэргийн, бага зэргийн. Тэгээд энийг олон улсын стандарт руу бид ойртуулж ирж байгаа юм олон улсын стандарт руу. Тэгэхгүй бол манай одоо нэг гаднын хөрөнгө оруулалтууд яагаад орж ирэхгүй байна гэхээр энэ хуультай чинь холбоотой байгаа юм. Тэгэхээр энд бид ангилсан юм шүү Ганбаатар гишүүнээ. Зүгээр нэг жижигхэн нэг бид жижигхэн эмийн сан ч юм уу нэг юу ч юм ийм газруудад нь хурдхан, хурдхан бизнесийг нь хийлгээд явуулъя. Яах аргагүй ноцтой газруудад нь ингэе гээд энийг бол энэ олон улсын чиглэлээр нь ангилсан байгаа.

Үндсэн хуульд харин мэдэх эрхийг хангаж, энэ тухайн нөлөөллийн бүсийн иргэдэд энэ төслөө танилцуулах, тайлбарлах гээд энэ бүх зүйлийг оруулж ирсэн. Зарим орхигдсон зүйлийг.../минут дуусав/

Б.Бейсен: Ганбаатар гишүүн тодруулъя.

С.Ганбаатар: Чуулган дээр ярья даа. Уг нь та нар маань сайхан ухаантай улсууд энэ дээрээ ингээд татаад авчихвал буян болно гэж хэлж байгаа юм шүү дээ уг нь бол. Тэгээд төслийн хуудас 19-д зааж байгаа шүү 7.14-д сум, дүүргийн Засаг дарга төсөл хэрэгжүүлэгчийн хүсэлтийг, хуудас 19 7.13-д заасан байгаа шүү дээ дахиад, хүлээн авч ажлын 10 хоногт багтаан хариу өгөх бөгөөд энэ хугацаанд шийдвэрлээгүй тохиолдолд хариу өгсөнд тооцно гэж байгаа юм. Энэ хариу нь тэгээд зөвшөөрсөн гэсэн үг юм уу, татгалзсан гэсэн үг гэдгийг яаж та мэдэж байгаа вэ? 10 хоног гэдгийг хэн тогтоосон юм бэ? Энэ чинь та нар чинь бүр гэрлийн хурдаар шийдэж байна шүү дээ. Тэгээд хүлээн авах гэдгийг яг ямар утгаар хэлж байгаа юм бэ? Цаасаар юм уу, нөгөө цахимаараа юм уу? Нөгөөдхийг чинь онгойлгож үзээгүй 10 хоночихсон бол тэгээд л бандан тас уу?

2 дугаар асуулт нь энэ тэгээд томоохон энэ том төслүүд дээр тэгээд Үндсэн хуулийнхаа 6.1-ийг өөрчлөх хэрэг болж байгаа юм уу? Энэ ард түмний мэдэлд, гагцхүү ард түмний мэдэлд гэдгээ авч хаях хэрэг гарч байгаа юм уу хэдүүлээ, яах уу?

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 4 номерын микрофон хариулъя.

Г.Энхмөнх: Тухайн хүсэлт гаргаж байгаа нөхцөлд төрийн байгууллагаас байгууллагад иргэн, ААНБ-аас хүсэлт гаргах, шийдвэрлэх хоногийг 30 хоногоор заачихсан байж байгаа. Тэгэхлээр энэ дээр цахимаар ч бай, цаасаар ч бай хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш шийдвэрлэх хугацааг зааж өгсөн. Нөгөө талаасаа тухайн энэ хууль Газрын тухай хуулийн заалттай хэрхэн холбогдож байгаа вэ гэхлээр газрын шийдвэр гараад, үнэлгээ гарсны дараа тодорхой шийдэх хугацаанууд байж байгаа юм. Нөгөө талаасаа тухайн сумын Засаг дарга энэ дээр санал өгч байгаа юм. Түүнээс татгалзсан гэдэг юм уу, дэмжсэн гэдэг юм уу тийм шийдэл байхгүй. Тухайн төслийн хувьд тухайн орон нутгийн Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн төлөвлөгөө болоод газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй хэрхэн уялдаж байгаа юм, энэнтэй холбоотой саналуудыг өгөөд явдаг энэ зохицуулалт байж байгаа. Тэр утгаараа, тэгж байгаа. Тэгж байгаа. Энэ ажлын 10 хоног гэж байгаа юм. Ажлын 10 хоногт хариу өгөөгүй бол санал өгсөнд тооцно гэж байгаа юм. Тухайлбал энэнтэй холбоо бүхий.../минут дуусав/

Б.Бейсен: Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Энэ өдрийн мэнд хүргэе. Энэ Байгаль орчны үнэлгээний хуультай холбоотой асуудал дээр ялангуяа орон нутагтай холбоотой нэлээн ноцтой юмнууд орсон байна гэж би харж байна. 1 дүгээрт сая яг энэ Ганбаатар гишүүний яриад байгаа тэр нөгөө сумын Засаг дарга зөвшөөрсөн, зөвшөөрөөгүйг огт харгалзахгүйгээр ингээд цаашаа явна 1 дүгээрт энэ. Энэ яаж байгаа юм бэ?

2 дугаарт энэ багийн иргэдийн нийтийн хурал гэдэг чинь та нар ер нь яг юу гэж бодоод байгаа юм бэ? Тэр баг дээр ажиллаж, амьдарч байгаа хүмүүс цуглаж, ажил амьдралаа ярьж, нэг шийдвэр гаргаж, тэрийгээ мөрдөж хэрэгжүүлж явдаг төрийн хамгийн анхан шатны байгууллага шүү дээ. Гэтэл энэ Байгаль орчны үнэлгээний хуулиараа одоо байгааг нь бүүр шал дордуулаад, багийн иргэдийн нийтийн хуралгүйгээр зүгээр иргэдийн саналыг авна гэж. Энэ дээр Байгаль орчны яам ер нь танайх яг өөрсдийнхөө үндсэн үйл ажиллагаанаас арай өөр юм руу ер нь чиглээд байна уу, үгүй юү? Энэ ашигт малтмалын хайгуулын ч бай, ашиглалтын ч бай энэ компаниуд нэг хэзээ нэг ард түмний өмнө нэг зөөлөн чихтэй, за гэж дуугардаг вэ гэвэл энэ үнэлгээгээ хийлгэхийн тулд танай баг дээр ингэе, тэгье, ажлын байр нэмье, ингэж ухъя, ингэж хайгуул хийе, байгаль орчныг ингэж хамгаалъя гэж ганц дуугардаг юм нь энэ байхгүй юу. Гэтэл та нар энийг нь байхгүй болгоод хаячихаар энэ багийн иргэдийн Нийтийн Хурлаар наадах чинь орохгүйгээр зүгээр нэг багийн 2, 3 хүнээс сонгож аваад танилцуулчих юм уу?

Тэгэхээр ер нь зүгээр энэ Байгаль орчны яамныхан та нар жоохон амьдралтай юм хиймээр байна. Ямар ч амьдралгүй, ард түмнээс тасарсан. Өмнөх олгосон баахан лицензүүдийнхээ учрыг олоогүй, хужрын тунгаагаагүй, өмнө нь эзэнгүй баахан ухуулчихсан газруудаа булж, тэгшилж янзалж чадаагүй байж дахиад нэг баахан юмнуудыг ингээд иргэдийн хяналтаас гаргаад хаячих нь байна шүү дээ. Энэ багийн иргэдийн Нийтийн Хурлын даргагүй болгочихсоныг нь өнгөрсөн парламентын үед энэ орон нутгаас сонгогдсон аймгийн Засаг дарга нар нэг хөөцөлдөж байгаад энэ Нэгжийн хууль дээр нь өөрчлөлт оруулаад багийн иргэдийн Нийтийн Хурлын даргатай болоод энэ 1 сар, 2 сараас бүх багууд даргатай болоод ингээд цэгцэрч байгаа. Одоо тэгээд даргатай болоод ч нэмэргүй тэд нарын үгийг сонсохгүй ийм хууль оруулж ирж байгааг эсэргүүцэж байна.

Та орон нутагт ямар юм болдгийг мэдэх үү? Энд ингээд баг нь эсэргүүцээд, сум нь эсэргүүцээд, аймаг нь эсэргүүцээд байхад хэдэн мянган га-гаар нь ашиглалтын лиценз өгдөг, хайгуулын лицензүүд өгдөг. Тэрний гайг энэ нэг сумын дарга энэ муу өгчихсөн юм, энэ нэг муу аймгийн дарга энэ муу өгчихсөн юм тийм л юм үүрдэг шүү дээ. Тэгээд энийг нь улам та нар ингээд яаж байна. Тэгээд энэ нөлөөллийн судалгаа хийсэн, танилцуулга хийсэн гэж байна. Аль сумын, аль аймгийн, аль сум дээр очиж танилцуулга хийсэн бэ?

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 6 номер хариулъя.

И.Бямбахүү: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Энэ олон нийтийн оролцоог хангах энийг бол зөвхөн иргэдээр бид хязгаарлаагүй. Өөрөөр хэлбэл бид журам аргачлалдаа энийг юу гэж оруулж байна вэ гэхлээр олон нийт гэдэг дотор 2 янзаар оруулж байгаа. 1 дүгээрт нь орон нутгийн иргэд, 2 дугаарт нь шийдвэр гаргах түвшний иргэд. Энийгээ бид яаж процесс дээр нь үнэлгээ хийж байх явцад энийг зөв зүйтэй хийх вэ гэдэг дээр аргачлал дээр маш нарийн зааж өгч байгаа. Өөрөөр хэлбэл тэр тухайн үнэлгээ хийж байгаа компани нь тухайн төсөл хэрэгжиж байгаа газар нутагт очоод иргэдээс нь санал асуулгаа авна. Шийдвэр гаргаж байгаа хүмүүс буюу сумын Засаг дарга, хорооны Засаг дарга ингээд шийдвэр гаргах түвшнийг бүх хүмүүсээс авна. Дараа нь энд аргачлал дотор ямар нюанс байдаг вэ гэхлээр олон улсын яг жишгээр явдаг бүлгийн ярилцлага, ганцаарчилсан ярилцлага энэ асуудлуудыг хийж байгаа. Ганцаарчилсан ярилцлага гэдэг яг тэр тухайн, тухайн хүмүүстэйгээ ярилцаад, бүлгийн ярилцлага хамгийн чухал. Энэ иргэд нь ч суудаг, шийдвэр гаргагч хүмүүс нь ч суудаг. Энэ ингээд 10-аас, 8-аас 10 хүнийг суулгаж байгаад тусгайлсан санал асуулгын дагуу үнэлгээтэйгээ холбоотой энэ асуудлуудыг хийж өгч гаргаж ирж байгаа юм.

Дараа нь бид энд юу шаардаж байна вэ гэхлээр энэ олон нийтийн оролцоо, хэлэлцүүлгийг зөв зохион байгуулсныгаа албажуулах ёстой, албажуулаад тайландаа оруулах ёстой, оруулсныгаа бид үнэлгээ батлуулахдаа мэргэжлийн зүйлүүд үнэн зөвөө тайлагнах ёстой. Ийм цаана нь хяналтын системүүдийг бид оруулж өгч байгаа юм. Тэрнээс зөвхөн иргэдтэй очоод ярина гэсэн ойлголт энд байхгүй. Тэгэхлээр яг энэ бол ерөөсөө бид яг нөгөө нэг олон улсынхаа зарчим руу энэ олон нийтийн хэлэлцүүлгийг явуулж байгаа үндсэн зарчмыг л бид дөхүүлж аваачихгүй бол өнөөдөр бид хөгжиж байгаа улс хөрөнгө оруулалт цаашдаа маш их нэмэгдэнэ.

Дэлхийн банкны хөрөнгө оруулалт гэхлээр яг л энэ зарчмаараа явдаг. Гэтэл бид өмнө нь яаж байгаа процесс яаж явж байна вэ гэхлээр багийн иргэд дээрээ очоод л хурал нь болохгүй. Сая бид энэ бүх юмыг ярилаа. Тэгэхлээр энэ олон нийтийн оролцоо гэдэг нэлээн хяналтын систем нь цаанаа маш нарийн болж өгч байгаа. Дээрээс нь энэ олон улсын ямар ч байгууллагаас бид зээл, тусламж аваад хэрэглэхэд яг тэдний аргачлалын дагуу бид адилхан яг үнэлгээний ажил хийдэг. Яг энэнтэй мөр зэрэгцээд ирж байгаа юм. Тэгэхлээр энэ болгон маань нэг шугам дээр ороод ирэхлээр бид харин цаашдаа энэ олон улсын банк, санхүүгийн байгууллага, магадгүй гаднын хөрөнгө оруулалтууд энэ бүх юмыг бид энэ хууль, эрх зүйн орчиндоо дэмжиж өгнө.

2 дугаарт тэр ашигт малтмал, хайгуул энэ эхлээд сумынхаа Засаг даргаасаа аваад явж байгаа шүү дээ. Манай одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үнэлгээний тухай хуулийн 3.1.4 дээр юу байдаг вэ гэхлээр энэ хөндөгдөөгүй заалт тухайн төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээг боловсруулж байх, тухайн тухайн

төслийн техник, эдийн засгийн үндэслэл, хөгжлийн бодлого, хөтөлбөрийг боловсруулж байх явцад төлөв байдлын үнэлгээ хийж, төсөл хэрэгжих нутаг, дэвсгэрийн байгаль орчны асуудлыг тодорхойлно гээд заагаад өгчихсөн байж байгаа. Энэ нь бид бүхний ярьж байгаа уул уурхайн ТЭЗҮ боловсруулж байх явцад уг нь манай энэ Үнэлгээний хууль яг тэр үедээ ард нийттэй очоод уулз, байгаль орчныхоо асуудлыг оруулж өг. Ингээд ТЭЗҮ боловсруулах механизмд нь оруулаад өгчихсөн байдаг байхгүй юу. Харамсалтай нь энэ хуулийн заалт маань өнөө хүртэл хангалттай.../минут дуусав/

Б.Бейсен: Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Тийм. Та хэд яах вэ олон улсын сайхан жишээг ярьж л байна. Жоохон тийм хөрсөн дээрээ буумаар байна, хөрсөн дээрээ буумаар байна. Яагаад ажил явахгүй гэж энэ чинь уул уурхайн салбар чинь хөгжөөд ингээд л энд тэндгүй яваад л байгаа биз дээ. Энэ чинь багийн иргэдийн нийтийн хурал юмаараа ороод ингээд л явж байгаа шүү дээ. Үгүй ээ тэрүүгээр нь л бүүр сайжруулдаггүй юм гэхэд тэрийг нь битгий дордуул. Тэгээд би та нараас тодорхой юм асуусан шүү дээ. Олон улсын л юм яриад байх юм. Та нар яг аль аймгийн, аль сумын аль баг дээр очоод энэ төсөл хэрэгжихэд багийн иргэдийн Нийтийн Хурлын процессыг чинь ингээд хөнгөлчихсөн, ингээд, ингээд хэлэлцүүлэг хийнэ, ингээд бүлгийн хэлэлцүүлэг хийнэ гэж тэр ард иргэдээс яг асуусан тийм бодитой тийм тайлан байна уу? Аль аймгийн, аль сумын, аль баг дээр, хэзээ очоод ийм яриа таниулга хийв, саналыг нь сонсов гэж? Биднийг энэ хөдөөгүүр явж байхад маш их юм ярьж байна шүү дээ. Дорнод аймгийн Чойбалсан сумын Минжүүрийн рашаан гээд тэр маш сайхан рашааны хажууд нүүрс ухаад эхэлсэн. Энэ чинь байгаль орчныг хамгаалж байгаа юм уу, яаж байгаа юм бэ?

Б.Бейсен: Хэдэн номер хариулах уу? 2 номер хариулъя.

М.Энхмэнд: Та бүхэнд энэ өдрийн амгаланг айлтгая. Гишүүний асуусан асуултад хариулъя. Таны хэлж байгаа зүйл нэг талаар маш үнэн сонсогдож байгаа. Тэгэхдээ бид хэд 2012 оноос хойш энэ үнэлгээний хуулиараа өдий хүртэл явсан. Миний бие 2020 онд 1000 орчим судалгаа хийсэн юм үнэлгээний тайлан дээр. Тэгэхээр багийн иргэдийн хурлын энэ баталгаажуулж байгаа процесс өөрөө асуудалтай байгаа юм гэдэг нь тайлангаас гарч ирсэн юм. Үндсэндээ яаж байна гэхээр одоогийн байгаа хуулиар улирал тутамд нэг удаа багийн хурал хуралдана. Тухайн улирлаар хэрвээ асуудлаа хэлэлцүүлж чадаагүй бол дахиад 3 сар хүлээнэ. Тэгэхээр жилдээ 4 удаа л багийн хурал болж байгаа юм. Энэ цаг хугацааны нэг асуудал байна.

2-т нь энэ асуудлаар багийн хурлаар энэ үнэлгээний тайланг хэлэлцэхдээ ямар асуудал тавьж байна вэ гэхээр дандаа ахуйн шинжтэй асуудлууд байгаа. Тэрнээс биш төслийн үр нөлөө, цаашдын ач холбогдлын талаар ярьж байгаа зүйл хийсэн судалгаагаар гарч ирэхгүй байгаа юм. Тэгэхээр ганцхан энэ талаас нь биттий хараач гэж.../минут дуусав/

Б.Бейсен: Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Би та нараас ганц асуултад л хариулт авах гээд чадахгүй байна. Ямар аймгийн, ямар сумын, ямар баг дээр очиж энэ талаар танилцуулга хийсэн бэ? Тэр уулзалтад оролцсон иргэд юу ярьж байна вэ? Хэзээ хийсэн танилцуулга вэ? Ахуйн юм ярьдаг хүн ер нь ховор болсон шүү. Одоо багийн иргэдийн нийтийн хурал

дээр очиход бол эд нар нэг байгаль орчны үнэлгээ хийх гэж нэг зөөлөн чихтэй юм ирсэн, тэгээд тэрийг нь бид ингээд итгээд дэмжсэн. Тэгээд л тэрнээс хойш ёстой газар нутгийг сэндийлж дуусаж байна. Яг ийм л гомдол тавьж байгаа шүү дээ. Тэгэхээр багийн ИНХ болдог, түүн дээр асуудлыг ярьдаг, дэмжихээ дэмждэг, дэмжихгүйгээ ч дэмждэггүй, заавал дэмжих ёстой ч биш. Тэгэхээр ингээд бүхэл бүтэн багийн ИНХ-ыг та нар зүгээр хэдхэн хүнээс санал авна, олон улсын жишиг нь ийм гээд, тэгээд яг тэнд ажиллаж, амьдарч байгаа ийм баг юман дээр очоод та нар танилцуулга хийсэн үү? Би нэг ч удаа сонсоогүй.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Яах вэ энэ багийн ИНХ-ыг байлгана гээд хэлэлцэх явцад гишүүд үзвэл оруулж болно. Гэхдээ яах вэ зүгээр энэ манай дээр ирж байгаа бүх гомдол, судалгаанаас үзэхэд багийн ИНХ улиралдаа нэг хуралддаг, ингэнгүүтээ улиралд хуралдахгүй тохиолдол маш их байдаг гэж байгаа юм. Тэгэхээр дахиад л 3 сар, 6 сар, ингээд 8 сар гээд энэ бизнес чинь явахгүй байгаа юм л даа. Тэгэхээр энэ хугацааг бид богиносгоё гэсэн юм. Багийн ИНХ байхад бол гишүүд байлгана гэж үзвэл энэ болохгүй юм байхгүй. Хугацаа нь үнэхээр бодолдоо та бүхэн 152 хоног болдог. Би салхин Салхит гээд манай сэргээгдэх эрчим хүчний компанийнхантай уулзаж байхад тэгж байгаа байхгүй юу. Бид энэ компанийг байгуулахын тулд 10 жил явсан, 296 гарын үсэг бид авсан гэж байгаа юм. Тэгэхээр ерөөсөө Монголд хөрөнгө оруулалт хийхэд маш хүнд байдаг. Бүх газар л нэг юм хүлээдэг, нэг юм хүлээдэг. Тэгээд сая хэллээ шүү дээ мянгаад хүнээс судалгаа авахад.../минут дуусав/

Б.Бейсен: Одонтуяа сайд гүйцээж хариулъя.

С.Одонтуяа: Мянгаад хүнээс судалгаа авахад мэдээж энэ байгаль экологийнхоо талаар ярьж байгаа хүмүүс байгаа. Гэхдээ дийлэнх нь дандаа ахуйн юм л хэлж байгаа гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг бид бодолцож үзэх ёстой. Бидний юм зүгээр энэ 152 хоногийг л богиносгоё гэсэн юм. Тэрнээс биш 3 ангилж байгаа шүү дээ. Үнэхээр ямар ч шаардлагагүй юманд заавал багийн ИНХ-ыг хүлээгээд байх ямар хэрэг байна гэж байгаа юм. Тэр хүн цахимаар юмаа өглөө, нэг муу жижигхэн лаборатори, нэг жижигхэн эмнэлэг, хувийн эмнэлэг, хувийн эмийн сан шууд, шууд ингээд цахимаараа мэдүүлээд л явчихъя гэж байгаа юм. Үнэхээр зайлшгүй шаардлагатай газар бол тэр 1 дүгээр зэрэглэлд оруулаад, энийг нь нэлээн шалгуур өндөртэй ийм зүйлийг хийлгэж байгаа.

2 дахь нь тухайн орон нутаг өөрөө шийддэг. Орон нутагтаа энэ хэр үр нөлөөтэй юм, энэ төсөл нь хэрэгтэй юм уу, хэрэггүй юм уу энийг орон нутаг өөрөө шийддэг байхгүй бол бүгдийг нь яаман дээр авчраад овоолчхож байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр зүгээр яах вэ ер нь бид энэ бизнесийн.../минут дуусав/

Б.Бейсен: Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Энд энэ хуулийн төслийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн төслийг оруулж ирсэн Байгаль орчны яамныхан хаанаас цалинждаг вэ та нар, хаанаас цалинждаг юм бэ? Төсвөөс биз дээ. Би эсвэл андуураад байгаа юм уу. Наад төсвийн чинь мөнгийг татвар төлөгчид бүрдүүлдэг юм шүү дээ. Та нарын наад яриад байгаа иргэдтэй уулзахаар ахуй юм яриад байна гэх юм. Ахуйгаа л ярина шүү дээ, өөр юу ярих юм бэ? Өмнөговь аймаг, Дорноговь аймаг, Говьсүмбэр аймаг миний сонгогдсон говийн бүсийнхэн яг энэ та нарын наад яриад байгаа нөлөөллийн бүсэд амьдардаг юм. Энэ иргэдийн эрх ашгийг

хамгаалсан заалт Үндсэн хуулийн 16.2-т байдаг юм. Би уншаад өгөх үү? Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй. Өнөөдөр малчин хүн, жирийн иргэн хүн төрсөн нутаг усандаа тайван сайхан амьдрах эрхтэй. Нөлөөллийн бүсэд биш шүү. Энэ Үндсэн хуулийн заалт энэ та нарын энэ оруулж ирж байгаа хууль дээр чинь зөрчигдсөн байна.

Та нар өнөөдөр юугаар бид нарын амыг таглах гэж орж ирж байгаа вэ гэвэл мэдээлэл нээлттэй, Монгол Улсын иргэн мэдэх эрхтэй гэдэг Үндсэн хуулийн заалтаар гуль барьж орж ирж байна. Зөв, орж ирэх ёстой. Гэхдээ яагаад эрүүл орчинд амьдрах эрхийг нь та нар зааж өгөхгүй байгаа юм бэ? Тэгээд багийн иргэдийн хурал хуралдах эсэхэд та санаа зовдог юм уу? Багийн иргэд яаж амьдардгийг мэдэхгүй байж. Та нар өчнөөн олон хуулиар, тэр 2 номерын микрофон дээр сууж байгаа хүн өчнөөн олон хэлэлцүүлсэн гэж байна. Багийн иргэдийн үгийг сонсохгүй болсон энэ заалтаа аль багийн иргэдээр хэлэлцүүлсэн юм бэ, хэн дэмжсэн юм бэ? Бид өнөөдөр тойргоос сонгогдсон гишүүд багт очиж ажилладаг. Яваад очихоор багийн иргэд өөр юм ярьдаг. Тэд нарын зөв байдаг. Тэд өнөөдөр усгүй болж байгаа, тэд өнөөдөр тоосжилтод амьдарч байгаа, уушгины архаг сүрьеэтэй болсон, хавдартай болсон, эмэгтэйчүүд нь жирэмсэлж чадахаа байсан. Энэ өвчний оношнуудыг хойш нь тавьчихъя. Зүгээр нутагтаа сайхан амьдарч чадахгүй, багаараа, сумаараа нүүх байдалд шилжсэн байна шүү дээ.

Гэтэл өнөөдөр бизнес сүйрлээ, бизнес болохоо байлаа, тэр иргэд юугаа ярьдаг юм, зөвхөн дарга нартай ганцаарчилж уулзаад шийдчихье гэсэн ийм хуулийн төсөл оруулж ирээд байдаг. Тэгээд энд нь зүгээр жагсаалтаар мөнгө, жагсаалтыг мөнгөөр худалдаад авчихсан Улсын Их Хурлын гишүүн үзэл санааны хувьд дэмжиж байна гээд сууж байдаг. БОХХАА-н байнгын хороонд дандаа прагматик гишүүд байдаг. Дандаа хөдөө орон нутгаас сонгогдсон, дандаа өмнө нь Засаг дарга байсан, сумын Засаг дарга байсан, багийн Засаг даргаас авхуулаад явчихсан ард түмнийхээ зовлонг мэддэг хүмүүс байдаг. Энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтийг унагаахыг уриалж байна би. Бид очоод өнөөдөр сонгогчдынхоо өмнө юу ч харж чадахгүй. Монгол Улсын иргэн өнөөдөр эрхээ.../минут дуусав/

Б.Бейсен: Мөнхбаясгалан гишүүнд 1 минут олгоё.

Л.Мөнхбаясгалан: Төр засагтаа өнөөдөр ард иргэд үгээ хэлж чадахаа больчихсон. Тэрийг нь та нар шууд авч хаяж байгаа юм байна. Иргэдийн оролцоо гэж юу юм бэ гэж яриад сууж байдаг, тэгээд иргэдийнхээ төлсөн татвараар цалинжиж байдаг ичээч та нар. Байнгын хорооны гишүүддээ дахиад уриалъя. Энэ төслийг Байнгын хороон дээр нь унагах хэрэгтэй. Дахиад бүр үзэл санаанаас нь өөрчлөх хэрэгтэй. Тэгэхгүй бол Монгол Улсын Үндсэн хуулийг дагалдах хууль болгож өөрчлөх гээд байгаа юм уу? Үзэл санааны хувьд бүхэлд нь дэмжихгүй.

Б.Бейсен: Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Асуудалдаа хэдүүлээ их зөв хандмаар байна л даа. Бид хэд байгаль орчноо хамгаалах чиг үүрэгтэй төрийн бүтэц нь байхгүй юу манай энэ Уур амьсгал, байгаль орчны яам бол. Ашиглагчийн зүгээс хандаад Үнэлгээний хуулиа биччихэж байгаа юм биш үү та хэд минь? Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны гэдэг юм уу, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тэр эрх ашгийн үүднээс энэ Үнэлгээний хуулийг биччихэж болох юм уу хэдүүлээ? Бид хэд яагаад энэ иргэд энэ асуудалд дургүй байна гэхээр байгаль орчны ерөнхий болоод нарийвчилсан

үнэлгээ энэ 30 хэдэн жилд яг хийх ёстой зүйлээрээ хийж, тэнд тусгагдсан дүгнэлт, зөвлөмжийг нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд нь яг тусгуулж, хэрэгжүүлэх үйл явц дутчихсантай холбоотой асуудал үүсээд байгаа байхгүй юу. Үгүй ээ тэгээд бид хэд энийгээ л харж хийх ёстой шүү дээ. Одоо та хэд тэр стратегийн гэнэ үү, төлөв байдлын гэнэ үү, хуримтлагдах нөлөөллийн гэнэ үү үнэлгээнүүд, одоо бүүр алийгаа алдсан юм хэлэх гэж байна шүү дээ хэдүүлээ. Уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшигтай холбогдуулж хийнэ, байгаль орчны нөхцөл, орчны онцлогийг нь харгалзуулж хийнэ. Дараа нь хам болоод давхацсан шинжүүдтэй нь уялдуулж хийнэ гэж. Энэ нь л арай нэг жоохон дөхөж ирж байгаа юм яг үнэнийг хэлэхэд.

Тэр цаадах уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн нөхцөл байдлаас үүдээд байгаль орчинд ямар нөлөөлөл ирэх юм гэдэг юм хийнэ гэж яриад байхаар чинь юу гэж ойлгох юм бэ? Тэр хэрэгжихгээд байгаа төсөлтэйгөө холбогдож ярих юм байгаа биз дээ. Үгүй ээ наадах чинь тэгээд мөн гэж ойлгох юм уу? Байгаль орчныг хамгаалах нарийвчилсан юу ерөнхий үнэлгээ, нарийвчилсан үнэлгээ. Ерөнхий үнэлгээгээрээ нарийвчилсан үнэлгээ хийхгүйгээр үйл ажиллагаа явуулж болох дүгнэлт бичиж болохоор, тэрийг нь бариад ажил явж болохоор ийм юм оруулаад ирж байна шүү дээ. Ерөнхий үнэлгээ бол ийм, ийм зүйлийг тодорхойлсон үнэлгээ байдаг. Нарийвчилсан үнэлгээ бол ийм, ийм зүйлийг илүүтэй тодруулж хийсэн үнэлгээ байдаг. Ерөнхий үнэлгээгээр гарч ирсэн ёстой та нарын хэлээд байгаа тэр байгаль орчин, тэр нөхцөл байдалтайгаа уялдсан байдалтай чинь холбогдуулж нарийвчилж хийдэг үнэлгээгээ бид нарийвчилсан үнэлгээ гэж хэлдэг биз дээ? Үгүй ээ яагаад тэгээд хэдүүлээ байхгүй байж болохоор ярьж байгаа юм.

Энэ ерөнхий болоод нарийвчилсан үнэлгээгээр хамрагдах гээд байгаа үйл явцаа та нар задалж хийсэн байна лээ. Тэр нь юу гэж байна гэхээр зэрэг ерөөсөө уул уурхайтай холбоотой үйл явцаа хэлж байгаа байхгүй юу. Үгүй ээ тэгээд тэр уул уурхай дээр чинь нарийвчилсан үнэлгээ хийгддэггүй юм уу? Зам.../минут дуусав/

Б.Бейсен: Батжаргал гишүүн 1 минут.

Ж.Батжаргал: Энэ ордыг ашиглаж болно, ашиглах гэж байгаа бол та нар замаа сайжруулах ёстой. Замаа сайжруулаагүй тохиолдолд энэ ажил явахгүй гэдэг юмаа л тэр нарийвчилсан үнэлгээндээ хийж өгч, түүнийг нь байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөндөө тусгадаг. Тэр төлөвлөгөө нь багийн ИНХ-аараа батлагддаг ийм зарчим яваа шүү дээ өнөөдөр. Гэтэл та хэд нөлөөлөлд хамрагдаж байгаа иргэдийн гэж. Тэр хэдийг хамруулсан, хамрагдаагүйг юугаар нотлох юм бэ? Яаж ч бодсон засаг захиргааны нэг нэгж нь баг байгаа байхгүй юу. Тэр хамт олон хуралдаад, тодорхой шийдвэр гаргадаг Үндсэн хуулийн статустай байгууллага байхгүй юу. Тэр чинь шууд ардчиллын байгууллага байхгүй юу. Тэрүүнийг нь давуулаад хэдүүлээ 5, 10 хүний тухай яриад, одоо наад уул уурхайн компаниудыг чинь мэднэ шүү дээ бид бүгд. Орчны бүсэд байж байгаа хэдэн хүнд хэдэн төгрөг тарааж өгөөд л, байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөгөө батлуулах гэж оролддог ерөөсөө л нэг ийм гажгийг нь энэ хуулиар бид бүүр баталгаажуулаад.../минут дуусав/

Б.Бейсен: Дараа тодруулаарай. Энэ ажлын хэсгийнхэн албан тушаал, юутай тодорхой хариулаарай, хурлын протоколд орох юм шүү. 4 номерын микрофон.

Г.Энхмөнх: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Энхмөнх. Тэгэхээр энэ яг хуулийн төслийн агуулгын хувьд уул уурхайн гэдэг

юм уу, замын төслүүдийн хувьд зөвхөн ерөнхий үнэлгээгээр шийдүүлнэ гэсэн ийм зохицуулалт байхгүй. Энэ дээр юу гэдэг юм яг томоохон төслүүдийн хувьд хуучин нарийвчилсан үнэлгээ хийгддэг, ерөнхий нарийвчилсан үнэлгээ хийгддэг, тухайн жилийн төлөвлөгөө батлагддаг, төлөвлөгөөнийхөө хүрээнд хийсэн ажлуудаа намар болгон дүгнүүлээд явдаг энэ процесс яг хэвээрээ байгаа. Яг хэвээрээ. Ингэснээрээ та өөрөө мэдэж байгаа байх. Орон нутаг өөрөө Засаг даргын захирамжаараа гүйцэтгэлийг хянадаг шалгадаг ажлын хэсгээ байгуулаад, ажлын хэсэг өөрөө гүйцэтгэлийг нь жил болгон дүгнээд ингээд явж байгаа. Үүн дээр үндэслээд харин хэдий хэмжээний газар нөхөн сэргээлт хийсэн юм, хэдий хэмжээний ажлыг хийсэн юм энэ бүх зүйл өөрөө цахим системд орчихсон, орон нутгаасаа автоматаар хянасан шалгасан акт нь ирээд явж байгаа. Энэ процесс дээр огт өөрчлөлт оруулаагүй.

Б.Бейсен: Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Бид адилхан төрийн алба хашиж байгаа улсууд хэн хэндээ илүү, дутуу юм яриад хэрэггүй. Би Одонтуяа сайдыг энэ хуулиа татаж аваад, эргэж та нэг бүрэн хар гэх гээд байгаа юм. Байгаль орчныг хамгаалдаг статустай төрийн захиргааны төв байгууллага нь үндсэндээ тусгай хамгаалалттай газар нутаг руугаа орох асуудлыг энэ хуулиар нээж өгч байгаа байхгүй юу. Хамгаалалтын захиргаа буюу эсвэл тухайн шатын Засаг даргын санал дээр тулгуурлаж гэж. Тэгж болохгүй шүү дээ хэдүүлээ. Угаасаа наад элдэв бусын үйл ажиллагааг чинь тусгай хамгаалалттай газар нутаг руу оруулахгүй гэж хаасан шүү дээ. Одоо та хэд энэ шигтгэсэн хувилбар дээр чинь байна. Би худлаа яриагүй. 7.3 дээр та хэд яг тэгээд оруулаад ирж байгаа байхгүй юу. Юу гэж орж ирж байна вэ гэхээр зэрэг тухайн хамгаалалтын захиргааны болон сум, дүүргийн Засаг даргын санал гэж ингэж оруулж ирж байгаа байхгүй юу. Болохгүй, хэдүүлээ Уул уурхайн яамны ажлыг энд хийх гээд хэрэггүй. Тэр.../минут дуусав/

Б.Бейсен: 4 номерын микрофон хариулъя.

Г.Энхмөнх: Батжаргал гишүүний тодруулгад хариулт өгье. Энэ хуулиар тусгай хамгаалалттай газар нутаг дээр ашигт малтмал олборлох, хайх гэдэг юм уу энэ асуудлыг нээсэн зүйл, заалт, зохицуулалт байхгүй. Зүгээр 7-гийн түүн дээр ямар заалт байна гэхлээр одоо тусгай хамгаалалттай газруудад аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа төслүүдийн хувьд тухайн хамгаалалтын захиргаанаасаа санал авах, тухайн жилийнхээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дүгнүүлэх ийм л зохицуулалт байгаа. Түүнээс юу гэдэг юм энэ хуулийн зохицуулалтаар тусгай хамгаалалттай газар нутагт уул уурхай гэдэг юм уу, бусад хориглосон үйл ажиллагааг нээж өгсөн заалт, зохицуулалт байхгүй.

Б.Бейсен: Одонтуяа гишүүн хариулъя.

С.Одонтуяа: Гишүүдийн энэ чинь байгаль орчны асуудалд хатуу, нэлээд шаардлага өндөр хандах ёстой гэдэг дээр санал нийлэлгүй яах вэ. Энэ салбарын сайдын хувьд. Зүгээр гол нь бид нэг ийм зүйл ярьж байгаа юм. Дэлхий даяараа ер нь бүгд хиймэл оюун ухаан руу шилжиж байна. Тэгэхээр бид юмаа зүгээр бүгдийг нь нэг сагсанд хийчхээд, тэгээд тэрийг нь бүгдийг нь ингээд өдөр болгон л 3, 4 нөлөөллийн үнэлгээ хийгдээд байдаг. Гэтэл энэ яг аль нь чухал юм, алин дээр нь онцгой анхаарах юм гэдгүүдээ л ер нь ялгаж, хариуцлагатай хандъя гэж байгаа. Жишээлэхэд тэр зүгээр цахимаар мэдүүлээд болчихдог нэг жижигхэн газруудыг тэгээд л үнэлгээ хийнэ, 152 хоног гээд л заавал багийн нийт мэдэхээ больё л гэсэн

юм. Тэр бизнес эрхэлж байгаа хүмүүс хөөрхий тэр нэг цахимаараа юмаа мэдүүлээд ажлаа хийж байг л дээ. Тэрийг чинь хянадаг газар нь байгаа, нэг жижигхэн нэг бичил бизнесүүд байдаг. 2 дахь нь орон нутаг энэ дээр өөрсдөө хариуцлага.../минут дуусав/

Б.Бейсен: Одонтуяа сайд гүйцээж хариулъя.

С.Одонтуяа: Өмнө нь ингээд бүгдийг ингээд яаман дээр овоолчихоор орон нутаг ч тэр заримдаа ингээд хариуцлага хүлээхгүй тал бий. Тэгэхээр энэ хуульд энэ орон нутаг ямар хариуцлага хүлээх юм, яаж хяналт тавих юм, хяналтын механизмыг ерөөсөө бүхэл бүтэн бүлэг оруулж өгсөн байгаа юм. Яаж хянах юм бэ гэдэг хянан магадлах юм бэ гэдэг 11 дүгээр зүйлдээ бүтэн оруулж өгсөн. Тэгэхээр би зүгээр ямар саналтай байна гэхээр энэ хуулиа буцаах амархан. Ингээд нэгэнтээ ангилна гэсэн. Яг энэ зайлшгүй энэ гишүүдийн санаа зовоод байгаа энэ байгаль орчныг чинь сүйтгэдэг юм, замыг нь муухай болгодог юм. Тэр байгаль орчныг хэдхэн хүн шийдээд байдаг юм гэдэг энэ том төслүүдээ яаман дээрээ тэр шийддэгээр нь шийдээд, тэр хамаагүй багийн иргэдийн нийтийн хурлыг нь оруулъя гэж байгаа бол оруулаад ингээд тэрнийхээ шаардлагыг өндөрсүүлье гэж байгаа юм. Тэрнээс биш бүгдийг нь ингээд нэг сагсанд хийчхээд, 700, 800 хүнийг яачхаад, ингээд жижгүүдийг нь бүгдийг нь энд хамрагдаад байхаар бизнес явахгүй байна л гэсэн санаа.

Б.Бейсен: Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Та хэд 7.2-оо уншаарай. 7.2-оор ерөнхий үнэлгээ хийх ёстой этгээдүүдийн чинь эрхлэх үйл ажиллагааны юм нь их тодорхой заагдсан шүү. Тэр бол ер нь үндсэндээ ашигт малтмалтай холбоотой харилцаа, аж ахуйн зориулалтаар газар эзэмшихтэй холбоотой асуудлыг л хөндсөн. Тэгээд та хэд 7.3-аараа тусгай хамгаалалттай юуныхаа захиргааг оруулаад ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр чинь болж байгаа юм уу, үгүй юм уу? Зүгээр би илүү, дутуу олон юм яриад баймгүй байна. Хэдүүлээ энэ байгаль орчны үнэлгээг хийж ирсэн энэ нэг байдалдаа жоохон дүн шинжилгээ хийгээд, сургамж нь юу байгаа юм бэ гэдгээ хараад, тэгээд энэ хуульдаа л тусгаж авах хэрэгтэй. Тэр.../минут дуусав/

Б.Бейсен: Асуулт, хариулт байхгүй тийм ээ, санал хэлсэн үү? Ганбаатар гишүүн асуулт асууя.

Г.Ганбаатар: Би энэ хуулийн тэр нэг байгальд шаардлагагүй тэр шаардлагагүй гэдэг юм уу, байгаль орчны үнэлгээг нь ангилж байгааг дэмжиж байна. Тэр 1 дүгээр зэрэглэл нь зайлшгүй шаардлагатай нь Байгаль орчны яам гэнэ үү, 2 дугаар зэрэглэл нь аймаг, орон нутаг гэнэ үү энэ бизнес эрхлэгчдэд жоохон тэр байгаль орчныхоо орчинд нөлөөлөх үнэлгээнийхээ тухай энэ хуульд оруулж ирж байгаа гол агуулга нь энэ дээрээ байгаа юм болов уу жоохон гэж нэг талаасаа харж байна.

Нөгөө талдаа энэ танай яамнаас оруулж ирж байгаа хууль чинь Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Ашигт малтмалын тухай хуульд шинэчилсэн найруулга хийх нэг ажлын хэсэг байгаа. Тэрний өмнөөс биччихсэн байна. Энэ тэр ажлын хэсэгт нь би өөрөө байгаа юм л даа. Тэр ажлын хэсэг дээр яг энэ яригдаад байгаа орон нутгаас санал авах, багийн иргэдийн юунуудаас санал авах, ер нь орон нутгийн оролцоо ямар байх вэ гэдэг талаас нь маш их яригдаж байгаа байхгүй юу. Одоо бид чинь яг энэ өнөөдөр ингээд Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүдийн ярьж байгаа юм бол хөрөнгө оруулалт нэн

тэргүүнд чухал уу, эсвэл хөдөө орон нутагт малаа маллаад ажиллаж, амьдарч байгаа иргэдийн амьдрах орчин чухал уу гэдэг тухай л ярьж байна шүү дээ. Энэ асуудал дээр уг нь танай яам тэр байгаль орчин хамгаалал тал дээрээ байх нь зөв байх.

Миний асуулт та нар энэ Ашигт малтмалын тухай хуулийн төсөлд шинэчилсэн найруулга хийж байгаа ажлын хэсгийн явж байгаа төслийг олж харсан уу? Түүнтэй наад оруулж ирж байгаа ажил чинь хэр уялдаж байгаа вэ? Энийг үзсэн хүн байна уу? 1 дүгээрт нь асуултаа асуугаадахъя.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 4 номерын микрофон.

Г.Энхмөнх: Ашигт малтмалын тухай хууль дээр тэр орон нутгаас санал авч байгаа зохицуулалт бол хайгуулын тусгай зөвшөөрлийг олгоход санал авч байгаа зохицуулалт. Тэр утгаараа Үнэлгээний тухай хуулийн хувьд олон нийтийн оролцоо хангахтай холбоотой л зохицуулалт байгаа. Тэгэхлээр энэ 2 зүйл бол санал авах процесс шал өөр 2 юм байгаа. Тийм учраас тухайн одоо бидний оруулж ирж байгаа хуулийн төсөл тэр Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн боловсруулсан хуулийн төсөлтэй зөрчилдөх тийм зохицуулалт байхгүй. Нийцэж байгаа. Ер нь юу гэдэг юм бид хэд энэ хуулийн хүрээнд 47 холбогдох хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж үзсэн. Ингээд үзэхэд үндсэндээ бусад хуулийн төслүүдийн хувьд нэршлийн хувьд ямар байгаа юм, цаашдаа нэршлийг яаж бусад хууль тогтоомжтой нийцүүлэх вэ гэдэг асуудал байж байгаа. Энэ хүрээнд яг Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу ер нь үндсэн энэ хууль дээр нь нэр томьёог тодорхойлоод, бусад хууль тогтоомж дээр байгаа нэр томьёог түүнтэй адилтгах байдлаар ойлгоно гэсэн байдлаар оруулсан учраас бусад 47 хууль тогтоомжид байгаа нэршлийн хувьд энэ нэр томьёонд оруулж байгаа өөрчлөлттэй нийцээд явна гэсэн ийм ойлголт байгаа.

Б.Бейсен: Ганбаатар гишүүн тодруулъя.

Г.Ганбаатар: 2 дахь асуулт нь энэ орон нутгаас санал авахыгаа 10 хоног гэж оруулж ирж байгаа юм уу? Хуучин сар байсан гэж ярьсан уу, тэгээд түүнийгээ бүүр богиносгож байгаа юм уу? Энэ дээр ингэдэг юм. Тэр саяын яриад байгаа зүйл чинь нөгөө ашигт малтмалын хайгуул дээр санал авах эд нар чинь хуучин нэг сар байсан юм. Намайг лав Дорноговь аймгийн хурлын дарга хийж байхад. Тэгээд сар нь яадаг вэ гэхлээр тэр бичиг нь их тулгуу ирдэг байхгүй юу. Нэг тулгуулж ирээд санал авсан болоод, эсвэл хугацаа хэтэрвэл орон нутгийг санал дэмжсэнд тооцоод шууд автоматаар орон нутгийн оролцоог хангахгүйгээр шууд дээрээсээ төрийн захиргааны төв байгууллага нь олгодог байсан юм. Одоо энэ дээр ямар зохицуулалт орж ирж вэ 10 хоног гэж орж ирээд, магадгүй сүүлийн 2 хоног ч юм уу, эсвэл хугацаа нь тулган ирээд, тэгээд орон нутаг нь ямарваа нэгэн байдлаар саналаа өгөх боломжоор хангагдаагүй байх үед нь та бүхнийг санал авсан гэж ойлгохоор орж ирж байгаа юу хууль, эрх зүйн зохицуулалт нь?

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 4 номер хариулъя.

Г.Энхмөнх: Тухайн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоног гэж байгаа юм. Тэгэхлээр үндсэндээ энэ яг хуанлин хоногоор бодоход 14 хоног л гэсэн үг. Нөгөө талаасаа энэ дээр бид нэг тодорхой болгож оруулж ирсэн юм нь тухайн хүсэлт гаргахдаа ямар бичиг баримтын хүрээнд ямар агуулгатай байх вэ гэдгийг нь тодорхойлж өгсөн. Энэ дээр нэг жишиг байж байгаа. Тухайлбал энэ Засаг даргын

санал өгөх хүрээнд Хан-Уул гэдэг юм уу, Баянзүрх дүүргийн хувьд 17-гоос 20 төрлийн бичиг баримт шаардаж байгаа ийм тохиолдол гарсан. Тухайлбал энүүгээр нөгөө хуулиар тодорхой хамрах хүрээг нь зохицуулалт хийж өгөөгүйтэй холбоотойгоор хамааралгүй бичиг баримт нэхэх ийм асуудал энэ хэрэгжилтийн судалгааны явцад гарч ирсэн байж байгаа.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хууль санаачлагчийн танилцуулгатай холбогдуулан санал хэлэх гишүүн байна уу, нэрс өгнө үү? Уянга, Сэддорж гишүүн, Замира гишүүнээр тасаллаа. Уянга гишүүн асуулт асууя, үг хэлье.

Б.Уянга: Ер нь энэ хуулийг орж ирэхэд нэлээн хүлээлт өндөр байсан. Тэгээд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамныхны ярьж танилцуулж байсны хүрээнд бол бас мөн батлагдаж, сая өнөөдөр танилцуулагдсан, гишүүдэд тараагдсан үзэл баримтлал ч тэр яг уншаад үзэхээр бодит байдлуудыг тусгасан, тэгээд яг тэр чигээрээ хэрвээ хуулийн төсөлдөө агуулга нь ороод ирчихсэн бол их зүгээр байх байсан юм болов уу.

Төслүүдийг зэрэглэл 1, 2, 3-д хувааж байгааг дэмжиж байгаа. Гэхдээ яг энэнийх нь тодорхойлолт нь байхгүй байгаа учраас нэг тийм журамд хэтэрхий хүч өгчих ийм асуудлыг өөрийн зүгээс түрүүн ойлгуулахыг оролдлоо. Цахимжуулж байгаа асуудлыг дэмжиж байгаа. Тэгэхдээ хуулийн төсөлдөө яг үг заалтдаа хэрхэн суусан нь нэлээн сул байгаа ажиглагдаад байгаа. Тэгээд байгаль орчноос гадна нийгмийн үнэлгээг оруулж ирж байгаа нь дэвшил юм. Тэгээд энэ үзэл баримтлалыг Одонтуяа сайдаас гадна, Хууль зүй, дотоод хэргийн сайд Алтангэрэл сайд баталсан байгаа учраас Үндсэн хуулийг зөрчсөн гэж бол үзэхгүй байгаа. Тэгэхээр яг энэ үзэл баримтлалыг нь уншаад үзэхэд их дэвшил байгаа мөртөө яг хууль нь төсөлдөө асуудлууд байна гэж харж байна.

Түрүүн олон гишүүд энэ санал авах процесс асуудалтай байна гэж хэлж байна. Магадгүй энэ нь 10.5-д энэ хөндөж орж ирсэн заалт байгаа байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулна гээд. Тэгэхээр бүх л иргэдтэй уулзаад санал аваад, тайлангаа танилцуулна гэдэг нь энэ 10.5 гэдэг танай хөндөж орж ирсэн заалтад суусан байна гэж харсан юм байгаа юм. Тэгэхээр бүгдээрээ яг энэ оруулж ирсэн хуулийн төслийг нэлээн сайн үзэх хэрэгтэй байсан. Гэхдээ яг төслийн нөлөөлөлд өртөх иргэн гэж хэнийг хэлэх юм бэ гэсэн тодорхойлолт байхгүй. Ямар ч хууль дээр байхгүй шүү дээ. Бүс гэдэг тодорхойлолт байхгүй. Тэгээд бүгдийг нь аргачлалаар батлах юм гэж оруулж ирж байгаа нь нөгөө журмыг бид багасгая, хуульдаа оруулъя, хүн төвтэй байлгая гээд байгаа тэр зарчим алдагдаад байх шиг ийм бодолтой байна. Тэгэхээр нөлөөлөлд өртөх иргэн гэж хэнийг хэлэх вэ, аливаа нэг төслийн нөлөөлөлд өртөж байгаа бүс гэж алийг хэлэх вэ. Тэгээд зөвхөн уул уурхай төслөөр хязгаарлагдахгүй гэдгээ бүгдээрээ хаана хаанаа ойлгох хэрэгтэй байна.

Энэ нийгмийн үнэлгээ, байгаль орчин, нийгмийн үнэлгээ хийдэг болно гээд тэгж байгаа. Тэгсэн мөртөө 7.6-д нөгөө шинжээчдээ тавьж байгаа шаардлага нь байгаль орчны чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан байх ёстой гээд үндсэн шаардлага нь байгаа байхгүй юу. Нийгмийн нөлөөллийн үнэлгээний асуудлаар ямар үүрэг, ямар шаардлагыг хангасан байх ёстой юм бэ гэдэг агуулга дурдаагүй. Гэхээр нэг нийгмийн нөлөөллийн үнэлгээг хийнэ гэж байгаа мөртөө яг холбогдох шинжээчид нь тавих шаардлага нь орж ирээгүй байх шиг. Тэгэхээр яг энэ Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтарч баталсан үзэл баримтлалынхаа хүрээнд хуулийн

төслийн нэмэлт, өөрчлөлтийг илүү сайжруулах ёстой юм шиг байна. Тэгэхгүй бол энэ чигээр нь дэмжээд явчихвал гишүүдэд л бөөн ажил гарна. Тэгээд яг та хэдийн зохион байгуулсан хэлэлцүүлэгтэй адилхан хэлэлцүүлгүүдийг зохион байгуулаад явахад асуудал үүснэ. Тэгэхээр яг энэ үзэл баримтлалдаа нийцүүлээд хуулийнхаа төслийг сайжруулж орж ирэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Б.Бейсен: Замира гишүүн үг хэлье.

С.Замира: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ хуулийн төслийг дэмжиж байна. Яагаад дэмжиж байна гэхээр нь манай эдийн засаг ямаршуу байгаа билээ, Алт хөтөлбөр 3 гээд 3Г нь юу баталсан байдаг. Тэр байгаль орчны үнэлгээ, тэгээд энэ алт хөтөлбөрийн ажил яг уялдаа холбоотой байдаг байхгүй юу нэг нэгэндээ. Яг ажил хийе гэхээр нь нөгөө багийн Засаг дарга нь, багийн хурал нь олдохгүй, хуралдахгүй. Энд зөндөө зовлон байгаад байдаг. Энийг яагаад уул уурхайн энэ салбарт холбоод ярьж байгаа гэхээр би уул уурхайн нөгөө ажлын хэсэгт, 3 ажлын хэсэгт ажиллаж байна л даа. Тэнд нэг хуулийн өөрчлөлтүүд орж ирэх гээд байна. Тийм учраас энд одоогийн Монгол Улсын байдал ямар байгаа билээ, бид улс төржих газарт нь улс төржих ёстой, улс төржих ёсгүй газарт нь анхааран ажиллах ёстой. Тийм учраас эдийн засгаа сэргээхийн төлөө ганц боломж уул уурхайн салбар болчихоод байна шүү дээ. Тэгэхээр аль болох яам, холбоотой яам, агентлагууд нэг нэгэндээ холбоотой байж, нэг нэгийнхээ оруулж ирэх гэж байгаа хуулийг нь судалж, тэгээд Хууль зүйн яамтай зөвшилцөж, Үндсэн хуулийг зөрчиж болохгүй, тэгээд энэ бүгдийг нь хоорондоо ярилцаж байгаад энэ хуулийг дахиад зарим нэг заалт нь зөрсөн зөрөөтэй байвал тэрнийг нэг дахиж янзлаад оруулаад ирсэн нь дээр байх гэж би бодож байна.

Тэгээд багийн нөгөө хурал гэдэг нь яг Одонтуяа сайдын ярьж байгаа нь үнэн байхгүй юу. Нэг улиралд хуралдвал хуралдана, хуралдахгүй бол байхгүй тэгээд. Тэгээд нөгөө хүмүүс нь тэгээд чирэгдээд яваад байдаг. Тийм учраас манай улс лиценз өгсөн гээд сая нөгөө уурхай яриад байна шүү дээ. Лиценз өгсөн бол тэрнийг хамгаалж ажил хийлгэх боломжоор хангаж өгөх ёстой. Тэр манай, миний ажиллаж байгаа нөгөө ахалж байгаа 42 дугаар зүйл дээр ашигт малтмалын орон нутагт тэр лиценз эзэмшигчид нь багийн, сумын Засаг дарга, тэгээд аймгийн Засаг дарга нэг бүрчлэн орон нутагтаа ямар ажил хийж өгөх вэ, ажилгүйдлийг яаж арилгах вэ, яаж тус хүргэх вэ гэдэг гэрээг шинэчлэх гээд явж байна. Том ажлын хэсэг явж байна энд. Тэгэхээр энэ дээр бид та бүхэн би гишүүдээс хүсэлт тавимаар байна. Энийг сайн судлаад болохгүй нэгийг нь яах вэ өөрчилж болно. Тийм учраас уян зөөлөн хандаад энэ хуулийг ер нь баталж өгөх нь зүйтэй байх гээд, дэмжиж өгөх нь зүйтэй байх гээд та бүхэнд саналаа хэлж байна. Баярлалаа.

Б.Бейсен: Отгонбаяр гишүүн үг хэлье.

У.Отгонбаяр: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Энэ яах аргагүй нийгэмд хүлээгдэж байгаа ийм хууль. Энийг засаж сайжруулах ёстой. Ер нь аливаа хуулийн шинэчилсэн найруулга гэдэг өөрөө ер нь дордуулах биш, дээшлүүлж сайжруулж хуулийн төсөл орж ирэх ёстой гэж ойлгодог. Тэгээд түрүүн манай Байнгын хорооны гишүүд хэлж байна. Манай Байнгын хорооны гишүүд ихэнх нь ер нь дийлэнх олонх нь бүгд л хөдөө орон нутгаас сонгогдсон, орон нутгийн зовлон, жаргалыг мэддэг ийм гишүүд зонхилдог. Тийм учраас энэ дээр гишүүн болгон өөрсдийнхөө санаа бодлыг ний нуугүй, илэн далангүй л ярьж байна. Тэгээд яах вэ энэ хууль маань би нэг л зүйлд жоохон санаа зовних маягтай байна. Энэ хуулиа дагаж гарах дүрэм журам нь илүү бараг

хуулийнхаа дээр шахуу болох ийм хэмжээнд очих вий. Энэ дээр та бүгд маань анхаараарай. Тэгээд юу гэдэг юм ингээд шууд баталчих гэж байгаа биш, засаж залруулах юмнууд нэлээдгүй гарах байх. Тэгээд санаагаар болдог байсан бол уг нь Байнгын хорооныхоо гишүүдийн дунд, дээрээс нь сонирхсон Их Хурлынхаа гишүүдийн дунд нэг сайхан нээлттэй хэлэлцүүлэг нэг хийчихсэн бол их зүгээр байх байж. Тэгвэл түүн дээр нэлээн тийм болох, болохгүй юмаа тал талаас нь сайн ярилцаад, үг үсэг дээр нь бүр нэгд нэгэнгүй зүйл, заалтаар нь ярилцах энэ боломж байх байсан байх гэж бодож байгаа. Гэхдээ энэ хэлэлцүүлэг оройтоогүй байх гэж би бодож байна.

Дараагийн нэг хэлэх санал тэр санал авах дээр хоног хугацааны хувьд их л тийм түргэн шуурхай болгох зорилготой 30 хоногийг багасгасан байх л даа цаад санаа нь. Гэхдээ тэр багаас, сумаас авдаг тэр санал тэр өөрөө их чухал шүү, чухал. Ний нуугүй хэлэхэд тэгээд л цагийг нь тулгаж нэг бичиг явуулчихаад л тэр нь зарим нэг нь ний нуугүй хэлэхэд санаатай, санаагүй бичгийг нь гацаадаг, бараг 5 дахь өдөр өгөөд, тэгээд нэг дэх өдөр хугацаа нь дуусаад, тэгээд дэмжсэн болоод л явчихдаг тийм зүйл яг амьдрал дээр байдаг юм шүү. Тэрийг Байгаль орчны яам маш сайн мэдэж байгаа, мэдэхийн дээдээр мэдэж байгаа. Тийм учраас энэ бүгдийгээ хэдүүлээ нэг арай нэг амьдралд ойрхон, ард иргэд рүүгээ чиглэсэн, ард иргэдийнхээ сайн сайхан амьдралыг нэгд нь тавьсан, нэн тэргүүнд тавьсан ийм хуулийн төсөл уг нь Улсын Их Хурал руу ороод батлагдвал аль, аль талдаа маш хэрэгтэй зүйл. Хүн гэдэг зүйл номер нэгд л байх ёстой. Хүн бол номер нэгд байх ёстой. Тийм учраас бид бүхэн энэ дээр онцгой анхаарч, хамтарч нийлж, нэгдэж ажиллахад болохгүй юм байхгүй гэж санал хэлье. Баярлалаа.

Б.Бейсен: Сэддорж гишүүн үг хэлье.

Р.Сэддорж: Энэ хуулийн төсөл яг цаг үе нь их тулчихсан, зайлшгүй хийх ёстой ийм өөрчлөлтүүд ороосой гэж хүсэж байна. Тэгээд энэ хуульд эргэж анхаарч, Байгаль орчны яам оруулж ирж байгаад баярлаж байна. Өнгөрсөн энэ хуулийн өнгөрсөн хугацаанд ямар олон төслүүд хэрэгжив. Алдаатай ч төслүүд байгаа, оносон төслүүд ч байгаа. Мэдээж уул уурхай дээр энэ Монгол Улсын маань эдийн засаг тогтож байна. Ялангуяа зэс, алт, нүүрс гээд бусад уул уурхайн салбараас гарч байгаа энэ бүтээгдэхүүнээр Монгол Улсын маань төсөв бүрдэж байгаа. Тийм учраас бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй гэдэг шиг бүгдээрээ хэлэлцэж байгаад энэ 126 гишүүнтэй парламент энэ өргөн олон Их Хурлын гишүүнтэй парламентаараа хэлэлцээд ингээд сайн өөрчлөлтүүдийг оруулах хэрэгтэй байх.

Тэгээд алдсан зүйлүүд нэлээн их байгаа. Жишээ нь Өмнөговь аймгийн Цогтцэций сум Монгол Улсын төсөвт Тавантолгойн бүлэг ордын нөлөөлж байгаа үлэмж их нөлөө байгаа. Тэрний хажуугаар тэр малчид амьдрах аргагүй, малын дотор гэдэс идэхийн аргагүй тийм чулуужчихсан, тэгээд 5 цулын шөл уух тийм аргагүй болсон. Тэгээд мал нь бүгдээрээ уушгины өвчтэй, хүн нь бүгдээрээ тоосны харшилтай, тэнд байгаа бүх хүн тоосны харшилтай. 3, төрсөн хүүхдээс авхуулаад тэгээд 80 настай эмээ хүртэл тоосны харшилтай. Тэгээд малын бэлчээр нь 2 төмөр зам, 3 авто замаар бүрэн хуваагдчихсан. Тэрийг давж явах барихад маш хэцүү ийм байдалтай байгаа. Тэгэхээр Байгаль орчны яамныхан маань энэ одоо байгаа энэ тэр юунууд дээрээ, одоо байгаа кэйсүүд дээрээ, одоо байгаа нөхцөл байдалтайгаа өөрсдийн биеэр маш сайн очиж танилцаад, энэ хууль дээр юу юуг өөрчлөх ёстой юм бэ гэдэг дээрээ нэг даруйхан дориухан өөрчлөөд явах хэрэгтэй байх.

Усан дээр байна тийм ээ, ус маш хямдхан учраас уул уурхайнхан усыг маш ихээр хэрэглэж байна. Тэр хямдхан учраас төсөвт орон нутгийн төсөвт төдийлөн усны төлбөр нь өндөр орж ирдэггүй. Усыг 600-аас 800 литр секунд хэрэглэж байгаа шүү дээ уурхайнууд нэг уурхай гэхэд л. Тэгэхээр энэ сэргээгддэггүй баялаг болсон усыг усны үнийг цаашдаа яах ёстой юм бэ? Ус үнэхээр тэр гүний усаар баяжуулсан үйлдвэрүүд үнэхээр үр дүнгээ өгч байгаа юу? Тэр усыг орлох бүтээгдэхүүн байгалийн баялаг гэж байхгүй байх. Тэгэхээр энэ дээр цаашдаа усны үнэ цэнийг ядаж ард иргэдийн хэрэглэж байгаа үнээс өндөр үнэтэй байж үйлдвэрүүд маань усаа хэмнэх тухай бодох байх. Гадаргын усыг аваачих тухай бодох байх. Тэгээд энэ зүйлүүд дээр анхаараарай.

Тэгээд энэ олон гишүүд хэлж байгаа багийн иргэдийн хурлын шийдвэрийг их төвөгшөөхгүйгээр оруулах хэрэгтэй. Тийм учраас багийн иргэд нь дэмжихгүй бол тэр ямар нэгэн төслийн хувь заяа ерөөсөө цаашдаа явахгүй маш харгис уул уурхай болчихож байгаа юм. Тийм учраас их төвөгшөөхгүйгээр яаж багийн иргэдийн хурлын шийдвэр гаргуулж байх юм энэ дээр бодож, шинэ хувилбаруудыг гаргаж ирээрэй гэж хүсье.

Б.Бейсен: Байгаль орчны нөлөөллийн байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай оруулах тухай хуулийн төслийг хэлэлцлээ. Ажлын хэсгийнхэн гишүүдийн асуултад тодорхой хариулахгүй байна. Ер нь цаашдаа энэ чуулганаар орно. Нөгөө талаар сая Сэддорж гишүүний ярьж байгаагаар хүн, мал, ан амьтанд нөлөөлж байгаа нөлөөлөл нь нэлээн сөргөөр нөлөөлж байгаа асуудлууд байж байгаа. Энэ 7.9 дээр яах вэ зэрэглэлээр хуваасан асуудал байж байна л даа 3 зэрэглэл 1, 2, 3 гээд л, энэ сайн байна.

Нөгөө талаар энэ 6.7 дахь заалт, 7.7 дугаар заалтуудыг нь сайн хараад найруулгын юун дээр анхаарахгүй бол зөвхөн хугацааг нь наашлуулснаар хуучин сарын дотор гэж байгаа бол одоо 15 хоногийн дотор гээд наашлуулаад уул уурхайн талынхандаа юутай хандаж болохгүй нь. Нөлөөллийн асуудал дээр бид онцгой анхаарах ёстой. Тийм учраас энэ дээр анхаарч ажиллаарай гэж хэлье. Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явагдана.

Байгаль орчны нөлөөллийн байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёолоор санал хураалт явуулна. Санал хураалт, гишүүд түрүүн Их Хурлын чуулган дээр заасан энэ юун дээр анхаарч яагаарай. Санал хураалтын бэлэн байдал. Сэддорж гишүүн.

Р.Сэддорж: Хэлэлцэх эсэх тухай тийм ээ, тийм. Тэгээд энэ хуулийн төслүүдийг чинь бүр ажлын хэсэг гаргаад бүр 3 жил ч хэлэлцсэн юу байдаг шүү дээ ажлын хэсгээрээ. Тийм учраас энэ ажлын хэсэг байгуулаад явах хэрэгтэй байх гэж бодож байна. Энэ дээр л ажиллах, энэ бол хамгийн чухал хууль байхгүй юу. Тэгье.

Б.Бейсен: Энэ хэлэлцэх эсэхийг шийдсэний дараагаар тэгээд ажлын хэсэг байгуулагдлаа. Санал хураалтын бэлэн байдлыг хангая. Санал хураалт. 23,5 хувиар санал дэмжигдсэнгүй. Чуулганы нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны санал, дүгнэлтийг Замира гишүүн танилцуулна. Нэг дэх асуудал дууслаа.

Хоёр.Малын генетик нөөцийн төлөв байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох

Дараагийн асуудалд оръё. 2 дахь асуудал. Малын генетик нөөцийн төлөв байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ХХААХҮ-ийн сайдын мэдээллийг сонсьё.

Ж.Энхбаяр: Байнгын хорооны эрхэм гишүүд та бүхэнд өдрийн мэндийг хүргэе. Энэ удаагийн мэдээллээр Монгол Улсын малын генетик нөөцийн байдал болон 2025 оны мал төллөлтийн талаар танилцуулах болно. Монгол Улсын мал сүрэг 2024 оны жилийн эцсийн нийт дүн 57,6 сая толгой тоологдсоны 4,7 сая нь адуу, 5,1 сая нь үхэр, 480,6 мянга нь тэмээ, 24,5 сая нь хонь, 22,9 сая нь ямаан сүрэг байна. Нийт мал сүргийн дотор хонь 42,5 хувь, ямаа 39,8 хувь, үхэр 8,8 хувь, адуу 8,1 хувь, тэмээ 0,8 хувийг тус тус эзэлж байна.

Манай орны байгаль, цаг уурын уур амьсгалын онцлогт дасан зохицсон хонины 15 үүлдэр, ямааны 9 үүлдэр, үхрийн 5 үүлдэр, тэмээний 5 үүлдэр, адууны 3 үүлдэр батлагдаж, сайжруулагч үндсэн цөм сүргээр тус тус ашиглагдаж байна. Танилцуулгыг явуулаарай. Тэнд явж байгаа. Монгол Улсад өсгөн үржүүлж байгаа нийт мал сүргийн 96,2-оос 99,7 хувийг манай Монгол Улсын уугуул үүлдэр омгийн мал, 0,3-аас 3,8 хүртэл хувийг гадаад улсаас импортолсон цэвэр үүлдрийн болон тэдгээрээр сайжруулсан эрлийз мал тус тус эзэлж байгаа.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Биологийн олон янз байдлын конвенцод Монгол Улс 1993 онд нэгдэн орсон. 2017 онд Малын генетик нөөцийн тухай хуулийг баталснаар малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээг малын төрөл тус бүрээр 3 жил тутам шинэчлэн хийж, үр дүнг ЗГ-т танилцуулан улмаар НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуй генетик нөөцийн хороонд хүргүүлдэг болсон. Монгол Улс малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээг олон улсын аргачлалын дагуу анх 2000 онд хийсэн бол сүүлд 19-өөс 20 онд шинэчлэн сайжруулж, НҮБ-д тайлагнасан болно.

Малын генетик нөөцийн үнэлгээнээс үзэхэд Монголын уугуул үүлдрийн үхэр, тэмээ, хонь, ямааны генетик тогтоц ашиг шимийн хувьд эрсдэлгүй, адууны 30,8 хувь ашиг шимийн чиглэлийг нарийвчлан тогтоох шаардлагатай гэж шинжээчид дүгнэсэн. Өөрөөр хэлбэл манай орны уур амьсгалын нөхцөлд дасан зохицсон үхэр, тэмээ, хонь, ямаан сүргийн хувьд гений өвөрмөц тогтцыг хадгалахад тооны хувьд хангалттай популяц байгаа бөгөөд ашиг шимийн чиглэлийг нь харьцангуй тогтвортой хадгалагдаж байна. Харин нийт адуун сүргийн 31 орчим хувь нь ашиг шимийн чиглэл болон генетик шинж тэмдгийн нарийвчилсан судалгаа явуулж дараах дүгнэлтийг гаргах шаардлагатай. Учир нь сүүлийн 20 жил нийтдээ Монгол Улсад 5200 орчим англи, араб, Ахалтекин, Будённые, Орлов, Кабардин, Хатирч, Оросын хатирч зэрэг үүлдрийн адууг гадаад улсаас импортоор авч, Монголын адууны хурдлах чадварыг нэмэгдүүлэх чиглэлтэй үржүүлгийн ажил явуулсантай шууд холбоотой ийм үзүүлэлт гарч байна.

Бусад төрлийн, бусад төрлийн малын тухайд гадаад улсаас авч цэврээр үржүүлж байгаа болон үндсэн сайжруулагчаар ашиглаж байгаа шинээр зохион бүтээсэн үүлдэр омгийн малын тоо толгой цөөрсөн, ашиг шим нь буурсан, генетик тогтцын зарим шинж тэмдэг өөрчлөгдсөн байх магадлалтай, эрсдэлтэй гэж дүгнэсэн. Ялангуяа Монгол Улсад үржүүлж буй үүлдэр омгийн хонины 18,5 хувь нь

эрсдэлийн түвшинд байна. Эрсдэлийн түвшинд байгаа үүлдэрт нарийн нарийвтар ноост тал нутгийн цагаан, бүдүүн, бүдүүвтэр ноост Байдраг үүлдэр, Алтанбулаг, Жаргалант үржлийн хэсэг, торгууд үүлдрийн хэсэг, буржгар хурганы арьсны сүмбэр үүлдрийн хонийг эрсдэлийн түвшинд багтаасан байна. Эдгээрээс 2025 оны 5 дугаар сарын байдлаар Байдраг үүлдэр, Жаргалант үүлдрийн хонины хэв шинжийг хадгалсан бодгаль улсын бүртгэлд бүртгэгдээгүй байна.

Ямаан сүргийн уугуул үүлдрээс 15 үүлдэр омгийн 86,7 хувь нь эрсдэлгүй, 13,3 хувь нь эрсдэлийн түвшинд гэж дүгнэгдсэн. Эрсдэлийн түвшинд байгаа үүлдэр, омогт ма..., ноосны чиглэлийн өнжүүл, үржлийн хэсэг, ноолуурын чиглэлийн гал шар омог тус тус багтсан байна. Цаашид ямааны тоог аажим бууруулж, 20 сая орчим нь барих, ямаан сүргийн генетик нөөцийг оновчтой ашиглах, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулах, экспортод чиглэсэн ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг баримтлахыг зөвлөсөн болно.

Эрхэм гишүүд ээ, Мал сүргийн чанарыг сайжруулах, ашиг шимийн хэмжээг нэмэгдүүлэх, генетик нөөцийг хамгаалах, зохистой ашиглах чиглэлээр дараах арга хэмжээнд бодлогын дэмжлэг үзүүлэн ажиллахыг хүсэж байна. Үүнд, 1 дүгээрт Монгол Улсын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээг нарийвчлан зохион байгуулж, гений дарааллыг тогтоож, дэлхийн мал, амьтны генетик нөөцийн санд бүртгүүлэх. 2. Малын чанарыг сайжруулж, ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор мал аж ахуйн ахуйг бүсчлэн төрөлжүүлэн хөгжүүлэх. 3. Хүн амын өсөн нэмэгдэж буй хүнсний хэрэгцээг хангах зорилгоор гадаад улсаас махны, сүүний болон мах, сүүний чиглэлийн өндөр ашиг шимт цэвэр үүлдрийн үхэр, түүний үр хөврөлийг импортолж, төрөлжүүлэн өсгөх, сайжруулагчаар ашиглах зэрэг арга хэмжээг та бүхний бодлогын болон төсөв санхүүгийн дэмжлэг хэрэгтэй байна.

Хүндэт байнгын хорооны гишүүд ээ, үргэлжлүүлэн та бүхэнд 2025 оны мал төллөлтийн мэдээг тоймлон танилцуулъя. Монгол улс нийт 26,7 сая хээлтэгч буюу, уншихъя, тэгээд хамтраад явах юм даа.

Б.Бейсен: 3 дахь асуудал нь.

Ж.Энхбаяр: 26,7 сая хээлтэгч буюу төллөх насны малтайгаас 2024 онд хээлтүүлэгт оруулсан төллөвөл зохих 24,2 сая эх мал байна. Төллөвөл зохих эх малын 93,9 мянган толгой ингэ, 1,55 сая нь гүү, 1,91 сая нь үнээ, 10,9 сая нь эм хонь, 9,72 сая нь эм ямаа байна. 2025 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт төллөвөл зохих эх малын 73,4 хувь төллөж, 17,7 сая төл хүлээн авч, 17,5 сая төл бойжиж, бойжилт 98,7 хувьтай явагдаж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад төлөлтийн хувь 14,9 хувиар их, төл 5 саяар олон байна. Мал төлөлтийг бүсчилбэл баруун бүс 77,8 хувь, зүүн бүс 63,7 хувь, төвийн бүс 72,6 хувь, хангайн бүс 74,1 хувьтай үргэлжилж байна. Бид 25 онд нийт 23 сая орчим толгой төл хүлээн авах төлөвтэй байна. Ингэснээр 2025 оны зун, намрын улиралд нийт 80,6 сая толгойд хүрч, мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн, мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн хэмжээнд эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Монгол орны бэлчээрийн даац гангүй, хэвийн жилд дунджаар 85 сая хонин толгой малыг тэжээлээр хангах боломжтой бол 25 оны зун, намрын улиралд байх малын тоог хонин толгойд шилжүүлснээр 100 сая толгой болж бэлчээрийн даацаас 15-аас 20 сая толгойгоор хэтрэх төлөвтэй байна. МАА-н салбарын 25-аас 26 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах хүрээнд малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, малчдын амьжиргааг хамгаалах, дэмжих, бэлчээрийн даацад малын тоог

тохируулах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам мал, малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн дотоодын болон гадаад худалдааг дэмжих, хөнгөн хүнсний үйлдвэрийн боловсруулах үйлдвэр хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэн, хэрэгжүүлж байгааг энд мэдэгдье. Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Б.Бейсен: Түрүүчийн тэр нэг дэх асуудал дээр Ганбаатар гишүүн, бид 2 дэмжсэн юм. Тэрийг протоколдоо тусгаарай хуралдааны комисс 1 дүгээрт. 2 дугаарт энэ салбарын сайд маань хамтатгаад мэдээлэл хийчихлээ. Тийм учраас энэ хамтатгаад явчихъя. Тэгээд асуултаас өмнө ажлын хэсгийг танилцуулъя. Жадамбын Энхбаяр ХХААХҮ-ийн сайд, Ц.Болорчулуун Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ц.Мөнхнасан Мал аж ахуйн бодлого, хэрэгжилт зохицуулалтын газрын даргын албан үүрэг түр орлон гүйцэтгэгч, Ц.Цогтбаатар Мал аж ахуйн бодлого, хэрэгжилт зохицуулалтын газрын Малын нөөцийн хэлтсийн даргын албан үүрэг түр орлон гүйцэтгэгч. Сайдын мэдээлэлтэй холбоотой асуулт асуухад гишүүд нэрс өгнө үү? Батжаргал гишүүнээр тасаллаа. Ганхүлэг гишүүний асуулт асууя.

М.Ганхүлэг: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ Генетик нөөцийн хуультай холбогдолтой зүүн бүсийн гишүүдээс өнөөдрийн хурал Байнгын хорооны хурлаар асуудал хэлэлцье гэдэг ийм саналыг оруулж ирсэн. Үүний дагуу Хөдөө аж ахуйн яамнаас тодорхой мэдээллүүдийг өгөөд явж байна. 2017 онд бид бүхэн Генетик нөөцийн тухай хуулийг баталсан байгаа. Үндсэндээ энэхүү хуулиар малын бүртгэлтэй холбогдолтой, мэдээлэлтэй холбогдолтой асуудлыг зохицуулах, түүнийгээ ашиглах, мөн цаашдын бодлого үйл ажиллагаандаа судалгаа, хөгжүүлэлтийн чиглэлээр ашиглах гол үндэс суурь болгож явах ийм зохицуулалтууд гол хөндөгдсөн. Хамгийн чухал асуудал нь энэ Монгол малын цөм сүрэг, түүнтэй холбогдолтой энэ хамгаалах асуудлыг энэхүү хуулиараа гол нь нэлээн хөндсөн.

Гэвч энэ хуулийн хэрэгжилттэй холбогдолтой олон асуудлууд байгаа юм. Тэр утгаараа энэхүү асуудлуудтай холбогдолтой зүүн бүсээс сонгогдсон гишүүд эргэх холбоо хөтөлбөрийн хүрээнд бүх багууддаа явж ингээд ажиллахад олон, олон саналууд гарч ирж байгаа. Тэгэхээр цаашдаа энэ чиглэлээр ажлын хэсэг байгуулаад, илүү нарийвчлаад энэхүү хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллая гэсэн ийм санаачилгыг гаргаж байгаа юм. Монгол Улсын хэмжээнд энэ хуулиараа сая сайд маань хэллээ. Хамгийн эхний асуулт малын генетик нөөцийн үнэлгээний судалгааг бид бүхэн тогтмол хийгээд явах ёстой. 2020 оноос хойш ингээд 5 дахь жил рүүгээ энэхүү судалгаа тооцооллууд хийгдээгүй байгаа. Тэгэхээр шалтгаан юу байв? Мөн 2025 он болон 26 оны төлөвлөгөө улсын төсвүүд дээр энэ чиглэлийн төсвүүдийн саналууд ямар байдалтай явж байна вэ гэдэг эхний асуулт байгаа.

Тодорхой нэр төрлөөр бид бүхэн 4,7 сая адуутай байгаа. Энэ дундаа үржлийн адуу 1,9 сая болж байх шиг байна. Үүний 1,7 нь гүү, үлдсэн нь үндсэндээ азарга байгаад байгаа юм. Ингээд энэ үндсэндээ Генетик нөөцийн тухай хууль яг бодит байдал дээрээ зөвхөн энэ квот олгодог ийм хуулийн гол зохицуулалт болж хувирчхаад байна. Тэгэхээр цаашдаа энэ асуудлуудыг цэгцлэх чиглэл дээр тодорхой ямар, ямар саналууд байна вэ? Ялангуяа импортын адуу оруулж ирж байгаа энэ 72 ААН-үүд өөрсдийн гэсэн тусгай байранд, өөрсдийн гэсэн үржил энэ хээлтүүлгийн үйл ажиллагаа явуулах тодорхой ийм төлөвлөгөөтэй байх ёстой. Тэгэхээр энэ төлөвлөгөө энэ зүйлүүд дээр тодорхой ямар хяналт шалгалтууд

хийгдэж байна, энэ чиглэлийн юмнууд байна уу гэдэг дээр ерөнхий асуултуудаа асууя? Тэгээд цаашдаа илүү нарийвчлаад саналуудаа хэлнэ.

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулах уу, хэн хариулах вэ? Энхбаяр сайд хариулаарай.

Ж.Энхбаяр: Малын генетик нөөц өөрөө төрийн хамгийн гол бодлого. Мал сүрэг төрийн хамгаалалтад байна гэсэн Үндсэн хуулийн заалт ерөөсөө л малын генетик нөөцийн асуудлыг бодож хийсэн зүйл байдаг. Харамсалтай нь яг генетик нөөц малын нэг малаас авах ашиг шимийг сайжруулах, үржил селекцийн ажлыг сүүлийн 30 жил үндсэндээ орхигдуулсан. Мал хувьчлагдсан тул энэ малчны өөрийн асуудал гэж орхисонтой холбоотойгоор мал сүргийн чанар, ашиг шимт байдал сүүлийн 30 жил унасан. Бодын тухай ч тэр, богийн тухай ч тэр. Махны гарц багассан, ноос ноолуурын чанар өөрчлөлт орсон, мал давжаарсан, нөгөө талаас бэлчээр, даац, сүргийн бүтэц алдагдсантай холбоотойгоор бэлчээрээс авах шим тэжээлээ мал авч чадахаа больсон. Байнгын дутагдалд орсон. Ингээд ган зудын бэрхшээлийг даван туулах чадавх муудсан. Өнгөрсөн оны өвөлжилт, хаваржилтын үед харж бид сургамж авсан шүү дээ. 9,2 сая мал тэр нөгөө богинохон хугацааны эрсдэлийг давахгүй байх жишээтэй. Бараг тэрбум долларын хохирол бид амссан.

Тэгэхээр ер нь цаашдаа малын генетик нөөцийн асуудал дээр зарчмын цоо шинэ бодлого оруулах хэрэгтэй. Ялангуяа Монгол Улсыг хөгжүүлэх 2050 хөтөлбөрийн хүрээнд бид үхэр сүргээ үржүүлэх, тэмээн сүргээ үржүүлэх зорилготой бусад 3 төрлийг жил бүр тогтмол тоо толгойг нь бууруулах ийм зорилготой ажиллаж байгаа. Ялангуяа махны гарц, сүүний нийлүүлэлт гээд гол анхаарал бол Хүнс, хөдөө аж ахуйн яам бол үхэр сүрэг дээр, үхэр сүргийг сайжруулах дээр гол бодлогоо явуулах ёстой гэсэн ийм бодлого гаргаад, хэрэгжилтийг хангаад, арга хэмжээг зохион байгуулаад явж байна.

Импортын адуутай холбоотой импортолдог ААН-үүдийг бүрэн хамарсан иж бүрэн шалгалтыг хийждууссан. Нэлээн олон 10 ААН-үүдийн мал, амьтан импортлох тусгай эрх нь цуцлагдсан. Тэгээд өөрийн зориулалтын байртай, үржлийн чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдэд холбогдох тэр зөвшөөрөл эрхийг энэ 25 оны эхээр олгосон. Ингээд адуу импортлогдох ажлууд явагдаж байна. Тэгэхээр адуун дээр нарийвчилсан нийт 30 гаруй хувьд нь үндсэндээ тодорхой хэмжээний өөрчлөлт орсон. Энийг тодорхой болгох, шинэ үүлдэр угсааг нь нэг мөр шийдвэрлэх, Монгол адууны стандартыг шинэчлэн боловсруулахаас авхуулаад нэг мөр шийдэх том асуудал бидний өмнө тулж байна. Мэдээж энд зориулж тодорхой хэмжээний санхүүжилтийг Байнгын хорооны дэмжлэгтэйгээр батлаад, бодлого гаргаад ингээд хийх зүйл адуун дээр тодорхой яг хамар тулсан ажил болж байгаа шүү гэдгийг хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Тодруулъя. Генетик нөөцийн хуультай холбогдолтой яг бүртгэлээ яах вэ гэж би асуугаад байгаа юм. Бүртгэлээ ер нь цаашдаа хэдүүлээ яаж явах вэ? Энэ дээр ямар төлөвлөгөө байна вэ? Тодорхой тэр хуулиараа заачихсан байгаа энэ судалгааныхаа ажлуудыг төсвөөр шийдэх ийм саналууд орж ирж байна уу? Цөм сүргийг хамгаалахтай холбогдолтой энэ чиглэл дээр яг онцгойлон анхаарах асуудал нь яг юу байна вэ гэдэг дээр? Жишээлбэл үндсэн сүүлийн 10 жилийн хугацаанд нийтдээ 5209 импортын адуу орж ирсэн байгаа юм. Энэ үндсэндээ зүгээр хар аргаар бодоход бид үржлийн 10 адуу тутмын 1 нь эрлийз болчихож байгаа юм.

Тэгэхээр үндсэндээ энэ нийт мал сүргийн маань хэчнээн хувь нь эрлийз бол энэ аюул нүүрлэж байна гэж үздэг юм бэ? Энэ чиглэлээр тодорхой судалгаанууд байна уу? Тэр дундаа энэ адуун сүрэг дээр энэ асуудлыг нэлээн онцолж үндсэндээ малчид яриад байгаа юм.

Б.Бейсен: 5 номер хариулья.

Ц.Мөнхнасан: Ганхүлэг гишүүний асуултад хариулья. Малын генетик нөөцийн тухай хууль батлагдаж хэрэгжсэн 2018 оноос хойш ХХААХҮЯ малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санг цахим системийг өргөн ажиллуулж эхэлсэн байгаа. Цахим систем дээр Монгол Улсад өсгөн үржүүлж байгаа бүх мал малчны регистрийн дугаараар малын төрөл, нас, хүйс, ашиг шимийн чиглэлээрээ бүртгэгдэж байгаа. Бид энэ малын бүртгэл нөөцийн мэдээллийн сан дээр байгаа тоогоо жил бүр Статистикийн үндэсний хорооноос гаргадаг малын тоотой харьцуулан судалж, бүртгэл мэдээллийн нарийвчлалыг улам сайжруулан ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 2025 оны хавар төллөж байгаа төлүүдийн 50 орчим хувь нь нэмэлтээр бүртгэгдчихсэн байгаа.

Адуун сүргийн тухайд ер нь малын энэ генетик нөөцийг хамгаалах чиглэлд Монгол Улс 5 хошуу малынхаа генетик нөөцөд гений дарааллыг тогтоож, дэлхийн мал, амьтан.../минут дуусав/

У.Отгонбаяр: 5 номерын микрофон гүйцээж хариулья. Микрофоныг өгөөрэй.

Ц.Мөнхнасан: Энэ Дэлхийн мал, амьтны гений сангийн бүртгэлд геном дарааллыг зайлшгүй бүртгүүлсэн байх шаардлагатай. Ингэснээрээ малыг төр малын генетик нөөцийг хамгаалж байна гэж ингэж ... байгаа юм. Сүүлийн 20 гаруй жил, урагшлаад 1950, 1960-аад оноос хойш орж ирж үржүүлсэн, гадаадаас оруулж ирж үржүүлсэн цэвэр үүлдрийн тэр дунд нь нөгөө Монгол адууны хурдлах чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн энэ үржлийн ажлын үр дүнд Монгол адууны 30 орчим хувь нь ашиг шимийн чиглэл тодорхойгүй, зайлшгүй нарийвчилсан судалгаа хийж ашиг шимийн чиглэлийг гений геномын дарааллыг тогтоох шаардлагатай гэдэг ийм судалгааны дүгнэлтүүд гарсан байгаа. 2020 оноос хойш малын генетик нөөцийн төлөв байдлын судалгаа нарийвчилсан судалгаа хийгдээгүй. Генетик малын цөм сүргийн, үржлийн цөм сүргийн малд үзлэг ангилалд хийх бага хэмжээний зардал жил болгоны улсын төсөвт хуваарилагдаж байгаа. Энэ.../минут дуусав/

У.Отгонбаяр: Замира гишүүн асуулт асууя.

С.Замира: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Эрхэм сайдаа юуны өмнө Монгол Улсын нийт малчид, хөдөө аж ахуйн салбарт ажиллагсад энэ оны мал төллөлт амжилттай үргэлжилж буйд баяр хүргэе. Гэсэн хэдий ч нэг хэд хэдэн асуулт байна. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо алдагдсан, ялангуяа бог малын хээлтүүлэгч дутагдалтай байгаа нь төллөлтийн явцад сөргөөр нөлөөлж байна гэж дурдсан байна л даа. Энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх гээд байна вэ?

2 дугаарт Дорнод, Сүхбаатар зэрэг аймгууд өвөлжилт, хаваржилт хүндэрснээс малын хээлтүүлэг оройтсон байна. Эдгээр бүс нутгийн малчдад зориулсан онцгой нөхцөлтэй бодлогын арга хэмжээ авч байна уу, татаас өгч байна уу?

3 дугаарт улсын хэмжээнд 121 мянган мал хорогдсон нь багагүй тоо. Малчдадаа эдгээр хорогдлын шалтгааныг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр ямар бодлого баримталж байна вэ?

4 дүгээрт олон улсын түвшинд Монголын уламжлалт үйлдвэрүүдийг генетикийн үнэт нөөцөөр бүртгүүлэх, хамгаалалтад авах алхам хийгдэж байна уу? Ийм 5 асуулт байна.

У.Отгонбаяр: Асуултад 5 номер уу? 5 номерын микрофоныг өгье. Маш тодорхой 5 асуулт асуулаа. Тодорхой, товч бөгөөд тодорхой хариулаад өгөөрэй.

Ц.Мөнхнасан: Малын хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо алдагдсан, хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироог оновчтой зохистой түвшинд хүргүүлэх чиглэлд ХХААХҮЯ 2023 оноос эхлээд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бог малын хээлтэгчийг худалдан авч малын үржүүлэг, технологи, ажил үйлчилгээний нэгжийн мэдэлд төвлөрүүлж байгаа. Ингэснээрээ малчин хүн өөрийн хотноос өөрийн дураараа хээлтүүлэгч мал тавьдаг энэ боломжийг нь хязгаарлаж, сайн чанарын хээлтүүлэгчээр малчдыг хангах ажил хийгдэж байна.

Малын хорогдлын тухайд 2024-өөс 25 оны өвөл, хаврын улиралд харьцангуй өнөтэй сайхан өвөлжиж, хаваржиж, зуншлагатайгаа золгож байна. Малчдын малын тоог өвөл, зун, намрын улиралд бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах, дотоод гадаадын худалдааг дэмжихэд чиглэгдсэн зохицуулалтын бөгөөд бодлогын арга хэмжээнүүдийг ХХААХҮЯ-наас авч хэрэгжүүлж байгаа. Дээрээс нь ЗГ-ын тогтоол жил болгон гарч, малчид, малчдын түвшинд, сумын түвшинд, аймгийн түвшинд бэлтгэж нөөцлөх шаардлагатай өвс тэжээлийн хэмжээг албан даалгавраар гаргаж өгдөг.

Малын генетик нөөц, тэр дундаа энэ малын гений санг хамгаалах чиглэлд Монгол Улсад малын генетик Малын удмын сангийн үндэсний төв ажиллаж байгаа. Удмын сангийн үндэсний төв дээр Монгол Улсад зохих эрх бүхий байгууллагын шийдвэрээр баталгаажсан нийт 59 үүлдэр омгийн малын гений санг авч хадгалах, түүнээсээ цаашаа зохиомол хээлтүүлэгт ашиглах, Дэлхийн мал, амьтны генетик нөөцийн санд бүртгүүлэх зэрэг гений санг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Баярлалаа.

У.Отгонбаяр: Би өөрөө нөгөө гишүүнийхээ хувиар, хэн Энхбаяр сайд нэмж хариулт өгье.

Ж.Энхбаяр: Энэ малын сүргийн бүтэц гэж нэг ойлголт байгаа. Сүргийн бүтэц эвдэрчхээд байгаа. Нийт сүргийн 46 аравны хувийг хээлтэгч байгаа юм, 0,9 хувь нь хээлтүүлэгч байгаа. 1 наст мал, төл мал бол 22,9 хувь байна. Бараг 30 хувь нь эр, сувиа мал эзлээд байгаа юм. Сүргийн бүс дэх эр, сувиа малын тоо хэмжээ нэмэгдэх хэмжээнд тухайн малчны бүтээмж буураад эхэлж байгаа юм, ачаалал, зардал, эрсдэл нэмэгдээд эхэлж байгаа юм. Эргээд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдээд, бэлчээр ашиглалт, өвс тэжээлийн норм хэтрээд байгаа байдал. Энд үржлийн нормоор бол бог мал 1 хээлтүүлэгчид 25-аас 30 хээлтэгч ноогдох ёстой байдаг. Гэтэл 1 хуцанд 81 хонь, эм хонь, 1 ухна 88 эм ямаа ноогдож байгаа.../минут дуусав/

У.Отгонбаяр: Болсон уу Энхбаяр сайд? Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Тэгэхээр бог дээр авахад 3 дахин норм хэтэрнэ гэдэг маань өөрөө мал сувайрах, 1 малаас ашиг шим, мал аж ахуй үр ашиг багатай байх гээд маш олон сөрөг ийм нөлөөллийг үзүүлж байгаа. Харамсалтай нь 2018 оноос малын энэ үржил селекц генетикийн чиглэлээр улсын төсөвт хөрөнгө оруулалт тавьж өгөөгүй. Малыг бүртгэлжүүлэх асуудал, эзмэгжүүлэлтийн асуудлыг оруулж ирсэн улс төр болгоод Их Хурал дээр унагааж байсныг бүгд санаж байгаа. Ахиад сануулахад энэ малын үржил селекцийн асуудлыг үнэхээр төрийн бодлого болж, нэг цоо шинээр нь бид нэг олон улсын стандартад нийцүүлж шинэчлэх, бүртгэх, эзмэгжүүлэх, энэ мөшгөх тогтолцоог нэг тодорхой болгохгүй бол манай экспорт болон үйлдвэрлэл гээд маш олон зүйлд энэ байдал олох боломжоо бид бүрэн ашиглаж чадахгүй байгаа байдлыг л үүсгэж байгаа зүйл энэ байгаа юм шүү гэдгийг гишүүдэд анхааралд оруулъя.

У.Отгонбаяр: Замира гишүүн тодруулъя.

С.Замира: Би нэг нэмэлт нэг хэдэн асуулт асуух гэсэн юм. Манай мал маш их өсөж байгаа юм байна, тэр нь сайн байна. Тэгээд малыг амьдаар нь гаргах Ерөнхийлөгчийн улс орнуудын Ерөнхийлөгчтэй хийж байгаа гэрээний талаар нэг мэдээлэл өгөх боломж байна уу? Яагаад гэвэл энэ Казахстан улс яваад ирсэн чинь тэр улс хүсэлт тавьж байна. Амьдаар нь, 2 улсын Ерөнхийлөгч 500 мянган хонь амьдаар нийлүүлэх гэрээ хийсэн юм, тэр гэрээний биелэлт нь юу болж байгаа, бид тэгж хонь авч болох уу гэсэн.

Тэгээд 2 дугаарт яшур үе мөчний өвчин гэж байдаг юм байна малын, хонины. Тэр ер нь манай энэ нутагт хэр зэрэг тархацтай байгаа, ер нь хэр зэрэг эмчилгээнд хамаарагдаж эдгэж байгаа гэдэг талаар? 2 асуултад хариулт өгч болох болов уу.

У.Отгонбаяр: Энхбаяр сайд хариултад, хариулт хэлье.

Ж.Энхбаяр: Гишүүд тэр слайд руу анхаараарай. Тэр гаргаад байгаа мэдээлэл. Бид адуугаа жил болгон 0,8 хувиар бууруулах ёстой, үхрээ 0,5 хувиар нэмэгдүүлнэ, тэмээгээ 0,3-аар нэмэгдүүлнэ, хонио 1,7 хувиар бууруулна, ямаагаа 1,9 хувиар бууруулж явж байж бид нөгөө тогтвортой хөгжлийн зорилтот хүрэх, нөгөө олон улсын өмнө амласан амлалт руугаа хүрнэ. Дээрээс нь бэлчээрийнхээ даац, сүргийн бүтцийн зохистой харьцаа гээд олон зорилтдоо хүрэхээр ингэж явж байгаа. Нийгэм болохоор ингээд өсгөөд байх нь чухал гэдэг талаас нь ойлгоод байдаг бол бид зохистой бэлчээртээ таарсан зөв бүтэцтэй, ийм ашиг шимт өндөр ийм мал сүргийг бий болгох ийм зорилготой ажиллаж байгаа. Энэ хүрээнд ер нь манайхаас нэгэнт бодлогод цөөрүүлэх бодлоготой тул импортоор амьд мал авъя гэсэн газар луу гэрээ хийгээд.../минут дуусав/

У.Отгонбаяр: Дараагийн, 4 номерын микрофон асуултад хариулъя.

Ц.Болорчулуун: Замира гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Тэгэхээр өнөөдрийн байдлаар бид Узбекистан улстай Монгол Улсаас амьд мал гаргах 100 мянган толгой мал гаргах ийм гэрээ байгуулаад өнөөдрийн байдлаар 7 мянган тооны, 7 мянган толгой малыг гаргаж байгаа. Гаргахдаа энэ тээврээр онгоцоор явж байгаа учраас тээвэрлэлт дээр жоохон асуудлууд гарч байгаагаас бус өөрөөр энэ гарах боломж нь нээлттэй, ингээд үе шаттайгаар аваад явж байгаа. Ямар ч байсан энэ он дуустал 50 мянган толгойд хүргэнэ гэсэн байдлаар ингээд хамтын ажиллагаа өрнөөд явж байгаа.

2 дахь асуулт нь яшур өвчний талаар гэхих шиг боллоо. Тийм тэгэхээр энэ шүлхий өвчнийг хэлж байна гэж ойлголоо. Тэгэхээр энэ олон улсын гоц халдварт өвчнөөр сүүлийн 3 жил, тэр дундаа энэ малын шүлхий өвчнөөр тайван байгаа. Тэгээд ямар нэгэн ийм тохиолдол бүртгэгдээгүй байгаа. Тэр ч утгаараа энэ жил бид дэлхийн эрүүл мэндийн.../минут дуусав/

У.Отгонбаяр: Нэмж 4 номерын микрофон гүйцээж хариулъя.

Ц.Болорчулуун: Сая бид 5 дугаар сард ДМАЭМБ-д сүүлийн 2 жил энэ гоц халдварт өвчнөөр тайван байгаа учраас цаашдаа энэ тайван статусаар бүртгэх бүх бичиг баримтаа илгээсэн. Энэ 7 сардаа багтаж энэ асуудлыг хэлэлцэж шийдэхээр, шийдүүлэхээр ажиллаж байгаа.

У.Отгонбаяр: Надад ганц нэг асуулт байна. Малын генетик нөөцийн нөөцийн тухай хууль маш чухал хууль, 2017 онд батлагдсан. Тэрнээс хойш яг ний нуугүй хэлэхэд энэ хууль маань огт хэрэгжихгүй байгаа олон зүйл дээр. Би ганц нэгхэн жишээ авч энэ адуун дээр. Манай зүүн бүсийн, зүүн бүсээс сонгогдсон Их Хурлын гишүүд энэ импортын адууг тодорхой хугацаанд хориглох чиглэлээр тодорхой ажил зохион байгуулъя. Холбогдох Байнгын хороо шаардлагатай бол Улсын Их Хурлаас Улсын Их Хурлын тогтоол гаргах чиглэл рүү ажиллая гээд ажиллаж байгаа. Импортын адуу ингээд гаалийн мэдээ аваад үзэхээр сүүлийн 2024-өөс, 14-өөс, 15-аас 2024 он гээд 10 жилийн хугацааг аваад үзэхээр жилдээ нэг дунджаар 500 адуу орж ирж байгаа юм импортоор. Үндсэндээ азарга орж ирж байна. Энэ азарганд хамгийн багадаа 20 гүү тавьж байгаа юм. Тэгээд жил болгон үндсэндээ адуун сүрэг маань 10 мянга орчим адуу үндсэндээ эрлийзжиж байгаа юм, гаднын цус орж байгаа юм. Энэ бол тоон үзүүлэлт.

Эдийн засаг талаасаа аваад үзэхээр гаднаас импортоор орж ирж байгаа адууны үнэ хамгийн багадаа 50 саяас 200 сая төгрөг. Тэгээд жилдээ 500 адууг дундажаад 120 орчим сая төгрөг, 125 орчим сая төгрөг гэж бодоход жилдээ 62,5 тэрбум төгрөг гадагшаа гарч байгаа юм. Энийг дагасан хивэг тэжээлийн мэдээг би авч үзлээ. 2025 оны эхний улирлын байдлаар 3,5 сая долларын хивэг тэжээл орж ирсэн. 2024 онд 14 сая, 2023 онд 10 сая гээд маш их мөнгө энэ импортын адууг дагаж гадагшаа урсаж байгаа. Тийм учраас бид бүхэн тэр дундаа энэ жил энэ Монгол Улсын дэлхий нийтээрээ эдийн засаг хүнд байгаа, тэр дундаа Монгол Улсын эдийн засаг хүнд байгаа энэ цаг үед, дээрээс нь энэ Генетик нөөцийн тухай хуулиа хэрэгжүүлэхийн тулд бид бүхэн эхний ээлжид тодорхой хугацаанд энэ импортын адууг хязгаарлая гэсэн ийм санал гаргаж байгаа юм.

Хөдөө орон нутагт бид бүхэн маш их тойргоороо, мөн төвийн бүс, баруун бүс гээд олон газраар ажилласан. Дээрээс нь энэ мэргэжлийн холбоодтой бид бүхэн уулзалт хийсэн. Монголын морин спорт уяачдын холбоо, Монголын үндэсний морин уралдаан уяачдын холбоо, дээрээс нь уяачидтай, хөдөө орон нутагт мал маллаж байгаа хөдөөгийн хөх уяач нартай, малчидтай маш олон уулзалтуудыг хийсэн. Энэ импортоор орж ирж байгаа адууг тодорхой хугацаанд зогсоох ийм зайлшгүй шаардлага байна гэдэг дээр маш олон хүмүүс санал нэгдэж байгаа. Тийм учраас бид бүхэн энэ чиглэл рүү энэ хориглох асуудал дээр салбарынхаа яамтай хамтарч ажиллах ийм зайлшгүй шаардлага байна гэж үзэж байгаа юм.

Тэгээд энэ зохист харилцаа алдагдсан 1 л тоо баримт. Түрүүн та өөрөө тайландаа, мэдээлэлдээ дурдаж байх шиг байна. Адуун сүргийн 30,8 хувьд нь ашиг шимийн чиглэлийг нарийвчлан тогтоох зайлшгүй шаардлагатай байна гэж

шинжээчид дүгнэжээ гэж байгаа юм. Энэ маш өндөр тоо шүү. Өндөр тоо. Сая тайланд гарч байна адуун сүрэг жишээ нь адууг бол хамгийн багадаа 0,8 хувиар бууруулах ёстой гэсэн тэгж байж зохист харилцаа бий болно гэсэн байгаа. Тийм учраас бид бүхэн импортоор адуу оруулж ирээд, үржлийг маш ихээр хийж байгаа нөхцөлд энэ хууль болон энэ зохист харилцаа хэрэгжих боломжгүй юм гэдэг дүгнэлтэд хүрч байна.

Хамгийн сүүлд та бүгд маань саяын сайдын хэлснээр аттестатчилал явуулсан юм шиг байна оруулж ирж байгаа компаниудад. Энэ компаниудын тоо толгойг цөөрүүлж, ер нь энэ импортоор орж ирж байгаа адууг тодорхой хугацаанд хориглох энэ чиглэлээр яам яг ямар бодлого барьж байгаа вэ, цаашдаа ер нь оруулах нь зөв үү, буруу юу гэдэг дээр маш тодорхой хариулт өгөөч? Баярлалаа.

Б.Бейсен: Сайд хариулах юм байна. Хэдэн номер хариулах вэ? Болорчулуун дарга хариулъя.

Ц.Болорчулуун: Тэгэхээр энэ үржлийн мал импортлох, экспортлох тусгай зөвшөөрлийг ХХААХҮЯ-наас олгодог. Энэ хүрээндээ бид тодорхой шаардлагуудыг тавиад, энэ шаардлага хангасан ААН-үүд дээр нь зөвшөөрлүүдийг олоод явж байгаа. Яг үржлийн адуу импортлох чиглэлээр нийтдээ 72 ААН, иргэн зөвшөөрөл авсан байдаг. Үүнээс хяналт шалгалт хийж тухайн жилд авсан квотоо хэдэн хувийг нь оруулж ирсэн, ямар үржил хийсэн гээд хэд хэдэн үзүүлэлтээр манай хяналт шалгалтын байгууллагууд мэргэжлийн энэ газрууд явж шалгалт хийсний үр дүнд 72 ААН, иргэнээс 58 ААН нь тодорхой хэмжээнд шаардлага хангасан гэсэн ийм дүгнэлтийг гаргасан байгаа. Яг нийт Монгол адууны тоонд харьцуулж үзвэл жилдээ орж ирж байгаа 500 толгой адуу нийт адууны 0,0001 хувь байгаа. Бид тодорхой хэмжээнд энэ Малын генетик нөөцийн хуулийн хүрээнд энэ зөвшөөрлийг олгоод, оруулж ирж байгаа хэдий боловч энийг яг шууд хориход нөгөө талдаа гаалийнхаа хяналт шалгалтыг сайжруулахгүй бол энд далдуур ийм үржлийн үр хөврөл, хөлдөөсөн үрүүд маш их хэмжээгээр гарал үүсэл нь тодорхойгүй зүйлүүд орж ирж энэ адууны үржил явагдах ийм бололцоо нөхцөл байгаа. Тэгэхээр энийг бид нэг талдаа зогсоосон тохиолдолд энэ талынхаа хяналт шалгалтыг чангатгаж байж энэ ажлыг зохион байгуулах нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байгаа гэдгийг хэлье.

Б.Бейсен: Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: 1 дүгээрт адуун сүргийн тоог тасралтгүй багасгах ёстой, ялангуяа бэлчээрийн талхагдалд маш их гомдол гэдэг юм уу ийм байдал их байнга орж ирж байгаа. Импортын адууг хориглох ямар ч хууль, эрх зүйн орчин байхгүй. Хориглох бололцоо одоохондоо байхгүй. Шаардлагаа хангаад материалаа бүрдүүлсэн, экспортолж байгаа орны мал эмнэлгээс эрүүл гэсэн ийм тодорхойлолт юмаа авсан бүх оруулж ирэх ААН-үүд тэр квотдоо багтаад л оруулж ирж байгаа. Хориглох буюу хязгаарлах энэ бодлогыг миний түрүүн ярьсан энэ малын генетик нөөцтэй холбоотой дүн шинжилгээ хийж дуустал түр хугацаагаар түдгэлзүүлэх гэдэг зүйл байвал Байнгын хорооны санал, дүгнэлт гаргаад эсвэл Их Хурлын тогтоол шийдвэр гаргаад ингээд өгвөл яам хэрэгжүүлэхэд бэлэн байна. Одоо байгаа хэрэгжиж байгаа хууль, эрх зүйн хүрээнд бид ямар нэг.../минут дуусав/

Б.Бейсен: Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Одоо мөрдөж байгаа хууль, эрх зүйн хүрээнд бид ямар нэгэн хязгаарлалт тавих эрх байхгүй. Хуулиар хориотой байгаа. Тэгэхээр яг бодлого

гаргадаг Улсын Их Хурал дээр энэ хэлэлцээд шийдвэр гаргаад, хэрэгжүүл гээд өгөхөд яам хэрэгжүүлэхэд бэлэн байна.

Б.Бейсен: Отгонбаяр гишүүн тодруулъя.

У.Отгонбаяр: Тийм ээ тийм, тэрийг ойлгож байгаа. Яам энийг шууд түдгэлзүүлэх ямар ч хууль, эрх зүйн талаас боломж байхгүй. Тийм учраас өнөөдрийн энэ танилцуулгатай холбогдуулаад Байнгын хорооноос ажлын хэсэг гарах нь зөв байх гэж ойлгож байгаа. Тэгээд ажлын хэсэг гараад ямар зохицуулалтаар энийг тодорхой хугацаанд импортын адууг хориглох боломж байгаа эсэхийг судлаад, гарц гаргалгаа гаргаад, ингээд ажиллаад явбал болох байх гэж би ойлгож байна.

Б.Бейсен: Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ их чухал асуудал болоод байна л даа. Ер нь яах вэ бид нөгөө малынхаа тоог их болбол мундаг байна гэдэг байсан бол одоо Монгол малын өөрийнх нь ашиг шим, малын өөрийнх нь онцлог гээд олон зүйлүүдийг хадгалж үлдэхэд энэ генетикийн асуудал туйлын чухал болж байна л даа. Том биетэй бол сайн бух, ухна гээд ингээд яваад байдаг байж болохгүй болж байгаа юм билээ. Монгол мал дээр ямаан дээр гэхэд тэр микроны асуудал байна, одоо бас жоохон бүдүүрээд байна гэж байгаа. Бүдүүрээд байхын хэрээр үнэ унана. Энэ бидэнд маш хортой, ашиггүй. Нөгөө талдаа сүү, махны гарцууд байхгүй болоод байна. Бэлчээрийн даац хэтрээд байна гээд ийм асуудлууд байгаа.

Тэгэхээр яах вэ орон нутагт энэ ажлыг зохион байгуулах үндсэндээ мэргэжлийн хүнгүй болчихоод байна л даа. Мал эмнэлгийн тасаг байгуулна, нөгөө зоотехникч гэдэг хүн чинь байхгүй болчихсон. Тэгэхээр ер нь зүгээр тэр эцэг малыг ер нь гаднаас нь хараад том, жижгээр нь ер нь сайн, мууг нь дүгнээд явчихдаг ийм юм руугаа орчихоод байгаа юм. Тэгэхээр яах вэ энэ нөгөө Малчны тухай хууль дээр малчны хүүхдийг сургана гэсэн энэ 9 сарын 1-нээс хэрэгжих энэ зохицуулалт дээр ер нь энэ зоо техникийн асуудлыг бид оруулж өгвөл төрдөө ч ажилладаг бай, хувьдаа ч байдаг бай энэ талын мэдлэг мэдээллүүдийг маш сайн хүргэх энэ шугамаа 1 дүгээрт би нээмээр юм шиг санагдаж байгаа юм.

2 дугаарт манай зүүн бүсийн уяачдын ярьдаг энэ, ер нь Монголын бүх уяачид л ярьж байна дээ энэ адууны асуудал байгаа юм. Энэ адууг эрлийзжүүлснээр нийт адууныхаа дунд маш бага гэж байгаа тийм ээ. Гэхдээ Монголд үзүүлж байгаа хор хөнөөл нь асар өндөр байгаа байхгүй юу. Ердөө Монгол төр наадмаа хийж чадахаа болилоо шүү дээ. Хэрүүлгүй наадам гэж хаана ч байхгүй боллоо. Хэрүүлгүй наадам хаана ч байхгүй. Уяачид нь хөх уяач, мөнгөтэй уяач гээд ингээд 2 хуваагдчихсан. Тэгээд энэ нь өөрөө асар их хортой болчихоод байгаа байхгүй юу. Аймгийн наадамд 10 хэдэн морь уралдаж байна эрлийзүүд байгаа гээд ингээд л. Энэ өөрөө нөгөө Монгол наадмын нэр хүндэд ч тэр бас асар их нөлөөлж байгаа. Нөгөө талдаа энэ морь малын наймаа хийдэг энэ групп дээгүүр байна туршуул азарга, security азарга. Би 2 жилийн өмнө байх Их Хурлын чуулганы танхим дээр бас ярьж л байсан. Тэгээд ийм хөгийн, хөгийн юмнууд яваад байгаа учраас наад үржлийн мал азаргыг оруулж ирэх асуудлаа ер нь зүгээр түр түдгэлзүүлээд, цаашдаа хаачихвал яасан юм бэ гэдэг ийм тодорхой саналыг хэлж байгаа юм.

Дараагийнх нь сая Хөдөө аж ахуйн яамны асуудал дээр гарч байна л даа. Ер нь энэ адууны тоо толгой гэж. Ялангуяа манай зүүн бүс дээр энэ асуудал туйлын

хүнд. Одоо ингээд л баруун талаас баахан адуутай нөхөд явсаар байгаад ер нь улсын хилийн наана очоод л, тэнд очоод л 2, 3 мянган адуу унахгүй, идэхгүй, бүгд уралдахгүй, зүгээр тоолоод л, бэлчээр тахлаад л, тэр хавийн малчдын амьжиргаанд нь шууд нөлөөлөөд байж байна. Тэгэхээр энэ асуудлууд ер нь яг яаж орж ирэхээр байгаа вэ, хэзээ шийдэгдэхээр байгаа вэ? 2 асуулт, 1.../минут дуусав/

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ бэлчээр замбараагүй талхалж байгаа байдал адуутай холбоотой. Ялангуяа зүүн бүсэд отрын адуунууд төвийн бүсээс их хэмжээгээр олон зуун мянгаар гарч байгаа. Тэгээд энэ шийдэх нэг арга ухаан буюу малын хөлийн татварт энэ хуульд өөрчлөлт оруулах асуудлыг яам одоо өргөн барина. Боловсроод дууссан. Орон нутаг тэр бэлчээр ашиглаж байгаа тэр малд татвар тавих эрхээ олж авна. Тэр мөнгөө бэлчээрээ сэргээх, худаг усаа гаргах, хашаа хороогоо сайжруулах, мал эмнэлгээ сайжруулах гэх мэтийн бодлогодоо ашиглах бололцоотой буюу нэг бодож байгаа зохицуулалт энэ.

2 дугаарт тэр энэ адуу оруулж ирэх нь зөв, буруу гээд олон зүйл асуудлууд байна. Нэг зүйл үнэхээр энэ сайд болоод санаа зовж байгаа зүйл салбар шинжлэх ухаанч биш болчихсон манай салбар. Манай бидэнд зөвлөх өдөр тутам яг энэ асуудлыг маргаан таслах ёстой Мал аж ахуйн хүрээлэн, Мал эмнэлгийн хүрээлэн, нөгөө ургамлын асуудал шийддэг Ургамал, газар тариалангийн хүрээлэн, хүрээлэнгүүд маань яамны харьяа биш, өөр, бүүр өөр хамаагүй хөгжлийн судалгааны, бодлогын чиглэл рүү яам руу яваад өгчихсөн. Хүний нөөцийн асуудал байдаг бас өөр яам руу явчихсан. Тэгэхээр энэ олон зүйл ер нь энэ хүнс, хөдөө аж ахуйн салбар Монголын гол тулгуур салбар, хамгийн олон ажлын байр бий болгож байгаа, нийгмийн баялгийн хуваарилалтад хамгийн шударга байгаа салбарын хувьд энэ шинжлэх ухаантай нь, хүний нөөцтэй нэг ийм бодлоготой нэг гарт нэгтгэж өгөх асуудлыг манай мэргэжлийн Байнгын хороо бүүр нарийвчлан ажлын хэсэг гаргаж, судалж, Их Хуралд оруулж энэ дүгнэлт гаргаж ингэж шийдэж өгөөч. Үнэхээр яг ажил аваад мэдэгдэж байгаа гол юм тэр байна. Бодлогын юм буюу нарийн юм гаргахаар судалгааны байгууллагуудын дүн шинжилгээ, мэдээлэл байдаггүй. Хүний нөөцөө бэлтгэх, боловсруулах гэхээр байхгүй.

2 дугаарт орон нутагт байгаа тэр бүтэц Хөдөө аж ахуйн газар гээд хэвтээ бүтэц байгаа аймгийн даргын мэдэлд. Энийг Хөдөө аж ахуйн яамны харьяанд босоо бүтэц болгож өгмөөр байна. Ингээд анхан шатаасаа, малчны хотхоноосоо үйлдвэрлэлийн түвшинд хүрэх бүх бодлого нэгдсэн бодлоготой, нэгдсэн шинжлэх ухаанч бодлоготой, нэгдсэн хүний нөөцийн бодлоготой нэг ингэж нэг төр захиргаа нэгдмэл бүтэцтэй явж байж энэ явах юм байна. Тэгээд ямар санаатай юм бүү мэд бүгдийг нь тус тусад нь болгоод жиргээд л задалсан байна. Энийг яаралтай эмхэтгэж, нэг гарт оруулж, нэг бодлого болгохгүйгээр энэ хүнс, хөдөө аж ахуйн салбар, хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг нэг үр ашигтай босгоход үнэхээр маш том саад болж байгаа юм байна. Үнэхээр нөөц байна, бид байгаа нөөцийнхөө 20 хувь дээр нь нэг эргэлдээд л байгаад байна. Маш сайн дайчлах нөөц байна, үйлдвэрлэлээ өсгөх бололцоо байна, малаа сайжруулах бололцоо байна, нэг малаас авах ашиг шимийн бололцоо байна, экспортын бололцоо байна, энэ бэлчээрээ сайжруулах бололцоо байна. Ингээд бодлогын тус тусдаа байдал, шинжлэх ухаанч бус ийм байдал, хүний нөөцийн бодлого салсан энэ байдлыг цэгцэлж өгөх зайлшгүй шаардлага байна. Энэ.../минут дуусав/

Б.Бейсен: Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Тийм энэ бол бас их тийм шинжлэх ухаанчаар хандах ёстой гээд тэр сайдын байр суурьтай санал нэг байна. Энэ дээр бид ер нь бодохгүй бол одоо тоо гэж байгаа, одоо чанар гэж байгаа. Чанартай болгохын тулд бид шинжлэх ухаанчаар хандахгүй бол түрүүний миний хэлсэн том, жижиг гээд ингээд яваад байж болохгүй юм байна гэдэг нь ойлгомжтой. Тэгэхээр ер нь яах вэ энэ ХАА-н салбар, МАА-н салбарын энэ шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх тэр шинэ бүтэц, зохион байгуулалт хийхээр бол эртхэн хийгээд, энэ намрын төсөв төлөвлөгөө хамаг юмандаа оруулаад, ингээд сууриар нь хөдөлгөөд үзвэл яасан юм бэ гэж ингэж бодогдож байгаа юм л даа. Тэгээд энэ адуу малтай холбоотой юмыг ярихад тэгээд л нөгөө ховор хүмүүс дээр гардаг шиг Дүүриймаагийн сууринд байж л нэг байж байдаг. Тэрнээс нэг жоохон шуурга хавсарга болоход аятайхан уруудаад яваад ирж чадахгүй л адуу болсон байна шүү дээ. Гэтэл дэлхий бол Монгол мориог дэлхийн 2 дугаар дайнд Монгол морь, Монгол адуу тэсвэр тэвчээрээрээ гайхамшигийг үзүүлж, Москвад хөшөөг нь босгоод сая Ерөнхийлөгч бүүр цэцэг өргөсөн шүү дээ. Баярлалаа.

Б.Бейсен: Батжаргал гишүүний асуулт асууя.

Ж.Батжаргал: Гишүүдийн орой амар амгаланг айлтгая. Генетик нөөцийн тухай юм ярихаар зэрэг нэлээн бодмоор юмнууд байна. Үгүй ээ энэ байгаль цаг ууртаа дасан зохицсон тэсвэрт чанартай малаа хадгалах тухай ойлголт яваад байгаа юм ер нь гол суурь нь. Тэгээд одоогоор үүлдэр, үүлдрийн хэсэг, үржлийн хэсэг, омог гээд 59 мал байх шиг байна ер нь тийм үүлдэр омог байгаад байх шиг байна гэж. Үүнийг аль, аль бүс нутгуудад хөгжүүлэх ёстой вэ гэдэг юмаа их тодорхой зураглалаа гаргаж, яг тэр лүүгээ чиглэсэн бодлогын зохицуулалт л бид хийх ёстой үүнийг бид нэлээн анзаармаар байна. Энэ дээр манай яам ямархуу бодлого, чиглэл байна вэ гэж нэг ийм зүйл?

2 дугаарт сүргийн бүтцийн. Өнөөдөр хар даа тэмээн дээр хээлтэгч 39 хувьтай, адуун дээр 34 хувьтай, үхэр дээр 39 хувьтай, хонин дээр 44 хувьтай, ямаан дээр 42 хувьтай л байгаа. Тэгэхээр бид яаж энэ малчдын орлогыг нэмэгдүүлэх вэ, яаж байгаль орчин гэдэг юм уу энэ бэлчээртэйгээ даац нь нийцэх вэ гэхээр зэрэг хээлтэгчийн эзлэх хувийн жинг эрс нэмэгдүүлэх шаардлагатай. Дан дамаа бог дээр бараг 65-аас 70 руу нь дөхүүлэх ёстой. Тэгээд өсвөр малаа эдийн засгийн эргэлтэд оруулах ёстой. Тэгж байж сая энд нэг зөв бүтэц, бас малчдын орлого амьжиргаа дээшлэх ёстой. Энэ тал руу ямар анхаарал төвлөрүүлж байна вэ гэдэг асуудал.

Түрүүний ярьсан юман дээр би тэр малын удмын сангийн үрийн банк гэдэг юм ер нь манайд ямархуу байна гэж тэр асуудал чухал байгаад байгаа юм. Энэ нэг олон үүлдэр омгийн малуудын чинь баталгаат үрийн нөөц, хадгалалт ер нь ямархуу байгаа юм энэ л бидний хамгийн гол аминд орох ёстой зүйл л байх ёстой. Үүнийгээ л бид сэргээж авч явах ёстой гэж би энэ талаас нь асуудалд хараад байна гэж.

Дараагийн нэг зүйл хэдүүлээ малаа давжаарч байгаа, ашиг шим буурч байгаа тухай яриад байгаа. Магадгүй энэ нь үүлдэртэйгээ гэдэг юм уу, цус ойртолттойгоо холбоотой байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ миний бодлоор тэжээлдээ байгаад байгаа юм. Өсвөр малд нь бид амьдаар нь борцолчихоод байгаа улс байхгүй юу. Үндсэндээ хургаа, ишгээ хавар гарангуут нь хатаачхаад байгаа улс. Тэгэхээр энэ мал чинь өөрөө тэр хөгжлөө авч, задралаа авч чадахгүй л яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ мал тэжээдэг арга ажиллагаа, ер нь өвс тэжээлийг бид зуд давдаг гэхээсээ илүү малын авсан тарга хүчний алдалтыг багасгахад.../минут дуусав/

Б.Бейсен: Батжаргал гишүүн нэмж асууя.

Ж.Батжаргал: Тэгэхээр энэ рүү чиглэсэн бодлогын чиглэл, арга зүйн зөвлөмж, шинэ арга барилыг бий болгох тухай асуудал бидний хамгийн гол зүйл байгаад байх шиг байна. Гаднын үнэтэй мал оруулж ирж чадаж байна бид хэд, өдөрт 40 саадаг үхрээс энэ чинь 23, 4 саачхаад хангалттай сааж байгаа тухай ярьцгаагаад байна шүү дээ ингэхээр чинь яаж болох юм хэдүүлээ, өртгөө нөхөхгүй шүү дээ. Тэгэхээр энэ тэжээл, тэжээлийн уураг, амин дэмийн зохистой байдал үүнийг авч үзэхгүйгээр энэ МАА-н салбарын хөгжлийн тухай асуудал ярихад нэн төвөгтэй болох байх. Үүн дээр нэлээн онцгой анхаарах ёстой. Энэ дээр ямар байр суурь байна вэ гэж?

Адууны тухай түрүүн нэлээн олон хүн ярьчих нь лээ. Энэ жилийн баяр наадам Монгол адуун дээрээ явах ёстой хуулиараа. Тэрийг нь төрийн захиргааны төв байгууллага бүгдийг нь баталгаажуулсан байх тухай асуудалтай шүү. Тэгэхээр.../минут дуусав/

Б.Бейсен: Батжаргал гишүүн нэмье.

Ж.Батжаргал: 1 ухраая гэж оруулж ирээд ухраалаа. Үндэсний баяр наадмын тухай хуулийн тэр заалтыг ухраах тухай асуудал яригдах болно шүү. Энэ их гэмтэй шүү. Тийм учраас яам энэ дээр ямархуу ажил хийгдсэн бэ? Би бол харин тэр ажлын хэсэгт нь өөрөө байж байгаад энэ мөнгөтэй улсууд нь тэр улсдаа урладаг тэр тусгай ангиллаараа, сумын баяр наадамд хэмжилт нь ч явна, үүлдэрлэг байдал нь ч явагдана тэгж байж энэ Монгол адууны ген фондыг хадгалж үлдэх ёстой, уур амьсгалынхаа араншныг даадаг адуу байх ёстой гэдэг үүднээс тэр хуульд бүүр яг тэгж оруулсан. Харин манай энэ сумд дан дамаа миний сонгогдсон энэ төвийн бүсийнхэн тэр адууны үүлдэрлэг байдал харахаа болиод, зөвхөн хэмжээд уралдуулаад байгаа юм байна лээ сумд. Энэ бол энэ нийтээрээ Монгол адууны байгальдаа дасан зохицох тэсвэрт чанарыг муутгаж байгаа зүйл. Хурдан байж болно, сайн байж болно. Нөгөө.../минут дуусав/

Б.Бейсен: Хэн хариулах вэ? Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Тэр малын үүлдэрлэг байдлын асуудал ер нь бүгдээрээ нэг хамтраад, Байнгын хороо санаачлаад Бейсен даргаа Монголын адуун чиглэлээр мэргэшсэн бүх эрдэмтдийг цуглуулж байгаад тэр МАА-н хүрээлэн гээд хүрээлэн байгаа шүү дээ. Үнэхээр Монгол адууг сайжруулах ёстой юм уу, гадаад импортын адуугаар сайжруулалт хийх ёстой юм уу, үгүй юм уу гээд ер нь нэг шинжлэх ухааны дүгнэлт гаргуулаад, Монгол адуу гэвэл ямар адууг хэлэх юм, ямар байх ёстой юм гээд нэг ийм жоохон шинжлэх ухаанч хандчихмаар байна. Энийг Байнгын хороо санаачлаад нэг хэлэлцүүлэг хийгээд нэг шийдвэр гаргавал яасан юм бэ гэдэг зүгээр санал байна.

Нөгөө талаас энэ МАА-г нэгэнт бэлчээрийн тоо толгой өссөн, бэлчээрийн даац хэтэрчихсэн, бэлчээрээс авах ашиг шим багасчихсан. Энийг гол нөхөх юм бол таримал тэжээлээр эрсдэлийг хаах буюу өвлийн тэр хүндрэлтэй үед уурагт шим тэжээл, ногоон тэжээлээр хангах асуудал байгаа юм. Нөгөө газар тариалан чинь хөгжиж байж л өөрөө энэ МАА чинь тэн дээр тогтоно гэдгийг л бүр хаана хаанаа нэг мөр ойлгочихмоор байгаа юм. Гэтэл бид чинь нөгөө газар тариалангийнхаа сая гол юман дээр бид сая ухралт хийгээд нэг хууль унагаагаад хаячихсан. Үндсэндээ

Оросоос тэжээлээ худалдаж авъя, Оросоос гурил худалдаж авъя, улаан буудайгаа авъя гэдэг л хуультай байна шүү дээ одоо. Тэгэхээр энийг нэг яаралтай засаад өгөөч. Газар тариалан хөгжиж байж тэжээлийн аж ахуй хөгжинө. Тэн дээр суурилж эрчимжсэн гахай, тахиа, шувууны аж ахуй хөгжинө. Хамгийн гол зорилт бол энэ төвлөрсөн хүн амын хүнсний хэрэгцээг хангана гэдэг асуудал байна.

Жишээлбэл бид бэлчээрт яваа энэ 60 сая малынхаа дэлэнд байгаа сүүг тооцоод, Монгол хүний сүүний хэрэглээ дэлхийн дунджаас 3 дахин их гээд байгаа статистикт дурддаг юм. Гэтэл бодит байдал дээр бид сүү, сүүн бүтээгдэхүүний 60 хувийг импортоор авч байгаа. Бэлчээрт байгаа тэр МАА-гаас төв суурин газрын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг хангаж чадахгүй гэдэг нь тодорхой байгаа. Тэгэхээр төв суурин газрыг хангахын тулд бид илүү ашиг шимт энэ саалийн байнгын байрын маллагаатай эрчимжсэн аж ахуй руу орохоос аргагүй. Тэгэхдээ тодорхой хувьд нь шүү дээ төвлөрсөн хүн амаа хангах. Тэгээд тэр бодлого тусдаа явах ёстой байгаа юм. Энд нийцүүлсэн үрийн банк буюу Монгол Улсын яг өөрийн язгуур тэр тэсвэр тэвчээр сайтай нутгийн омгийг хадгалах үрийн банк бүрдүүлэх байдал муу байгаа. 18 оноос хойш энэ салбарт хөрөнгө оруулалт тавьж өгөөгүй. Бүр юмны язгуур суурь нь үрийн аж ахуй малын хувьд ч тэр, ургамлын хувьд ч тэр. Тэр үр хөврөл, үр тарианы тэр үрийн нөөцийн асуудлыг л бид нэг сууриар нь манай Байнгын хороо байнга анхаарч, жоохон шинжлэх ухаанч хандаад өгөөч гэдэг л юм байгаа юм. Энэ дээр ерөөсөө хөрөнгө оруулалт алга, энэ дээр шаардлагатай урсгал зардал байхгүй. Ингээд л байгаа ч биш, байхгүй ч биш ийм байдалтай нэг янз янзын юмнууд их манайд байгаад байдаг юм. Цаг сунгаад өгөөч.

Б.Бейсен: Энхбаяр сайдын нэмж сунгая.

Ж.Энхбаяр: Улсын хэмжээнд цөм сүрэг гээд бараг аймаг болгонд цөм сүрэг байна, байгаа нэртэй л юм байна. Сая ахиад иж бүрэн бүх аймгаар тойрсон иж бүрэн шалгалт явуулаад дуусаж байна. Харамсмаар ийм үр дүн гарч байна хайран хөрөнгө. Ашиглалт, хамгаалалт ер нь их л сөрөг гарлаа. Энийг Байнгын хороонд би дараа нь нэг танилцуулна. Тэгэхээрээ ер нь бид Монгол Улс өөрөө энэ хөнгөн хүнсний үйлдвэрлэл чинь МАА-н үйлдвэрлэл, газар тариалангийн үйлдвэрлэл гэсэн 2 юман дээр тогтож байгаа шүү дээ. Тэгэхээр МАА-н үйлдвэрлэлийнхээ нэг ийм ген фонд, үржил селекцийнхээ бодлогыг, энэ үрийн банкиг бүрдүүлэх, ингээд ашиг шимт мал сүргээ сайжруулах, төв суурин газрын хүнсний хэрэгцээг яаж хангах, хамгийн гол нь үйлдвэрлэлд нийцсэн МАА байх ёстой. Үйлдвэрлэлд нийцсэн. Тэр үйлдвэрлэл дээр бодлого, тэр стандартад нийцсэн мал сүргийг өсгөж үржүүлж байх ёстой буюу үйлдвэрлэлийн бодлого, мал аж ахуйн бодлого 2 нэг юман дээр нэгдэж байх ёстой. Энэ мэтчилний маш олон.../минут дуусав/

Б.Бейсен: Нэмж хариулах хүн байна уу? Болорчулуун дарга.

Ц.Болорчулуун: Батжаргал гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тэгэхээр ер нь энэ 59 үүлдэр омог хэвшил байгаа. Үүнээсээ яг 37 үүлдэр байгаа юм Монголын яг. Энэ 37 үүлдрээс бид Малын удмын сангийн үндэсний төв дээр энэ ген фондыг нь хадгалах, генийг нь хадгалах ажлыг зохион байгуулаад өнөөдрийн байдлаар 16 үүлдэр омгийг малын нөгөө генийг хадгалж байгаа. Бусадтай нь тодорхой хэмжээнд ингээд зардал мөнгөтэй холбоотойгоор ажиллаж байгаа. Ер нь зүй нь энэ 37-гоо эхний ээлжид бүрэн омгийг нь хадгалах ийм шаардлага байгаа. Тэгээд энэ дээрээ тодорхой хэмжээнд хүрч ажиллахаар ингээд төлөвлөөд явж байгаа гэдгийг хэлье. Ер нь тэр хээлтэгч малын хувь хэмжээг нэмнэ гэдэг үнэхээр

таны хэлж байгаа дээр санал нэг байгаа. Бид өнгөрсөн жил, энэ жилээс эхлээд энэ улсын аварга.../минут дуусав/

Б.Бейсен: Болорчулуун дарга гүйцээж хариулъя.

Ц.Болорчулуун: Улсын аварга малчин шалгаруулах энэ журамдаа өөрчлөлт оруулаад, энд эхний ээлжид аварга малчин болох гэж байгаа малчны нэг шалгуур үзүүлэлтийн нэг нь энэ хээлтэгчийн тоо толгойг 45 хувь биш, 55, 60 хувь руу хүргэсэн байна гэдэг ийм шалгуур үзүүлэлтийг оруулж өгч байгаа. Тэгээд энэ үе шаттайгаар хээлтэгчийнхээ тоог нэмэгдүүлэх нь зөв бодлого гэж үзэж байгаа.

Б.Бейсен: Бадамсүрэн гишүүн асуулт асууя.

М.Бадамсүрэн: Малын удмын санг хамгаалах асуудал ингээд адуунаас эхэлье гэдэг энэ саналыг дэвшүүлж байна. Дээр нь энэ бүртгэлийг адуунаас эхэлбэл хамгийн хэрэгжих хурдан боломжтой байна гэж үзэх нь зөв болов уу л гэж бодож байна. Тэгээд миний асуулт энэ Генетик нөөцийн тухай хууль дээр 12.3 дээр ингэж гадаад улсаас оруулж ирсэн болон үржлийн зориулалтаар нутаг шилжүүлсэн үүлдэр омог, тэдгээрийг ашиглан бий болгосон үржлийн малыг энэ хуулийн 13.2-т заасан бүс нутагт нутагшуулан үржүүлж, хамгаална гэж байгаа юм. Тэгээд 13.2 нь төрөл бүрийн үүлдэр омгийн малыг үржүүлэх бүс байршлыг тогтоох журмыг ЗГ батална гэж байгаа юм. Тэгэхээр энэ ЗГ-ын ямар журам батлагдсан байдаг юм болоо гэдгийг асууя?

Дээр нь үргэлжлүүлээд энэ журмын дагуу ер нь энэ оруулж ирж байгаа, гадаад улсаас импортоор оруулж ирж байгаа энэ үржлийн малыг ямар бүс байршилд тогтоосон байгаа вэ? Хэдэн бүс байршилд ер нь энийг тогтоосон, энэ хуулийн хэрэгжилт ер нь ямар байгаа вэ гэдгийг асууя?

Дараагийнх нь энэ үржлийн адууг болон түүний үр хөврөлийг импортоор оруулж ирэхийг хориглох тодорхой хугацаанд тухайлбал 10 жилийн хугацаанд. Энэ нь шинжлэх ухааны үндэстэй ингэж судалгаа дээр үндэслэж гарсан гэж ойлгож байгаа. Тэгээд энийг үр дагавар нь ер нь яаж гарна гэж ер нь салбарын яам харж байгаа вэ? Энд зөвхөн үржлийн гэж заах нь чухал байх. Яагаад гэвэл морин тойруулга хөгжүүлнэ гээд яригдаж байгаа. Тэгэхээр морин тойруулгад зөвхөн агт адуу буюу үржлийн бус адууг оруулж ирж, энийг тэндээ уралдуулах энэ боломж нь нээлттэй байх ёстой. Өөрөөр хэлбэл энэ гарах үр дагавруудыг нь тооцоод, аль, аль талынх нь эрх ашгийг хангасан ийм байдлаар энийг зохицуулах нь их зөв болов уу гэж бодож байгаа юм.

Ер нь яах вэ нийгэмд ямар зүйл үүсээд байна гэхээр ийм яг эгэл жирийн ийм хөдөөгийн залуусыг дэмжих энэ зүйл их чухал болчихоод байгаа юм. Та бүхэн санаж байгаа бол улсын наадамд шүдлэн үрээ түрүүлгэсэн Дундговийн Улаанхүү гээд уяач, одоо энэ хөдөөгийн бүсгүй, хотын бүсгүй хөдөө нутагт гээд энэ нэвтрүүлгийн ТВ нэвтрүүлгийн оролцогч Баянхонгорын Ганболдын Ганхүрэл гээд залуу ч гэдэг юм уу яг ийм эгэл жирийн малчин залуусыг дэмжих энэ зүйл үнэхээр үгүйлэгдэж байгаа. Өөрөөр хэлбэл энэ морины уралдаан үндэсний энэ соёл, бидний төрийн сүлдэндээ дээдэлсэн энэ адуу гэдэг зүйлийг чинь яг энэ мал маллаж, хөдөө орон нутагт ажлын байр бий болгож, амьдрал ахуйгаа авч яваа энэ залуучуудыг уралдах, уралдуулах энэ нөхцөл боломжоор хангах асуудал хамгийн чухал байгаа байхгүй юу. Тэгэхгүй бол хамгийн боломжтой, хамгийн хөрөнгө, чадалтай нь өндөр үнээр импортын азарга оруулж ирж үржүүлэг хийгээд.../минут дуусав/

Б.Бейсен: Дараа тодруулга, хариулт хэдэн номер? 5 номер хариулъя.

Ц.Мөнхнасан: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Малын генетик, нөөцийн тухай хуульд заасан тусгайлсан төрлийн мал, амьтан өсгөн үржүүлэх бүс байршлын журмыг 2022 он, ЗГ-ын 2022 оны 92 дугаар тогтоолоор баталсан. ЗГ-ын тогтоолыг үндэслээд батлагдсан Үүлдэр омгийн малыг өсгөн үржүүлэх бүс байршлын журмын нарийвчилсан хэлбэрээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар тогтоосон байгаа.

Гадаадаас импортоор авч байгаа сайн чанарын сайжруулагч адуун сүргийг төвийн болон төвийн бүсэд цэврээр нь өсгөн үржүүлэхээр бүс байршлын журамд тодорхойлон зааж өгсөн байдаг. Тухайн үед төвийн бүс гэж нөгөө Хөвсгөл аймгаас Өмнөговь хүртэлх босоо тэнхлэгийг хамруулсан төвийн бүсийг гэж зааж байсан байгаа. Одоо тэгэхээр энэ бүс байршлын журмыг Бүсчилсэн хөгжлийн үндэсний үзэл баримтлалтай холбогдуулан шинэчлэн батлуулахаар журмын төсөл дээр ажиллаж байгаа.

Батжаргал гишүүний асуултад нэмээд хариулбал Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасны дагуу ХХААХҮЯ Монгол үүлдрийн адууны стандартад нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа. Монгол үүлдрийн адууны ерөнхий шаардлага 40 99 2020 стандартад нэмэлт, өөрчлөлт оруулаад Стандарт, хэмжил зүйн газарт Стандартын техникийн хороогоор хэлэлцүүлэхээр хүргүүлсэн байгаа. Стандарт зөвхөн зөвлөмжийн чанартай баримт бичиг. Зөвлөмжийн чанартай баримт бичгийг ЗГ-ын тогтоолоор Баяр наадмын ЗГ-ын тухай, ЗГ-ын тогтоолоор Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааны дүрмийг баталсан ийм ЗГ-ын тогтоолтой. Энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт орж байж бидний боловсруулаад Статистикийн газарт, Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлсэн байгаа стандартыг мөрдөх боломж бүрдэх юм. Дээрээс нь наадамд уралдах морьдыг ангилахдаа үүлдэрлэг байдлыг харах боломжийг тухайн ЗГ-ын тогтоолоор баталсан хурдан морины салбар хорооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж байж энэ хүчин төгөлдөр болно гэдгийг хэлье.

Идэрбат гишүүний асуултад нэмэлтээр хариулахад Малчны тухай хууль дээр заагдсан 10-аас дээш жил тасралтгүй мал малласан малчны нэг хүүхдийг мал аж ахуй, бэлчээр тэжээлийн чиглэлээр төрийн өмчийн их, дээд сургуульд үнэ төлбөргүй суулгах журам Боловсролын сайдын тушаалаар батлагдсан. 2025 оны 9 сарын 1-нээс эхлээд хэрэгжих ийм бүрэн боломжтой болсон байгаа гэдгийг хэлье.

Б.Бейсен: Бадамсүрэн гишүүн тодруулъя.

М.Бадамсүрэн: Тэгэхээр энэ ЗГ-ын 92 дугаар журмаар чинь би ингэж ойлголоо шүү дээ таны хариултаас. Импортын буюу гадаадаас оруулж ирсэн үржлийн адууг зөвхөн төвийн бүсэд үржүүлэхээр заасан юм байна гэж ойлголоо. Зөв үү? Үгүй ээ харин тэгээд, тэгвэл ингээд энэ төвийн бүс, зүүн бүсийг заачхаад өөр бүсэд энэ адууг чинь импортоор оруулж ирсэн адууг үржүүлээд байж болж байгаа юм уу? Энэ дээр ямар хяналт тавьж байгаа юм бэ? Тэгээд ажлын хэсэг юм уу энэ дээр энэ зохицуулалт байгаа шүү дээ мэдээж хяналтын механизм, энэ нь ямар үр дүн гарсан байдаг юм бэ? Энэ талаар тодорхой зааж өгөх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл энэ ерөөсөө ингээд замбараагүй, хяналтгүй байж болохгүй болчихоод байгаа учраас энэ адууны асуудлыг ингэж тавьж байгаа. Дээр нь энэ залуучуудын хөдөө орон нутгийг хөгжүүлэх, уламжлалт аж ахуй, соёлоо авч явах, өөртөө ажлын байр

бий болгох энэ боломжийг төрөөс зохицуулалтаар хангаж өгөхгүй болохгүй гэж, энийг тодруулъя дахиад.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 5 номер хариулъя.

Ц.Мөнхнасан: Бадамсүрэн гишүүний асуултад нэмж хариулъя. ЗГ-ын 2022 оны 92 дугаар тогтоолоор төвийн болон зүүн бүсийн аймгуудад үндсэн сайжруулагчаар ашиглахаар заагдсан байгаа. Энэхүү бүс байршлын журмын хэрэгжилтэд хяналт тавихад мэргэжлийн боловсон хүчин буюу Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний улсын хяналтын байцаагчийн орон тоо байдаггүй, зөвхөн мал эмнэлгийн хяналтын байцаагчийн орон тоотой байдаг байсан. Тийм учраас зөвхөн мал эмнэлгийн хяналтын байцаагч маань малын шилжилт хөдөлгөөнд нь л хяналт тавигддаг байсан. 2023, 2024 оноос хойш, 24 оноос малын үржүүлэг технологийн улсын байцаагч улсын хэмжээнд 100 гаруй байцаагчийн эрхтэй албан хаагчид ажиллаж байгаа. Эдгээр байцаагчийн эрхтэй албан хаагчид маань бүс байршлын журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байгаа. Энэ нь зөвхөн 2024 оноос эхэлсэн гэдгийг хэлье.

Б.Бейсен: Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Ингээд асуугаад байна шүү дээ. Та нар орж ирж байгаад зөвшөөрөл өгчхөж байна. Төвийн бүс гэдгээр хуучин тодорхойлолт аймгаа хэлчих. Шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжийн чинь хэдэн хувь импортлох эрхтэй ААН-ийн хэдэн хувь нь энэ төвийн бүсдээ байгаа юм буюу наад ЗГ-ын тогтоолоос гадуур өөр бүсэд импортлох эрх авсан аж ахуй байгаа юм уу? Дээрээс нь тэр бүс рүү явсан адуун дээр та нар жоохон бүртгэл тооцоогоо сайжруулаад тэр импортолж байгаа үед нь гэрээ хэлэлцээрээ жоохон сайжруулаад чанаржуулаад л, гүйцэтгэлийн хяналтаа тавиад л явчих ажил шүү дээ. Тэгээд л мэргэжлийн хяналтын байцаагч хэрэгтэй гээд байх хэрэггүй. Бүртгэлээрээ бариад ийм, ийм байна. Хэрвээ бүртгэлээрээ зөрчөөд тэр үржлийн бүсээс гараад өөр газар луу цэвэр адуу тэр азаргыг нь шилжсэн бол тэр хураадаг, хянадаг, шалгадаг юм руугаа ордог л юм байгаа биз хэрвээ. Ер нь энэ адуун дээрээ нэг ажлын хэсэг гаргаад нэг янзалъя тэгэх үү бүгдээрээ. Ер нь Монгол адуу гэж ямар адуу юм, бид яах ёстой юм, сайжруулах ёстой юм уу, ёсгүй юм уу ер нь яах юм бэ? Бодлогоо нэг цэгцлээд, нэг сайн ярилцаж аваад л шийдчихгүй бол дуусдаггүй хэрүүл. Миний хувьд аягүй хэцүү байна. Нэг хэсэг нь оруул гээд.../минут дуусав/

Б.Бейсен: Мандхай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Би энэ нөгөө нэг хамгийн сүүлийн хуудас хэрэгжүүлэх арга хэмжээний саналтай холбоотойгоор 4 асуулт байна. Нэгдүгээрх нь 1 дүгээр асуудал дээр малын генетик нөөцийн тухай, нөөцийн төлөв байдлын үнэлгээг 3 жил тутам хийнэ гээд хууль дээрээ заагаад өгсөн байгаа. Хамгийн сүүлийн үнэлгээний тайлан 18-аас 19 онд хийгдсэн. Үүнээс хойш энэ үнэлгээг ер нь хийсэн үү, хийгдэж байгаа юу? Энэ үнэлгээ дээр тэгээд гарсан яг дүгнэлт нь яг ямар дүгнэлт гарсан бэ гэдэг дээр асуулт асууж байна? Тэгээд ер нь энэ санал бол тухайн тэр үнэлгээ дээр гарсан саналтай үндэслэж энэ чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний санал гарах ёстой байгаа.

2-т нь энэ дээр гений дарааллыг тогтоож, дэлхийн мал, амьтны генетик нөөцийн санд бүртгүүлнэ гэхчхэн байгаа. Энэ нэлээн төвөгтэй нарийн мэргэжлийн хүн байхаас гадна, нэлээн төсөв мөнгө шаардагдах ажил харагдаад байна. Тэгэхээр

энийг хэн, ямар төсвөөр, хэдий хугацаанд хийнэ гэж төлөвлөж байгаа вэ? Дараа нь Дэлхийн мал, амьтны генетик нөөцийн санд Монгол Улсын 50 гаруй үүлдэр омгийн малын жагсаалт бүртгэлтэй байдаг. Одоо нэмж шинэчлэх төлөв байдлын өөрчлөлтийг оруулах асуудал бас яг хийгдэж байгаа юу гэдгийг асууя.

2 дугаар асуудал дээр малын чанарыг сайжруулахад чиглэсэн төрийн өмчит цөм сүргийн аж ахуй Малын удмын сангийн үндэсний төвд харьяалагдаж байгаа. Одоо тэнд төрийн өмчийн хэчнээн мал аль, аль аймагт байгаа вэ? Бүсчилсэн хөгжлийн бодлогод бид чинь бүсэд цөм сүргийн аж ахуйг дэмжихээр байгаа. Тэгээд үүнтэй уялдуулаад яг ямар ажлууд хийхээр төлөвлөж байгаа вэ? Мөн чанартай сайн малыг тухайн бүсийн иргэд, ААН-ийн хэрэгцээнд нийлүүлэх чадавх, тэгээд энэ төрийн өмчийн цөм сүргийн аж ахуйнууд үүнд орж байгаа юу, малын чанар нь хэр байгаа вэ гэдгийг асуумаар байна?

3 дугаар асуулт нь 5 дугаар асуудалтай холбоотой гаднаас авчирсан мал ер нь хэр нутагшиж байгаа вэ? Ялангуяа эрчимжсэн мал аж ахуйн хүрээнд гаднаас мал оруулж ирж байгаа. Ганцхан адуу гээд зогсохгүй, импортын үнээ махны чиглэлийн үхэр орж ирсэн. Тэгээд хэр нутагшиж байна, хэчнээн иргэдэд тараагдаж байгаа вэ гэдгийг мэдмээр байна. Тэгээд одоо ямар үүлдрийн мал, хэзээ оруулж ирж, хэнд тараагдах вэ гэдэг тодорхой асуулт асууя.

7 дугаар асуудал дээр малын чанар, ашиг шим муудаад байгаагийн цаад шалтгааныг харахаар энэ илүү нөгөө мал үржлийн хувийн аж ахуй, санхүүгийн дэмжлэг үзүүлдэггүй, энэ чиглэлийн мэргэжилтэн ажиллуулах хөшүүрэг илүү байхгүй.../минут дуусав/

Б.Бейсен: Мандхай гишүүн гүйцээж асууя.

М.Мандхай: Мэргэжилтэн ажиллуулах ийм хөшүүрэг байхгүйтэй холбоотой байх гэсэн ийм бодолтой явдаг. Гэхдээ энэ одоо мал эмнэлгийн хувийн хэвшлийн аж ахуй чинь вакцин тариад л, вакцин зэрэг тариад үйлчилгээ үзүүлснийхээ төлөө улсын болон орон нутгийн төсвөөс мөнгө авдаг. Тэгэхлээр яг энэнтэй адилхан эд нар чинь үйлчилгээний хөлс тогтмол авч байгаа, тоног төхөөрөмжийнхөө хөрөнгө оруулалтыг хийдэг, энэнээс болоод хөл дээрээ ингээд босоод ирчихлээ шүү дээ. Яг энэнтэй адилхан малын чанар, ашиг шим муудаад байгаа энэ асуудалтай холбоотойгоор энэ хувийн мал үржлийн энэ аж ахуйн нэгжүүдэд өгөх санхүүгийн дэмжлэгийг ер нь яам юу гэж харж байгаа вэ? Жишээлбэл энэ Шинэ хоршоо, жижиг, дунд үйлдвэрийн дэмжлэгүүд байгаа. Яах вэ үржлийн мал худалдан авах гээд нэг чиглэл байгаа боловч илүү бид өөрөө бодлогоороо яг ямар үржлийн малыг авах вэ гэдгийг бүүр нарийн тодорхойлж зааж өгч дэмжлэгтээ оруулж болох уу?

Б.Бейсен: Хэн хариулах вэ? 5 номер.

Ц.Мөнхнасан: Мандхай гишүүний асуултад хариулъя. Малын генетик нөөцийн тухай хууль батлагдсанаас хойш малын төлөв генетик нөөцийн төлөв байдлын нарийвчилсан үнэлгээг хамгийн сүүлд 2019 онд хийсэн. 2019 оноос хойш төлөв байдлын үнэлгээ хийгдээгүй байна. Төлөв байдлын үнэлгээ хэдийгээр 3 жил тутамд нэг удаа хийх хуулийн заалттай боловч хөрөнгө санхүүгийн асуудлаас болоод өдий болтол хийгдэж амжаагүй байна. Малын генетикийн нөөцийн төлөв байдлын үнэлгээ хийхэд нийтдээ бид 20 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай гэж 2025 оны улсын төсвийн төсөөллийг хийж байх үед төлөвлөж байсан юм. Удмын, Малын генетик нөөцийн тухай хуулийн 15.1-д заасан

байгууллага буюу удмын сангийн үндэсний төв дээр нийт 13 цөм сүрэгт төрийн өмчийн цөм сүрэг бүртгэлтэй байж байгаа. Төрийн өмчийн цөм сүрэгт 2025 оны 1 дүгээр сарын байдлаар 3 мянга орчим мал бүртгэлтэй байна. Удмын сангийн үндэсний төвд байгаа төрийн өмчийн цөм сүргийн малын чанар, ашиглалт, тэгээд дээрээс нь хамгаалалт дээр нь ХХААХҮ-ийн сайдын тушаалаар гарсан ажлын хэсэг хяналт шалгалт хийгээд үндсэндээ дуусаж байна.

13 аймгийн 13 цөм сүрэг байсан, цөм сүрэгтэй байдаг юм. Эдгээр цөм сүргийн чанар, дээрээс нь ашиглалтын байдалд хяналт шалгалт хийгээд, ЗГ-ын тогтоолоор цөм сүргийн тоо байршлыг өөрчлөх, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлэх, малыг төрөлжүүлэн эрчимжүүлэн хөгжүүлэх ийм бодлогын арга хэмжээндээ нийцүүлэн 13 аймагт биш, 4, 3 бүсэд зөвхөн арвин ашиг шимт буюу цаашдаа сайжруулагчаар, үндсэн сайжруулагчаар ашиглах боломжтой чанарын шаардлага хангасан цөм сүргийг шинээр дахин бүрдүүлэх ажил хийгдэхээр байна. Энэ 2025 оны 2 дугаар хагастаа хийгдээд эхэлнэ. Энэ хэр нутагшиж байна вэ гэдэг асуултад Монгол Улс гадаадаас сайн чанарын малыг авахдаа Монгол орны байгаль цаг уурын онцлог, дээрээсээ Монгол Улсад эрчимжсэн болон хагас эрчимжсэн мал аж ахуйд өсгөн үржүүлж байгаа, маллаж байгаа нөхцөл, тэжээллэгийн нөөц боломждоо нийцүүлээд хамгийн сайн дасан зохицох боломжтой төрлийн малыг сонгодог. Ингэхдээ манай Монгол Улсад урьд нь туршигдчихсан, үржүүлж эхэлсэн малуудыг оруулж ирж байгаа. 2025 онд герефорд үүлдрийн 200 толгой гүнжийг оруулж ирсэн, худалдаж аваад 12 ААН-д олгосон байгаа. Энэ 2025 оны 2 дугаар хагасаас эхлээд төр, хувийг хэвшлийн, төр.../минут дуусав/

Б.Бейсен: Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ хөдөө аж ахуйн гол суурь болсон ийм үржлийн аж ахуйнууд үндсэндээ орхигдсон. Монгол Улсад малын үржлийн төрөлжсөн аж ахуй байхгүй. Адуун дээр нэг жоохон дур сонирхлын юмнууд яваад байна. Жишээлбэл яг мэргэжлийн хониных алга, ямааных алга, тэмээн дээр алга, үхэр дээр алга. Энэ мал сүрэг төрийн хамгаалалт байна гэдэг Үндсэн хуулийн концепцын гол сүнс бол энэ үржлийн ажил, энэ удмын сан, энэ үржил селекцийн бодлого байх ёстой юм байхгүй юу. Энийгээ бид үндсэндээ хэрэгжүүлээгүй явсан.

Одоо дөнгөж үр тариан дээр бид жоохон ажил хийгээд нэг үрийн улаан буудайн дээр хэдэн, 5 орчим аж ахуйг яг баталгаажуулаад, тоног төхөөрөмж нь ялгаруулаад илүү өндөр стандарт тавиад ингээд эхэлж байна. Мал аж ахуй дээр зайлшгүй яг үхрийн, махны үхрийн сайжруулагч тэр үхрийг үржүүлдэг аж ахуй нь энэ байна. Одоо хувийн сонирхол хоббигоороо л нэг цөөхөн хэдэн улсууд байна.

Б.Бейсен: Мандхай гишүүн тодруулах юм уу? Болсон байна. Энэ Монгол Улсын малын генетик нөөц, төлөв байдлын тухай асуудал, 5 номер хариулъя.

Ц.Мөнхнасан: Мандхай гишүүний асуултад нэмж хариулъя. Малын гений дарааллыг тогтоох, гений дарааллыг тогтоож мөн Дэлхийн мал, амьтны гений санд бүртгүүлэх ажил хамгийн чухал ажил юм. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад өсгөн үржүүлж байгаа 5 хошуу малын нэг ч малын гений дараалал тогтоогдоогүй байна. 2020, 19, 2020 онд эхлээд адуун сүргийнхээ Монгол адууны геномын дараалал их тогтооё гээд аймгууд дээр судалгаа хийгдээд, зарим төрлийн зарим адуунаас цусны дээж аваад ийм шинжилгээ хийхээр бэлдсэн. Харамсалтай нь тухайн үед Монгол Улсад гений, малын гений дараалал тогтоодог лабораторийн хүчин чадал хангалтгүй, лаборатори байгаагүй учраас Бүгд Найрамдах Солонгос Ард Улсад

гений шинжилгээнд хамруулахаар хүргүүлсэн боловч санхүү, хөрөнгийн асуудал шийдэгдээгүй учраас зогссон. 2024 оны 6 дугаар сард Солонгос улсын хөрөнгө оруулалтаар Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуй, био технологийн сургууль дээр мал.../минут дуусав/

Бейсен: 5 номер гүйцээж хариулья.

Ц.Мөнхнасан: Мал аж ахуйн технологи дамжуулах төв байгуулагдсан. Уг төвд малын гений дараалал тогтоох лабораторийн анхан шатны суурь нөөцүүд бүрдсэн. 2025 оны 4 дүгээр сард 4 мэргэжилтэн бэлтгэсэн, одоо 6 дугаар сард эдгээр мэргэжилтнүүдийн чадавх сайжруулахаар Бүгд Найрамдах Солонгос Ард Улс руу сургалтад хамрагдахаар бэлтгэгдэж байна.

Бейсен: Гишүүд асуулт асууж дууслаа. Би нэг асуулт асуумаар байх юм. Би Энхбаяр сайд, хэн Сэддорж гишүүн асуулт асууя гэсэн мартчихсан байна, уучлаарай. Сэддорж гишүүн асуулт асууя.

Р.Сэддорж: Баярлалаа. Тэгээд Хөдөө аж ахуйн яамныхантай хуралд сууж байгаа дээрээ энэ чухал сэдвийг хөндөж байна. Тэгээд тэмээний талаар судалгаа ер нь хэр хийгдэж байна? ХААЯ-нд энэ эрэмбэ дараагаараа ер нь нэлээн хойгуур явж байгаа байх. Тэгээд тэмээний уралдаан гэдгийг та бүхэн маань анхаарч үзэж байгаа байлгүй. Тэгээд хавтгай эрлийз их уралдуулж байгаа. Тэр нь тэмээний үнэ цэн их өсөж байна. Тэгээд хурдан тэмээ 10 саяас дээш гарчихсан байна шүү дээ. Энэ дээр судалгаагаа та бүхэн маань энэ тэмээчдэд ойлгуулж явах ёстой байх.

Дараагийн асуудал энэ тэмээ уяач хүмүүст хэр анхаарал тавьж байна вэ? Тэр олон хүн тэмээгээ уралдуулж, өвлийн баяр наадам ч ерөөсөө тэмээгээр л явж байна, тэмээ л уралдуулж байна. Аялал жуулчлалыг татаж байгаа зүйл чинь тэмээний уралдаан байгаа. Тэгээд энэ дээр улсын цол авах хүсэлтээ тэмээчид маш их илэрхийлдэг. Тэгээд энэ дээр ХААЯ анхаарч үзээч. Дээрээс нь Дэлхийн тэмээний уралдааны холбооны гишүүн орон болсон, Азийн тэмээний уралдааны холбооны гишүүн орон Монгол Улс болсон. Энэ гадаад харилцаан дээр тэмээчид маань өөрсдийн зардал нөөц бололцоогоороо энэ Тэмээн соёл, уралдааны холбоо өөрсдөө зардал мөнгөө гаргаад ингээд яваад байгаа. Энэ дээр та бүхэн маань анхаарч ажиллаач. Тэгээд энэ тал дээр хийж байгаа судалгааны ажлыг санхүүжүүлж байгаа зүйлүүд байна уу? Энэ дээр хариулж өгөөч.

Бейсен: Хэдэн номер? Энхбаяр сайд, 4 номер Болорчулуун дарга.

Ц.Болорчулуун: Тэгэхээр энэ 5 хошуу малаас тэмээний асуудлыг хамгийн сүүлд тавьж байгаа асуудал байхгүй байгаа. Мэдээж тэмээ ашиг шимийн үед ингэний сүү нэлээд дэлхий нийтээрээ ийм үнэтэй бүтээгдэхүүн болж, энэ чиглэлд ААН-үүд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийж, ингэний сүүний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа. Энэ дээр тодорхой хэмжээний дэмжлэгүүдийг аж ахуйн нөхцөлд үзүүлэх, томоохон энэ Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөний хүрээнд дотоодын томоохон үйлдвэрүүдийн сүүний чиглэлээр ажиллахад нь бид хөнгөлөлттэй зээл олгох чиглэлд хамтын ажиллагааг өрнүүлж байгаа. Яг тэмээн дээр хийгээд байсан дорвитой судалгаанууд харьцангуй хэлчихээр юм зүйл байхгүй байна. Ер нь орон нутгаас говийн аймгуудаас манай Хүнс, хөдөө аж ахуйн газраар дамжуулаад энэ тэмээний уралдаантай холбоотой улсын цол хэргэм олгодог ийм асуудлуудыг асуудлуудаар удаа дараа тавьж байгаа. Тэгээд энэ дээр бид анхаарч ажиллаж байгаа.

Тэмээний ингэний сүүг энэ үйлдвэрт тушаасан бүтээгдэхүүнд урамшуулал болдог энэ сүүний урамшуулалд хамруулж явж байгаа гэдгийг хэлье. Тэмээний ноосон дээр урамшууллуудыг өгөөд явж байгаа. Бид энэ Цагаан алт хөдөлгөөний хүрээнд сарлагийн хөөвөр, тэмээний ноосоо бүрэн боловсруулах чиглэлд нэлээд онцгой анхаарч, энийг бүрэн эцсийн бүтээгдэхүүн 100 хувь эцсийн бүтээгдэхүүн болгох чиглэлд нь онцгой анхаарч ажиллаж байгаа гэдгийг танд хэлье.

Бейсен: Сэддорж гишүүн тодруулъя.

Р.Сэддорж: Тэмээний ноосон дээр ямар урамшуулал олгож байна, хэдэн төгрөг олгоод байгаа вэ? Тэмээний сүүн дээр ийм урамшуулал байдаг юм уу? Хэдэн төгрөг олгосон юм бэ?

Бейсен: Болорчулуун дарга хариулъя.

Ц.Болорчулуун: Улсын Их Хурлын 30 дугаар тогтоолын хүрээнд бид энэ хонь, тэмээний ноосонд мөнгөн урамшуулал олгодог журамтай. Энэ журмын хүрээнд тэмээний ноосны килограмм тутамд нь 2 мянган төгрөгийн урамшууллыг олгодог байгаа. Энэ нь Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоогоор дамжуулаад үндэсний үйлдвэрт тушаагдсан тэмээний ноосны килограмм тутамд нь 2 мянган төгрөгийн урамшуулалтыг олгоод явж байгаа. Тийм, жилдээ 1900 тонн ноос гардаг. Тэгээд эндээс урамшуулалд тодорхой хэмжээгээр хамрагдаад явж байгаа. Энэ бол 2013 оноос хэрэгжээд явж байгаа ийм журам байгаа. Сүүн дээр урамшуулал олгож байгаа. Бид дотоодын сүүний боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн аргаар бэлтгэсэн сүүний хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор сүүнд урамшуулал олгож байгаа үндэсний үйлдвэрт тушаасан. Энэ дээр ингэний сүүг үндэсний үйлдвэрт тушаасан тохиолдолд.../минут дуусав/

Бейсен: Гишүүд асуулт асууж дууслаа. Бид өнөөдөр сая салбарын сайд маань 2 асуудлаар хамтад нь мэдээллээ хийсэн. Би энэ сая сайд ч ярьж байна. Үнэхээр энэ генетикийн үржлийн албаны асуудал үнэхээр орхигдсон асуудал байгаа улсын хэмжээнд. Тийм учраас энэ асуудлыг бид эрдэмтдийн зөвлөлийг хүрээлэнгийнхнийг нэгтгэж байгаад хэлэлцүүлэг хийх нь зүйтэй юм байна. Бас гишүүдээс санал ирсэн байгаа. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.5 дахь заалтад заасан малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах болон Монгол малын генетик нөөцийн төлөв байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар холбогдох мэргэжлийн байгууллагын танилцуулга, мэдээллийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх саналтай байна гэсэн ийм ажлын хэсэг байгуулж өг гэсэн ийм санал ирсэн. Бид сүүлд энэ ажлын хэсэг байгуулаад, санал хураалтаар энэ юуны дараа шийднэ. Тийм учраас энийг үнэхээр үржлийн асуудал орхигдож байгаа асуудал байгаа.

Сая ярьж байна малын өвс, тэжээлтэй холбоотой, бэлчээрийн хомсдолтой холбоотой, цус ойртолттой холбоотой мал давжаарч байна, ашиг шим нь муудаж байгаа асуудлыг ярьж байна. Гэтэл гадаадаас бид эрлийз, үржлийн мал авчирч байна. Эрчимжсэн МАА-г хөгжүүлэх асуудлыг тавьж байна. Гэтэл урьд нь энэ үржлийн алба бол зоотехникийн алба сайн ажиллаж байсан, одоо мэргэжилтнүүд нь хомсдоод, зарим нь өндөр настан тэтгэвэрт гарсан ийм асуудал байгаа. Тийм учраас боловсон хүчний асуудал дээр анхаарах асуудал байгаа. Нөгөө талаар урьд нь энэ үзэмчин үүлдрийн гэх юм уу, керей омгийн эдельбаев гээд зөндөө малын

үүлдэр байсан. Казахын цагаан толгойт гээд байж байна. Гэтэл энэ Монголд орж ирсэн үхэрт Монголын цагаан толгойт гээд яаж байна уу, эрлийз мал гээд байж байна, тэр сорт тогтоосон юм байна уу ер нь? Жишээлбэл адуу гэхэд 25-тай, 50-тай, 75-тай гээд явж байх юм уу? Эрдэмтдийн зөвлөлөөр тэгээд Монгол үүлдрийн тэгээд тийм сорт бий болгох юм уу гэдэг асуудлууд байж байна. Тэрийг тогтоож байгаа юм байна уу 1 дүгээрт? Жишээлбэл хар тарлан үхэр байна, симменталь үхэр байж байна сая герефорт, тэр эрлийзжүүлээд Монгол юуны тийм сорт гаргаж байгаа юм байна уу гэдэг асуудал байж байна.

Дараа нь энэ ямааны асуудал байж байна. 70 онд Буриад, Тувагаас д... оруулж ирчхээд баруун аймгийнхныг ноолуурын микро нь юу болчихсон, тэгэхдээ ашиг шим нь их мөртөө чанар нь муудсан тийм асуудал гарсан. Энэ дээр судалгаа хийж байгаа юм байна уу? Эцэг малын хувьд урьд нь зоотехникийн алба, мал эмнэлгийн үржлийн албаныхан хавар хурга, ишиг юунууд засах үед нь селекц хийгээд энэ эцэг мал болох юм байна гээд селекц хийж байж дараа нь нэг сумаас нөгөө сумд нь эцэг мал хүргүүлэх асуудал байдаг байсан. Энэ уламжлалт арга бол орхигдсон. Энийг хэрэгжүүлэх юм байна уу? Малчид өөрсдөө тийм малаа яагаад л эцэг мал өөрсдөө тавьж байна уу гэдэг асуулт тавьж байна, асууя. Энийг цаашид хэрэгжүүлэх боломж бий юү? Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Бейсен гишүүн дандаа шинжлэх ухааны суурьтай асуудлууд асуугаад байдаг. Яг хариулах хүн нь өнөөдөр Гантөмөр сайдын харьяанд шилжсэн байхгүй юу. Гантөмөр сайд хариулахаар байгаа юм. Үнэхээр тэр малын үржил селекц нь ямар байгаа юм, удмын сан нь ямар байгаа юм, мал, тэр ноос ноолуурын микроны хэмжээ юу болж байгаа юм, ямар бодлого аль бүсдээ, юу үржүүлэх юм, ямар хөрсөндөө юу тарих гээд ер нь үнэхээр энэ салбарын яг аж ахуйн сайд өөрөө энэ талын мэдээлэлгүй, яам өөрөө энэ талын боловсон хүчин байхгүй, тэрийг нь бүгдийг нь салгаад өөр газар өгчихсөн. Тэгээд энийг л нэг засаад өгөөч гэдгийг би Байнгын хороондоо л хүсэлт тавиад байгаа. Энэ дээр та нар маань нэг даацтай нэг ажлын хэсэг гаргаад, энэ хөдөө аж ахуйн салбараа нэг шинжлэх ухаанч болгох, үйлдвэрлэлд нийцсэн хөдөө аж ахуйг хөгжүүлж байж бид мал аж ахуй ч ашигтай, газар тариалан ч ашигтай, экспортын чиг баримжаатай нь ингээд нэг валют олдог, нэг өрсөлдөх чадвартай л аж ахуй, хөдөө аж ахуй чинь бий болно шүү дээ.

30 жил замбараагүй дур зоргоороо явчихлаа. Энэ үржил селекц энэ юмнууд дандаа сайн дурын, санаачилгатай, дур сонирхолтой улсуудын санаачилга дээр л тогтож байна. Ингэж болохгүй л дээ, яагаад ч болохгүй. Энэ чинь их нарийн зүйл шүү дээ, ингээд тэр малын генфонд нэг эвдэрвэл, нэг популяц цөмрөөд доошоо явбал сая тайланд гарлаа шүү дээ. Хэд хэдэн төрлийн социализмын үед бий болгож чадсан нутгийн омгийн үүлдэрүүд үндсэндээ сая бүртгэлээс бүрэн хасагдлаа гэж байна, тоологдсонгүй гэж, ингээд л олсон ололт амжилтыг алдаад эхэлж байгаа байхгүй юу. Үр тариан дээр маш том алдагдлыг хүлээж байна өнөөдрийн байдлаар. Одоо мал аж ахуй дээр олон, олон үүлдэр алдаж эхэлж байна. Яаралтай сайжруулах шаардлагууд байж байдаг. Үнэхээр энийг нь жоохон дэмжээд анхаарвал энэ салбар маш их потенциал байна, боломж байна. Бид 20 орчим хувийг нь л ашиглаж байна, 80 хувийг бүрэн ашиглаж чадахгүй байна. Энийгээ дагаад малчдын орлого чинь нэмэгдэхгүй байна, үйлдвэрлэл чинь босохгүй байна, үр ашигтай байдал нь бага байгаад байна шүү дээ. Боломж байгаад байдаг бид ашигладаггүй. Тэгээд нэг ийм өөрсдөө шийдэх ёстой, энэ Их Хурлын шийдэх ёстой л ажлууд шүү дээ. Бүтэц зохион байгуулалт зөв болгох, бодлогыг нь зөв болгох, тэр хэдэн хууль тогтоомжийг нь зөв болгож ингээд гаргаад, дэмжээд өгвөл их л боломж байх юм.

Б.Бейсен: Хариулах асуудалд бас тиймэрхүү болчихлоо. Тийм учраас бид ер нь Байнгын хорооноос манай ажлын албаныхан Хөдөө аж ахуйн хүрээлэн, Мал аж ахуйн хүрээлэн, Хөдөө аж ахуйн яамтай хамтраад энэ ажлын хэсэг гарах юм байна. Хамтарч байгаад нэг эрдэм шинжилгээний хурал шиг хэлэлцүүлэг хийе. Тэгж байж энэ асуудлыг шийдэхгүй бол болохгүй юм шиг байна.

Дараа нь энэ өнөөдрийн хурлаараа бид ажлын хэсэг байгуулах ёстой саяын гишүүдийн юугаар саналаар. Санал хэлэх гишүүн байна уу, нэрс өгнө үү? Замира гишүүнээр тасаллаа. Энэ ажлын хэсэг байгуулах гэдэг асуудлаар л яаж байна шүү дээ. Мэдээлэл сонссонтой холбогдуулан үг хэлэх гишүүд? Бадамсүрэн гишүүнээр тасалъя. Хэн орохгүй байна Батжаргал гишүүн үү? Батжаргал гишүүн, Мандхай гишүүн оруулъя. Мандхай гишүүн. Ганхүлэг гишүүн үг хэлье.

М.Ганхүлэг: Өнөөдөр зүүн бүсийн гишүүд энэ удаагийн хуралд нэлээн идэвхтэй оролцож байгааг манай Байнгын хорооны гишүүд анзаарсан байх. Зүүн бүсийн гишүүн Идэрбат, Отгонбаяр, мөн Байнгын хорооны гишүүн биш Соронзонболд болон Бадамсүрэн гишүүд бүгдээрээ орж ирээд ингээд ярьж байгаа юм. Тэгээд гишүүд маань болон олон нийт маань энийг ойлгоосой гэж бодоод байгаа юм. Бид ингээд бүтэн сар гаруй ингээд багуудаар манай 3 аймаг 200 гаруй багтай, тэгээд бүгдийг нь алгасахгүйгээр орж уулзалтыг зохион байгуулъя гээд. Тэгээд хамгийн ихиргэдээс гарч байгаа асуудлуудаа хойноос нь хөөцөлдөөд, тэгээд тодорхой үр дүн гаргахын төлөө ажиллая гэдэг ийм зорилготой ажлуудаа эрэмбэлээд ингээд явж байгаа юм. Түүний нэг нь үндсэндээ энэ залуу малчдын асуудал, залуу уяачдын асуудал, түүнтэй холбогдолтой тодорхой энэ асуудлуудыг шийдвэрлэхтэй холбогдолтой асуудал байна. Сууриараа энэ асуудал нь өөрөө нутгийн энэ шилмэл энэ үүлдэр угсаагаа хамгаалахтай холбогдолтой энэ Генетик нөөцийн хуультай холбогдолтой асуудал байгаа юм. Энэ утгаараа бид бүхэн энэ асуудлыг Байнгын хороогоороо хэлэлцье гэдгийг өнөөдөр хэлэлцлээ.

Нэлээн олон асуудал үүнийг дагаад байгааг өнөөдрийн хурал харуулж байна гэж бодож байгаа юм. Тэгэхээр хэд хэдэн ажлын хэсгүүд байгуулагдаасай гэж бодож байна. Ялангуяа өнөөдрийн хурал дээрээс дүгнэлт хийхэд Монгол үүлдэр омгийн адууны малын удмын үнэлгээг, удам зүйн үнэлгээг үндсэндээ хийхтэй холбогдолтой энэ ажлыг ХХААХҮЯ энэ дээр тодорхой төсөв санхүүгийн тусгах чиглэл дээр анхаарал хандуулаад саналаа оруулж ирээсэй. Монгол үүлдэр омгийн адууны ген, генетик нөөцийн төлөв байдлыг тогтоох, түүнтэй холбогдолтой энэ судалгааг нэг нь генетик нөөцтэй холбогдолтой, нөгөөдөх нь болохоор энэ үүлдэр омгийн удам зүйн үнэлгээг хийхтэй холбогдолтой энэ асуудлуудыг яг эцэслээд шийдвэрлээсэй гэсэн ийм саналтай байгаа юм.

3 дахь нь энэ Генетик нөөцийн тухай хууль дээр заагдсан байгаа тодорхой асуудлаар хяналт үнэлгээ явуулах, тэр дундаа энэ импортын адууг тодорхой хугацаанд хориглохтой холбогдолтой асуудал дээр ажлын хэсэг байгуулан ажиллая гэдэг ийм тодорхой саналтай байгаа юм. Тэгээд эдгээр 3 асуудлыг цаашид нь хэрэгжүүлэх чиглэлээр Байнгын хорооноос тодорхой саналууд гараад ингээд явах нь зөв байна.

Б.Бейсен: Мандхай гишүүн үг хэлье.

М.Мандхай: Ер нь малын яг энэ сэдэвтэй холбоотойгоор малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээг 6 жил хийгээгүй байгааг сонсоход маш

харамсалтай байна. Бид өнөөдөр үнэлгээ хийгээгүй байж энэ тайланг ингээд бид нарт танилцуулж байгаа нь маш учир дутагдалтай тайлан танилцууллаа л гэж дүгнэж байна. Тийм учраас бид яг энэ тайланг хийж байж эндээс чинь гарч байгаа тайлангийн дүгнэлт, үр дүнг түшиглэж байж бид юу сайжруулах, ямар арга хэмжээг авах юм, эрэмбэ дарааллаараа юуг төлөвлөж ажиллах вэ гэдэг яамны өөрөө бодлого байх ёстой. Тэгэхээр Хөдөө аж ахуйн яг үндсэндээ яамны зарим нэгэн төлөвлөгөө өөрөө яг цогц, аль нэг дэд салбаруудыг орхихгүй ажилладаг байгаач гэж хэлмээр байгаа юм.

Түрүүн хэллээ л дээ. Газар тариалангийн үрийн сантай гэсэн мөртөө бид чинь энэ чинь 298,3 мянган малчинтай, 57 сая малтай улс шүү дээ. Мал аж ахуйн салбарынхаа энэ малын генетик фондын асуудлыг бид нэг номерт тавих ёсгүй байсан юм уу. Тэгээд энэ эрэмбэ дараа чинь яаж яваад байгаа юм бэ? 20 тэрбум төгрөгийн асуудалгүй учраас гээд зүгээр ерөнхийдөө ач холбогдолгүй гэдгээр нь хаячихсан байгаа. Бид тэр байтугай тэрбум төгрөг зарцуулж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ чинь юун эрэмбэ дараа нь чухал юм бэ гэдгийг, үгүй ээ, үгүй сайд аа, тэгэхдээ бас та хэлж байгаа бид нарын саналыг авах ёстой байхгүй юу. Зүгээр ингээд юу гэдэг юм эсэргүүцэх байр суурьтай биш, энэ чинь бодитой л юм ярьж байна шүү дээ би энэ тайлан дээр. Угаасаа 6 жил хийгдээгүй тайлан өнөөдөр энэ санал чинь бол бас л учир дутагдалтай орж ирж байгаа нь үнэн шүү дээ. Бид энэ гений фондыг сайжруулах, энэ малын ашиг шим, яаж энэ үүлдэр угсаагаа сайжруулах юм, одоо ялангуяа би хэллээ шүү дээ түрүүн санал. Энэ мал үржлийн хувийн аж ахуйн санхүүгийн ямар дэмжлэгүүд байж болох юм, одоо энэ хэрэгжиж байгаа Шинэ хоршоо олон энэ зээл санхүү, жижиг, дунд үйлдвэрлэлд өгч байгаа санхүүжилтээ тэгвэл бодлогоороо сайн үржлийн малыг олгох ч гэдэг юм уу ингээд бодлогоор бид төлөвлөгөө гаргаад хэрэгжүүлэх боломж байгаа шүү дээ тийм биз дээ? Байхгүй гээд суухын оронд байгаа юман дээрээ бид яаж энийгээ өсөж хөгжүүлэх вэ гэдэг дээр л ярих нь ач холбогдолтой. Тэгэхлээр энэ дээр бид шаардлагатай бол ажлын хэсэг гаргаад, энэ дээр нь бүр энэ төлөв байдлын үнэлгээг дахиж нэг шинэчилж хийгээд, энэ тайлангийн үнэлгээ дээр түшиглэж байж бид энэ генетик нөөцийн асуудлыг яаж сайжруулах вэ гэдэг дээр нь ажиллах саналтай байна.

Б.Бейсен: Замира гишүүн үг хэлье.

С.Замира: Баярлалаа. Монгол Улсын хөдөө аж ахуйн салбар бол Монгол Улсын амьжиргааны гол үндэс нь. Мал төллөлт бол зөвхөн улирлын чанартай үзэгдэл биш, харин салбарын цаашдын бүтээмж, тогтвортой байдлыг тодорхойлдог стратегийн ач холбогдолтой салбар. Тийм учраас хэд хэдэн санал хэлмээр байна.

1 дүгээрт мал сүргийн чанарыг сайжруулах үржлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх хэрэгтэй байна. 2 дугаарт бүсчилсэн, байгаль цаг уурын онцлогт тохирсон төлөвлөлт, эрсдэлийн менежментийн үйл ажиллагааг давхар явуулах хэрэгтэй. Тэгээд орон нутгийн, засаг захиргааны чадавх, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах хэрэгтэй. 4 дүгээрт мал эмнэлгийн асуудалд онцгой анхаарах, анхаарахгүй бол болохгүй байна. Хүртээмжтэй болох хэрэгтэй. Малын эмч, зоотехникч, хүний нөөцийн асуудалд онцгой анхаарч, хүртээмжтэй болгох хэрэгтэй байна даа. Малчдад ер нь малын эмч, зоотехникч гээд маш дутмаг байгаа гэдгийг удаа дараа, сая өөрөө ч ярьж байна. Энэ дээр засаг төр онцгой анхаарал тавих нь зүйтэй байх гээд бодож байна. Баярлалаа, амжилт хүсье.

Б.Бейсен: Сэддорж гишүүн үг хэлье.

Р.Сэддорж: Түрүүн асуусан асуултынхаа дагуу яг тэмээний ноос, сүүн дээр та бүхэн маань ямар урамшууллууд олгодог юм, ямар аймгууд, аль, аль аймгаар нь жагсаагаад надад нэг мэдээлэл өгөөч цаасаар ноос, сүүн дээр. Тэмээний ноос, сүүний асуудал энэ говьчуудын хувьд асар чухал асуудал байгаа. Тэгээд энэ дээр та бүхэн маань яаж дэмжиж ажиллаж байгаагаа хэлнэ үү, бичгээр өгнө үү.

Дараагийн асуудал тэмээ судлаачдыг та бүхэн маань дэмжээд өгөөч. Бид бол аймгууд дэмжиж л байгаа байх. Тэгээд яамны зүгээс тодорхой дэмжээд, энэ генфондын судалгаа эд нарыг ямар түвшинд аваачих вэ гэдэг дээрээ та бүхэн маань нэг ажил зохион байгуулаач. Тэмээний уралдааныг сайд дэмжье, дэмжиж тэр цол хэргэмийг ЗГ-ын түвшинд, Ерөнхийлөгчийн түвшинд аваачих талаар ажиллая гэж сая хэллээ. Тэгээд та бүхэн маань энийг дэмжиж, тэр хуулийн өөрчлөлтүүд орж байгаа байх түүн дээр дэмжиж ажиллаач гэдгийг хэлье. Мөн дэлхийн тэмээний уралдааны холбоод, Азийн холбоодтой та бүхэн маань хамтарч дэмжиж ажиллаач. Төрийн зүгээс тэр улсууд Саудын Араб, Арабын Нэгдсэн Эмират Улсууд руу дэмжсэн бичиг явуулж өгөөч гэдгийг хэлье.

Б.Бейсен: Батжаргал гишүүн үг хэлье.

Ж.Батжаргал: Мэдээлэл зөндөө сонсчихлоо. Манай гишүүд олон талаас нь ярьчихлаа. 2-хон зүйл байна 1 дүгээрт энэ малын үүлдэр угсааг сайжруулахтай холбоотой ажлыг бид нэлээн далайцыг нь өргөжүүлмээр байгаад байгаа юм. Дан дамаа тэр малын удмын сан дээр байж байгаа тэр үрийн банк гэдэг юмыг нэлээн сайжруулах хэрэгтэй байна. Цөм сүргийнхээ асуудлыг энэ дээрээ давхар яримаар байна. Тэгж байж энэ мал аж ахуйн салбарын үр ашгийг дээшлүүлэх тухай асуудал байна гэж.

Дараагийн зүйл энэ мал аж ахуйн салбарыг өөрийг нь жоохон шинжлэх ухаанч, нэг тодорхой судалгаа хөгжүүлэлт дээр тулгуурлаж явуулах тухай асуудал байгаад байгаа юм. Ер нь энэ аж ахуйн яаманд нь тэр эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийг нь өгөх асуудлыг шийдэх хэрэгтэй бид. Энэ Эдийн засгийн хөгжлийн яаман дээр хэдэн хүрээлэнгүүдээ татаад авчихсан. Зүгээр л нэг амьдрах төдий зардалтай, ямар ч захиалгат судалгааны гэдэг юм уу, хөгжүүлэлтийн төслүүд, юу төсвүүд байхгүй. Тэгээд нэг ийм үлгэн салган хүрээлэнгүүд яваад байх хэрэг байгаа юм уу даа. Үнэхээрийн энэ хөдөө аж ахуйн салбар өөрөө байгаль цаг уурынхаа хамааралтай бас эрсдэлтэй салбар. Тэгвэл үүнийг жоохон үр ашигтай, энэ салбарт ажиллагсад нэг бодит орлоготой, амьдралын чанартай байлгая гэвэл эрхэлж байгаа аж ахуйг нь өөрийг нь байгаль цаг уур дээрээ ч тэр, гаргаж ирж байгаа ашиг шим, түүхий эдийн боловсруулалт, үнэ цэний асуудал ч тэр тодорхой судалгаа тооцоолол, технологи дээр тулгуурладаг байх тухай асуудал байгаад байна л даа.

Тийм үүднээс би энэ мал аж ахуй эрдэм шинжилгээний хүрээлэн ч гэдэг юм уу, тэр газар тариалангийн, ургамал, газар тариалангийн хүрээлэн ч гэдэг юм уу, ургамал хамгааллын хүрээлэн ч гэдэг юм уу энэ байгууллагуудыг нь ер нь энэ яаманд нь өгөх талын асуудлыг судалж, Байнгын хороо тогтоол гаргаж өгөх хэрэгтэй. Тэгээд тэрнийхээ дагуу тэр ЗГ судалгаа тооцооллоо хийж, бүтцээ зөв болгох талын асуудал руугаа явахгүй бол ер нь бараг үндсэндээ сүүлийн хэдэн жил ч болж байгаа юм энэ асуудал яригдаад, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд байхаараа сайд нь манайд хэрэгтэй хүрээлэн гээд дайраад байдаг. Одоо энд яваад ирчихсэн бүүр холдоод яваад өгч байгаа байхгүй юу энэ чинь нөгөө сургалтын байгууллагаасаа холдоод явчхаж байна шүү дээ. Тэнд байхад хүрээлэн, сургалтын

байгууллагын хамтын ажиллагаа, тэгээд түүний хөгжүүлэлтийн асуудал гэдэг нэрийн дор яриад яваад байдаг байсан бол одоо энд ер нь ямархуу байдлаар энэ үйл ажиллагаа чинь явах юм бэ гээд бодмоор зүйлүүд байна.

Дараагийн нэг зүйл нь энэ залуучуудын гаргаж ирж байгаа манай гишүүдийн тэр ажлын хэсгийг дэмжье. Гэхдээ бид юм дэмжихэд учир байгаад байгаа юм. Яагаад Төрийн баяр наадмын тухай хуульд сумдын баяр наадмыг нэг өдөр хийхээр хуульчилсан бэ. Гэтэл манай Их Хурлын гишүүдээс үүдээд энэ болохоо байчхаад байгаа байхгүй юу. Өөр өөрийнхөө аймаг гэдэг юм уу, сумдад наадмуудыг өөр өдөр хийлгээд үймүүлээд болж өгөхгүй байгаа юм яг үнэнийг хэлэхэд. Уг нь сум болгон нэг өдөр хийвэл улс янз бүрийн наадмуудтайгаа давхцаад тухайн орон нутгийн иргэд нь нутаг орондоо уралдах, өнөө жинхэнэ хөх уяачид гэж хэлээд байгаа улс чинь тэр сум, орон нутагтаа баяр наадмаа хийж наадах бололцоог нь бүрдүүлж өгч байгаа юм. Үүний утга учрыг ойлгож, энэ Баяр наадмын хуулиа нэг мөр хэрэгжүүлмээр байна 1.

2 дугаарт энэ адуу эрлийзжээд, эрлийзжүүлэх сонирхол яваад байгаа чинь энэ наадмуудыг өөр өдөр хийгээд байгаатай холбоотой. Нэг хэсэг хөрөнгөө, цагаа зарцуулаад адуугаа сайжруулчихсан улсууд болж байгаа наадам болгон дээр очиж уралдаад айраг түрүүг нь авчхаад.../минут дуусав/

Б.Бейсен: Бадамсүрэн гишүүн үг хэлье.

М.Бадамсүрэн: Байнгын хорооны гишүүдийн асуулт, саналаас үзэхэд энэ ер нь импортын үржлийн цэвэр азарга, гүү гэдэг юм уу энийг тодорхой хугацаанд хориглохтой холбоотой асуудлыг дэмжиж байгаа гэдэг нь харагдаж байна. Тэгээд энд их баяртай байна. Яагаад гэхээр энэ бол Монголчуудын өв соёл, төрийн сүлдэндээ залсан энэ адууны соёлыг хойч үедээ зөв үлдээх энэ их том агуулгаараа их том асуудал л даа. Тэгэхээр энэ зүйлийг цаашид илүү тийм оновчтой шийдвэр гаргах талаар бүгд дэмжиж байгаад баярлалаа.

Дараагийнх нь энэ малын удмын санг хамгаалахтай холбоотой ер нь бидэнд цаашдаа хийх хамгийн том тулгамдах асуудал энэ бэлчээрийн хүрэлцээ, бэлчээрийн талхагдал. Тэгээд энэ дэлхийн дулааралтай холбоотой, цаг агаарын өөрчлөлттэй холбоотой урд талаасаа эхлээд цөлжилт их хэмжээгээр явж байгаа. Энд нөлөөлж байгаа хүчин зүйл буюу хүний хүчин зүйлийг шинжлэх ухаанчаар хандаж өөрчлөх боломжууд байна. Тухайлбал өвөлжөө, хаваржааны доорх газар гүний худгийн цооногийн хоорондын зайн доод хэмжээг бид хууль тогтоомжоор тогтоож өгөхгүй бол хаяа хаяагаа дэрлээд өвөлжөө, хаваржааны газар олгодог, тэгээд өвөлжөө, хаваржааны доорх газартай юм чинь энэ орчмын бэлчээрийг би эзэмшинэ гэдэг, ашиглана гэдэг, гүний худгийнхаа орчмыг бид ашиглана гэдэг. Тэгээд энэнээс болоод энэ талхагдал үүсээд байгаа юм. Өмнөх социалист нийгмийн үед энд шинжлэх ухаанчаар ханддаг байсан шүү дээ. Доод талын зай ойролцоогоор 5км гээд тогтоосон. Тэгээд энэ мэтчилнээр ингээд бидний зүгээс зохицуулах ийм шаардлага байна. Хууль тогтоомжийн хүрээнд болон бусад зохион байгуулалтын хэлбэрээр.

Мөн аварга малчдын тоог оновчтой тогтоохгүй бол энэ арай их байна. Яг үнэндээ. Одоо нээрээ сүүлдээ бараг энэ чинь энэ шагнал бол нээрээ арай болохоо болилоо. Би бол ямар тодорхой санал дэвшүүлж байна гэхээр аварга малчны тоог эрс цөөлөөд, харин өгч байгаа шагнал нь өөрөө үнэ цэнтэй. Тэр нь ийм бусад хүндээ үлгэр дуурайлал болохоор. Одоо нэг Монгол гэр өгдөг уламжлалаараа явж байгаа.

Миний санал хамгийн сайн аварга малчинд нь ийм битүү стандарт тийм хашаа барьж өгдөг. Тэгээд аварга малчныхаар ороод хүмүүс харахдаа аварга малчин хүн чинь аварга бол ийм хашаатай байдаг юм байна гээд энэ малынхаа тав тухтай байдлыг хангах, эрсдэлээс хамгаалах эсвэл ковш трактор шагналд нь өгдөг юм уу гэх мэтчилнээр ийм нэг ийм жишиг болсон ийм зүйлүүдийг нэвтрүүлмээр байгаа юм. Энэ дээрээ харин тодорхой хөрөнгө батлаад, тэгээд ингэж явахгүй бол энэ арай жоохон болохгүй болоод байна. Бид ер нь юманд жоохон тийм нэг хэм хэмжээтэй, цаг үедээ нийцүүлж ингээд арай өөрөөр хандахгүй бол энэ хөдөө аж ахуйн салбар үндсэндээ Монголчуудын хамгийн чаддаг уламжлалт аж ахуйн салбар. Мал аж ахуй, газар тариалан 2. Энэ 2-ын хослох хөгжихтэй холбоотой асуудлыг салбарын сайд дэвшүүлж байна. Энэтэй санал нэг байна. Цаашдаа бэлчээр хамгаалахаас гадна энэ тэжээлийн ургамал тариалах, энэ дээр илүү эрчимжсэн, хагас эрчимжсэн, хосолсон хэлбэрээр явуулах гээд энэ дээр хувийн хэвшил хэдий мал сүрэг хувийн өмч хэдий ч төр тодорхой шинжлэх ухааны байгууллагаар дамжуулж ийм зөвлөмжөөр хангадаг. Тэгээд энийг нь ингээд урамшууллын, шагналын тогтолцоогоо уялдуулдаг ийм хэлбэрээр явах хэрэгтэй байна.

Хамгийн сүүлийнх нь энэ адуунаас бүртгэлийн системээ эхлүүлбэл энэ үхрээс эхэлснээс илүү шүү. Яагаад гэвэл Монголчууд намар унагаа тамгалдаг ухаандаа хөрөнгөө тоолж байна гэсэн үг намартаа нэг удаа. Бүгд унагаа тамгалдаг. Тэгэхээр энэ бол адуу гэдэг өөрөө азарга гэдэг амьтан чинь ингээд адуугаа өөрөө хямгадаад явдаг шүү дээ. Тэгэхээр энэ бол хамгийн боломжтой. Эндээсээ эхэлбэл их зөв.

Б.Бейсен: Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Байнгын хорооныхоо дарга, гишүүддээ их баярлалаа. Ойрхон, ойрхон манай салбарын юмыг сонсоод, ер нь бид ч их хичээж энэ бололцоог ашиглаж мэдээлэл ахиу өгөх гэж хичээж байгаа. Надад, бидэнд юу хэрэгтэй гэвэл энэ салбар үнэхээр боломж нөөц байна, жоохон санхүү, бодлогыг нь дэмжих хэрэгтэй. Тэгэхээр ажлын хэсэг гаргаад, Байнгын хорооны тогтоолуудаар л намайг зэвсэглээд байвал би тэрийг чинь очоод нөгөө Хөгжлийн яамтайгаа тулна, Сангийн яамтайгаа тулна. Энд бид мянган гоё юм яриад бүх хөтөлбөрүүд тэнд очоод хасагддаг. Сая 26 оны улс орныг хөгжүүлэх тэр эдийн засгийн бодлогоос манайхаас 19 заалт яг тулгуур, тулгуур 19 заалтыг хасаад хаячхаж байгаа юм. Одоо тэр нь Сангийн яам дээр очно ахиад хэд нь хасагдана гээд. Ингээд нөгөө салбарын бодлого чинь цогц биш ингээд, овоо явж байсан юм чинь гэнэт, гэнэт ийм савлагаанд ороод байхаар тогтвортой байдал, хөгжлийн бодлого ярихад амаргүй л болоод байгаа юм.

Тэгэхээр та бүхэн саяын адууны асуудлыг гоё шийдчихмээр байна бүгдээрээ. Малынхаа үржил селекцийн асуудлыг нэг талд нь гаргаад шийдчихмээр байна. Ингээд хамтраад Ажлын хэсэг гаргаад шийдээд, шийдээд яваад, дүгнэлт гаргаад байвал салбарт их дэм болох юм байна. Би бол энэ Байнгын хороогоо дандаа дэм туслалцаа, боломж гэж ойлгож хараад, хандаад байгаа юм. Тэгээд иж бүрнээр нь энэ салбарыг нэг цогц болгоод, шинжлэх ухаантай болгоод, хүний нөөцөө бэлддэг болгоод ингээд явчихмаар байна. Жишээлбэл батлан хамгаалах салбар хүний нөөцөө яг өөрөө барьдаг байхгүй юу. Захиалж бэлдээд л, сургууль төгсөхөд нь тангараг өргөөд л офицерын погон зүүж өгөөд л, тушаал гардуулна. Та тэр ангид, тийм мэргэжлээр томилогдоно гэж. Ийм л байдаг байсан, хуучин манай хөдөө аж ахуйн салбар чинь Монголын хамгийн олон эрдэмтэнтэй, хамгийн олон лабораторитой, хамгийн олон хүрээлэнтэй, хамгийн сайн бэлтгэсэн боловсон

хүчинтэй, гайхагдаж байсан хөдөө аж ахуй шүү дээ. Тэгээд ийм болчих гэж. Тэгээд ерөөсөө тийм систем ингээд алдагдчихсан. Энийг нэг цогц болгоод, том ажлын хэсэг гаргаж дүгнээд, эрдэмтдийнхээ үгийг нэг сонсоод хөдөө аж ахуйн салбарын чиглэлээр ингээд бүгдээрээ ажиллаадахвал үр дүн гарах байх гэж итгэж байна. Баярлалаа.

Б.Бейсен: Гишүүд үг хэлж дууслаа. Салбарын сайдын хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой мэдээллийг сонссон. Энэтэй холбогдуулаад ажлын хэсэг байгуулах гишүүдийн саналын дагуу Ажлын хэсэг байгуулах Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн БОХХАА-н байнгын хорооноос тогтоох нь:

1.Малын генетикийн нөөцийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, Монгол үүлдрийн омгийн адууны удмын санг хамгаалах асуудлыг судалж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Ажлын хэсгийн ахлагчаар М.Ганхүлэг, гишүүдэд Монгол Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатар, Сонгобайн Замира, Ухнаагийн Отгонбаяр, М.Бадамсүрэн гээд ийм 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулах гэж байна.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулахыг ажлын хэсгийн Ганхүлэгт зөвшөөрсүгэй.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны Бейсенд даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байна. Тогтоолын төслөө батлах уу? Тогтоолын төслөө баталъя. Нээлттэй хураачих юм байна. Санал хураалт. 11 гишүүн дэмжиж, тогтоолын төсөл 64,7 хувьтай батлагдлаа.

19.02 цаг

Гурав.2025 оны хаврын мал төллөлтийн дүн, мэдээний талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох

3 дахь асуудал дээр түрүүн мэдээллийг нь сайд хийчихсэн. Мал төллөлтийн дүн мэдээний талаар сайдын мэдээлэлтэй холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт байхгүй юм байна. Үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна.

19.02

Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Байнгын хорооны гишүүд, ажлын хэсгийнхэнд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА